



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОН 03 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-73

<i>1.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг</i>	13-33
<i>2.“Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	33-38
<i>3.“Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	38-47
<i>4.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Мал сүргийн хаваржилт, хаврын тариалалтын бэлтгэл хангах, нөөцийн мах худалдаалах арга хэмжээний талаар/</i>	48-73

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
03 дугаар сарын 17-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 06 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Г.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Г.Тэмүүлэн;

Чөлөөтэй: Ж.Батжаргал, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ, Ж.Мөнхбат, Ц.Мөнх-Оргил, Ш.Раднаасэд;

Тасалсан: Д.Бат-Эрдэнэ, Б.Жавхлан, Д.Өнөрболор;

Хоцорсон: С.Батболд-1 цаг 23 минут, Х.Болорчулуун-2 цаг 35 минут, Д.Ганбат-10 минут, Х.Ганхуяг-57 минут, Д.Сарангэрэл-19 минут, Б.Саранчимэг-2 цаг 16 минут, Н.Учрал-19 минут, Б.Чойжилсүрэн-16 минут, Л.Энх-Амгалан-1 цаг 27 минут, Ж.Эрдэнэбат-53 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адьяа, Ж.Батсуурь нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адьяа, Ж.Батсуурь нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол цэргийн баярын өдрийн мэндчилгээ дэвшүүлэв. Мөн төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнээс Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж, 2021.11.24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг татан авч байгаа тухай болон Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж, 2022.06.17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл, Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг татан авч байгаа тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Нэг.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга О.Машбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хориг болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Д.Ганбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Ш.Адъяаа, Ц.Даваасүрэн, Н.Ганибал, О.Цогтгэрэл, Ж.Батсуурь, Б.Баярсайхан, Ц.Сандаг-Очир, Н.Энхболд, Д.Ганбат, Г.Дамдинням нар үг хэлэв.

Г.Занданшатар: Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	41
Татгалзсан:	5
Бүгд:	46

89.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:45/

Уг асуудлыг 11 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Г.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн түр хорооны дарга Э.Бат-Амгалан нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Н.Ганибал нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа нар хариулж, тайлбар хийв.

“Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийн соёрхон батлах тухай асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т заасны дагуу “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт эцэслэн батлах санал хураалтыг явуулахаар түр хойшлуулав. /12:02/

Уг асуудлыг 12 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайд хөгжлийн С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Г.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн түр хорооны дарга Э.Бат-Амгалан нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Д.Тогтохсүрэн, Г.Ганболд, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Г.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

“Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийн соёрхон батлах тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Н.Ганибал ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./12:38/

Уг асуудлыг 12 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 32 минут үргэлжилж, 12 цаг 38 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 06 минутад эхлэв.

Дөрөв.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Мал сүргийн хаваржилт, хаврын тариалалтын бэлтгэл хангах, нөөцийн мах худалдаалах арга хэмжээний талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын даргын албан үүрийг түр орлон гүйцэтгэгч Т.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ж.Монголжингоо нар байлцав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун Мал сүргийн хаваржилт, хаврын тариалалтын бэлтгэл хангах, нөөцийн мах худалдаалах арга хэмжээний талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, О.Цогтгэрэл, Б.Пүрэвдорж, Н.Ганибал нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын даргын албан үүрийг түр орлон гүйцэтгэгч Т.Тунгалаг нар хариулж, тайлбар хийв.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 15 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 19 минут үргэлжилж, 76 гишүүнээс 58 гишүүн хүрэлцэн ирж, 76.3 хувийн ирцтэйгээр 15 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 06 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Энэ гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн байна. Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 4 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, “Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол”-ыг соёрхон батлах асуудал хэлэлцэнэ.

Гуравдугаарт, “Олон улсын иргэний нисэхийн конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Мал сүргийн хаваржилт, хаврын тариалалтын бэлтгэл хангах, нөөцийн мах худалдаалах арга хэмжээний талаар

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20.3-т заасны дагуу хууль, тогтоолын төслөө татан авах тохиолдолд төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагчийн хууль, тогтоолын төсөл татан авах үндэслэлээ тусгасан албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд уншиж танилцуулснаар хууль санаачлагч хууль, тогтоолын төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр албан бичиг ирүүлж, хуулиуд татан авсныг танилцуулъя.

Хуулийн төсөл татан авах тухай, Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Засгийн газрын хуралдааны 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн тэмдэглэлийг хавсаргав гэсэн байна.

Хуралдааны тов хэлсэн байна. Энэ үйлдвэржилтийн асуудлууд их чухал юм даа. Хүнд үйлдвэр, хөнгөн үйлдвэр, үйлдвэржилтийн асуудлуудаа бас хууль, эрх зүйг бүрдүүлэх чиглэлээр Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн энийг анхаарч ажиллаарай.

Дараагийн хууль нь Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж, 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл,

Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ гэсэн байна. Газрын тухай хуулийг татан авчээ.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу гишүүн энэ хуулийн 9.5-д заасан Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлын тов дарааллыг өөрчлөх талаар горимын санал гарах бол Улсын Их Хурлын даргад албан бичгээр өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа албан бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу гишүүд үг хэлнэ.

Хуулийн төсөл татан авах албан бичиг тус тус ирүүлснийг уншиж танилцууллаа. Хуулийн төслүүдийг татан авсанд тооцлоо.

Одоо ингээд үг хэлнэ. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Ширнэнбаньдын Адьшаа, Жамбын Батсуурь нараас тус тус албан бичгүүд ирүүлснийг уншиж танилцуулъя.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Дэгийн тухай хуулийн дагуу 3 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд асуудал нэмэх горимын санал гаргах тул үг хэлэх зөвшөөрөл олгоно уу.

Асуудал нэмэх чинь Байнгын хороогоор хэлэлцсэн байж байж л нэмэх ёстой байдаг юм даа. Үндэслэл дутуу л байна даа. Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Монголынхоо ард түмний энэ өдрийн мэндийг айлтгая. Улсын Их Хурлын гишүүд чуулганы завсарлагаар тойрогтоо ажилласан. Тэгэхлээр энэ ажиллах явцадаа хүүхдийн мөнгийг яг бүрэн дүүрэн олгож байна уу гэдгийг бас иргэдийн хяналтад оруулъя

гэдэг ийм зорилгоор уулзалтууд дээрээ өндөр настай ахмадуудад ирж байгаа, золгож ирж байгаа айлуудын хүүхдүүд хэр зэрэг мөнгө өгөгдсөн бэ гэдгийг бас нэлээн ахмадууд хэлж тэднээс шалгуулсан. Энэний дагуу Ховд аймгийн Чандмань сумын Талын булаг багийн Лувсан-Очир гуай манай суманд 20-иод айлын хүүхдэд л мөнгө өгөөгүй байна гэдэг ийм зүйлийг ярьж байна. Энэ бол тэр 9 хувьдаа багтаж байх шиг байна.

Ховд аймгийн Булган сумын Галт багийн иргэн Нямаа гуай манайд 10 айл ирсэн. Тэрний хэд 3 нь хүүхдийн мөнгө аваагүй байна гэсэн ийм хариу өглөө. Ховд аймгийн Үенч сумын Цагаантуг багийн Бадрах гуай манайд ирсэн хүүхдүүд бүгд хүүхдийн мөнгөө авсан байна гэж хэлж байна. Ховд аймгийн Алтай сумын Алтангадас багийн өндөр настан Баярхүү гуай утас нь хаалттай мэдээлэл авч чадсангүй. Ховд аймгийн Зэрэг сумын өндөр настан Цогоо гуай суманд ер нь гайгүй хамрагдсан юм шиг байна гэсэн ийм хариу өгч байна. Ховд аймгийн Жаргалант сумын Магсаржав багийн өндөр настан Магсархүү гуай манайд 29 хүүхэд ирсэн. 11 хүүхэд нь хүүхдийн мөнгө аваагүй гэдэг ийм мэдээллийг өгч байна.

Би бас зөвхөн Ховд аймаг дээр явдаггүй, бусад аймгуудаар явж иргэдтэй уулзалт хийдэг. Энэ хүрээндээ Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн иргэдтэй уулзалт хийсэн. Сэлэнгэ аймгийн Сайхан сум буюу Хөтөл тосгоны иргэн Бүжээ эгч манайд 39 хүүхэд ирсэн. 3 айлын 6 хүүхэд мөнгө аваагүй байна гэсэн ийм мэдээллийг өглөө. Тэгээд яг энэ хүүхдийн мөнгөний асуудлыг шийдсэн Сангийн сайдын сонгогдсон тойрог буюу Дархан-Уул аймгийн Шарынгол багийн өндөр настан, сэргийлэхийн дарга хийж явж байсан, насаараа хурандаа цол хүртлээ сэргийлэхэд ажилласан Бямбаа гуай манайд 8 хүүхэд ирсэн. Тэрний 6 нь хүүхдийн мөнгө аваагүй. Тэгээд тэр хүүхдүүд нь яагаад аваагүй юм гэсэн чинь байр, хашаатай, машинтай бас аав нь Тавантолгойд тээвэр хийдэг гэдэг ийм

шалтгаанаар энэ 8 хүүхдээс 6-г нь хассан байна. Тэгээд хүүхэд болгоноо баярлуулмаар байна гэж хэлж өгөөч гэдэг ийм зүйлийг хэлж байна.

Тэгэхээр ер нь энэ хүүхдийн мөнгийг энэ судалгаанаас ингээд харахад бол 25 орчим хувь нь ялангуяа төв суурин газар руу орж ирэх дээр энэ хүүхдийн мөнгийг өгөхгүй байх ийм хандлага гарч байна.

Ялангуяа Монголчууд хоорондоо нэг орц руу ороод нэг нэг хаалга руу очдог, нэг нэг хашаанд очоод нөгөө айл руугаа ордоггүй, хоорондоо мэдээллээ дамжуулдаггүй энэ нөхцөл байдлыг ингэж ашиглаж бас энэ 9 хувьд өгөхгүйгээр илүү өндөр хувиар хүүхдийн мөнгө өгөхгүй байгаа ийм тохиолдол бас харагдаад байх шиг байгаа юм.

Тийм учраас энэ дээрээ маш нарийн сайн тооцоо судалгаа хийхгүй бол ялангуяа энэ өргөн хэрэглээний барааны үнэ өсчихсөн, хүнсний үнэ дахин өсчихсөн ийм үед энэ эдийн засгийн нөхцөл байдал маш их хүндэрч байна. Айл өрхийн орлого бас маш их багасаж байна. Дундаж давхар ерөөсөө бараг байхгүй болж байна. Эдийн засаг, хямрал нь хямралаас бас бүрэн гараагүй ийм нөхцөл байдалтай байж байна. Эдийн засаг 4.5 хувиар өссөн гэж та нар яриад байгаа боловч наадхаа доллароор бодоод үзэх юм бол төгрөг 20 хувиар суларчихсан байгаа шүү дээ. Тэгээд доллартоо шилжүүлээд үзэх юм бол юны ч өсөлт байхгүй байгаа шүү. Эдийн засаг нь өсдөггүй ийм нөхцөл байдалд энэ Монгол орныг энэ 7 жилийн хугацаанд та бүхэн ингээд удирдаж явж байна.

Тийм учраас ард иргэдийн орлогыг нэмэгдүүлэх ялангуяа төрөөс өгч байгаа тэр хүүхдийн мөнгийг баян айлын хүүхэд ч адилхан, ядуу айлын хүүхэд ч гэсэн адилхан л тэр хүүхэд чинь л хүүхэд шүү дээ. Тийм учраас тэр хүмүүсийн хүүхдүүдийг нэг угаалгын машинтай аль эсвэл хашаатай гэдэг ийм шалтгаанаар энэ хүүхдийн мөнгөнөөс хасна гэдэг

ерөөсөө байж болохгүй зүйл юм. Тийм учраас энэ иргэдээ бодсон хүүхэд болгондоо яг тэр Бямбаа гуайн хэлдэгчлэн хүүхэд болгоноо баярлуулсан тэр шийдвэрийг энэ чуулган гараач ээ, энэ Их Хурал гаргаач гэдэг ийм хүсэлтийг тавьж байна шүү. Сангийн сайд анхаараарай.

Г.Занданшатар: Тэгэхдээ Улсын Их Хурлын төсөв батлагдсантай холбогдуулан баталсан тогтоолд бол хүсэлт гаргасан хүүхэд бүрд олгох гэж байгаа шүү дээ. Хүсэлт гаргасан хүүхэд болгонд өгөхөөр заасан. Хүсэлт гаргаад байхад нь өгөхгүй байгаа бол Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэрэгжихгүй байна гэсэн үг. Бат-Амгалан гишүүн.

Одоо Ширнэнбаньдын Адьшаа гишүүн үг хэлэх хүсэлт ирүүлсэн байна. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлнэ гэсэн байна.

Ш.Адьшаа: Та бүгдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Энэ намрын чуулган өндөрлөж бид өнөөдөр орон нутгаар явж, ард иргэдтэйгээ уулзаж, тэдний санал бодлыг сонссон. Энэ ард иргэдийн санал бодлыг бид төлөөллийн хувьд өнөөдөр энэ Улсын Их Хурлын түвшинд хэлж, ярих шаардлага гарсан байна.

Хаврын чуулган эхэлж, улс оронд тулгамдсан олон асуудлуудыг өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцэх гэж байгаа. Бид бол энэ сүүлийн жил гаруй хугацаанд шударга ёс, төрийн албаны ёс зүй, гэмт хэргийн тухай л асуудал ярьдаг болсон. Энэ ярихаас өөр аргагүй ийм 30 жилийн булхай луйвар илэрч, энд ард түмний дургүйцэл нийгмийн эсэргүүцэлтэй бид тулгарсан. Энийг ярих ёстой, шийдэх ч ёстой.

Гэтэл өнөөдөр энэний хажуугаар хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн урд хожид байхгүйгээр нэмэгдэж, ард түмний амьдрал ямар байдалтай болсныг бид өнөөдөр харж,

энд дүгнэлт хийж төрийн эрх барих дээд байгууллагын хувьд энийг яаралтай хэлэлцэж, шийдвэр гаргаж явах ёстой гэсэн ийм байр суурины үүднээс өнөөдөр би энэ чуулган дээр үг хэлж байгаа юм.

Ялангуяа нийслэлээс алслагдсан баруун бүс нутаг нутагт цалин хөлс амьжиргааны наад захын түвшин хангаж чадахгүй байна. Төрийн жирийн албан хаагчид, тэтгэврийнхэн, урлаг соёлынхон энэ үнийн өсөлт, энэ эдийн засгийн хямралын нэрмээс болж байна. Энд бид нар энэ асуудлыг шийдэх ёстой. Хугацаа алдалгүй шийдэх ёстой. Энийг Засгийн газартайгаа хамтарч энэ Улсын Их Хурал нэн яаралтай хэлэлцэж шийдэх ёстой гэж бодож байна. Энэ бол өнөөдөр нийгмийн захиалга болсон асуудал. Өнөөдөр урлаг соёлын байгууллагынхан тэтгэврийн доод хэмжээгээр цалин авдаг. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх цалин авдаг.

Гэтэл өнөөдөр энэ урлаг соёлын байгууллага болсон энэ хүмүүсийн асуудлыг энэ хариуцсан яам, Засгийн газар нь яагаад орхигдуулж байна? Энэ дээр өнөөдөр энэ хөдөө орон нутгаас сонгогдсон болон энэ Улаанбаатараас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд бүгд мэдэж байгаа. Энэ дээр Улсын Их Хурал Засгийн газарт чиглэл өгч, энэ асуудлыг яаралтай оруулж өгөх шаардлагатай байна. Сүүлийн 2 жил гаруй хугацаанд хил, гааль хаагдсаны улмаас бараа таваарын үнэ урд хожид байгаагүйгээр нэмэгдсэн. Манайх бол зөвхөн импортоос хамааралтай эдийн засагтай улс. Гэтэл өнөөдөр хил, гааль нээгдэж, тээвэр ложистик, худалдааны эргэлт бол сайжирсан ийм мэдээлэл байхад тээвэр ложистикийн үнэ төдийлөн буурахгүй байна.

Түүнчлэн өнөөдөр хил, гааль нээгдэж өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн Монголын зах зээлд орж ирж байхад энэ үнийн хөөргөдөл чинь хэвээрээ байна. Энд энэ Улсын Их Хурал дүгнэлт хийхгүй юм уу? Засгийн газраа

шахаж шаардаж энд энэ асуудлын талаар зохих ёсны арга хэмжээ авах ийм цаг болсон байна шүү. Энэ Засгийн газар, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага гээд өнөөдөр энэ үнийн өсөлттэй холбоотой асуудлыг шийддэг ийм байгууллагаа бид шахаж шаардаж, энийг Улсын Их Хурал дээр яаралтай хэлэлцэж, зохих ёсны шийдвэр гаргая.

Ингэж ажиллахгүй бол энэ ард иргэд чинь, хөдөөгийнхөн ч төдийгүй энэ Монголд байгаа энэ хүмүүс чинь үнийн дарамт, эдийн засгийн хямралаас сөхөрсөн байна. Өлөн зэлмүүн амьдарч байна. Өөрийгөө яая гэж байна. Ийм нөхцөлд бид яах юм. Монголын төр энд шийдвэр гаргах ёстой. Энэ дээр бол энэ Засгийн газартайгаа Улсын Их Хуралд яаралтай энэ асуудлыг хугацаа харгалзахгүйгээр, дараалал харгалзахгүйгээр хэлэлцэж.../минут дуусав./

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгож өгнө үү гэсэн бичиг ирүүлсэн байна. Ингээд Жамбын Батсуурь гишүүн үг хэлнэ.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. 2 сар орчим бүх гишүүд тойрогтоо ажиллаж, Монгол Улсын 4 зүг, 8 зовхист ард иргэдийнхээ санал бодлыг бүгдээрээ сонсож, нөхцөл байдлыг нь бодитоор мэдэрч ирсэн байх гэж ингэж бодож байна. Миний явсан тойрог, ард иргэд бол өнөөгийн эрх баригчдын үйл ажиллагаа, өнөөгийн Их Хурлын үйл ажиллагаанд туйлын сэтгэл ханамжгүй, нэн сэтгэл ханамжгүй ийм үйлдэл байна. Тэгээд нэгэн зүйлийг хаврын чуулганы нээлт хурал дээр зориуд хэлж өгөөч гэсэн ийм саналыг маш олон хүмүүс хэлж, ярьж байна.

Учир юу вэ гэхлээр өнөөгийн эрх баригчдын санах ой нь байхгүй

болчихсон юм биш байгаа. Зарим зүйлүүдийг бас нэг сануулж хэлж өгөөч. Бид нарын хэлж ярьж байгаа зүйл дээшээ ерөөсөө явж очихгүй байна. Өнөөдөр Монгол Улс дотоодын нийт бүтээгдэхүүн 13 тэрбум доллар үйлдвэрлэдэг боловч, 33.9 тэрбум долларын өртэй болчихсон байна. Саяхан төр барьж байсан эрх баригчид 16 онд Монгол Улсын 1 хүн ам 15 сая төгрөгийн өртэй болчихлоо, ямар ч амьдрах боломжгүй боллоо, тэнгэр нурж, газар цөмрөх гэж байна гэж байсан.

Тэгвэл өнөөдөр 1 хүний өр 32, 33 сая төгрөгийн өртэй болчихсон байхад дуугарахгүй байна. 20 он, 21 он, 22 оны төсвийн 1 жилийн алдагдал 4.1 их наяд гэж хэзээ ч өмнө нь сонсож байгаагүй энэ тоонуудыг сонсогдож байна. Яг нөхцөл байдал хэдийгээр КОВИД, дайн тулаан гэж яриад байгаа боловч иргэд аж ахуйн нэгжүүд үндсэндээ мөлхлөө. Ямар ч босох боломж байхгүй. Нийгмийн даатгал, татварын энэ доор туйлдаж, гараа хөлтэйгөө өргөж, дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу болоод байна. Энэ дээр арга хэмжээ авахгүй байна.

КОВИД-ын үед иргэдийг л халамжлаад байснаас хойш мөнгө үйлдвэрлэдэг, нэмүү өртөг үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдийг хохирлыг үе шаттай бууруулахгүй байна. Зарим нэг нь төрөөс дэмжиж байгаа гэж байгаа боловч тэр бол өөрсдийнх нь хамаарал бүхий хүмүүс энд хамаарагдаад байна. Валютын хани өнөөдөр хамгийн рекорд амжилтыг бий болгочихсон байна. Саяхан доллар 1400 хүрлээ гээд нойлын цаас бариад, мөнгө төгрөг бариад дэвхцээд байсан. Тэгтэл өнөөдөр бараг 4000 дөхчхөөд байдаг. Тэгэхэд дэвхцэж байгаа хүн ерөөсөө харагдахгүй юм. Тэр 62-ын бүлэгт чинь гээд. Ингээд хүч төвлөрүүлээд өгөөч гээд 16 онд 65 суудал, 20 онд 62 суудал бүх эрх мэдлийг зууны зуу, зууны хоёр зуу өгчхөөд байхад бид нар амьдралыг хамгаалах ямар ч шүхэргүй болчихлоо гэсэн ийм үйл явдлуудыг хэлж байна.

Тэгээд энэ үйл явдлуудаас болж, 22 он гарсаар инфляц 22 онд 2 оронтой тооноос буухааргүй байна. Дэлхийн банкны бизнес эрхлэхүйн судалгаагаар Монгол Улс 58-д байсан бол 81-д орж, 23 байраар ухарлаа. Дэлхийн эдийн засгийн форумын хүрэлцэх индекс 14 онтой бол 10 байраар ухарлаа.

Хүчээ нэгтгэсэн гээд байгаа боловч дэлхийн 179 оноос ардчиллын индексээрээ 61-д байдаг байсан бол 77-д орж 16 байраар ухарлаа. Тэгээд энэ бүгдийг хэлэхлээр хууль руу ярих юм. Дан ялангуяа Үндсэн хууль руу ярих юм. Саяхан нүүрсний хэрэг, Хөгжлийн банк гэж ярьж байгаа нь сайн боловч нөгөө ЖДҮ юу болсон бэ? Нөгөө концесс юу болсон бэ? Нөгөө албан тушаалын хэргүүд юу болсон бэ? Энэ бүх зүйлүүдийг янзалъя гээд Үндсэн хуулийг өөрчилсөн 19 онд.

Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийснээс хойш сахил хүртээд шал дордов гэдэг зүйл болж байна. Дахиад Үндсэн хуулийн цэцтэй хамтраад давхар дээл өмссөн. Давхар дээлд нь бүх нүүрсний хулгайч нар хавчуулагдчихлаа. Дахиад одоо бас Үндсэн хуулийг өөрчлөх зүйл ярьж байна. Энэ өөрчилснөөрөө бид нарын амьдрал сайжирдаг бол өнөөдөр үнэхээр гайхалтай болчихсон байх ёстой. Гэтэл 16 оноос хойш нэг ч юугүйгээр уруудсаар байж байгаад бид нар энэ түвшинд ирчихлээ.

Ийм учраас ард түмэн бол бид нарт ажиллах боломжийг олгоод өгөөч, бизнес хийх боломжийг олгоод өгөөч, төр бизнес эрхлэгчдээ нэмүү өртөг бүтээдэг энэ хүмүүсээс савраа татаач гэсэн энэ үйлдлүүдийг хэлж байна.

Тийм учраас энэ хариуцлагын тогтолцоотойгоо хамт энэ хаврын чуулганаар ярьж байгаа хуулиудаа саяын хийсэн үйл явдлуудыг.../минут дуусав./

Г.Занданшатар: Ардчилсан намын гишүүдийн хэлж байгаа зарим зүйлүүд бол үндэслэлтэй. Ард түмний үгийг

сонссон бол тэрийг хүргэж байх ёстой. Дэгээрээ явж байна. Дэгээр явж байна. Бичгээ өгөөд л асуудал явж байна. Ажлаа хийцгээ.

Ер нь бол энэ асуудлуудыг анхаарч ажиллах нь зүй ёсны хэрэг. Энийгээ анхаарч ажил. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан харилцаа.../үг тасрав./

Энэ гишүүдийн ярих эрхийг хязгаарлахгүй. Хэлэлцэх асуудлаа оръё. Битгий ингээд маргаан дэгдээгээд хэлэлцэх асуудлаар. Тогтохсүрэн дарга.

Нэг.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.

Ярьцаа ярьцаа ярьцаа. Энэ чинь ярих гэж энэ Их Хурал байгаа юм. Одоо хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгуугийн Содбаатар танилцуулна.

Я.Содбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол

Улсын хуулиудыг 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталж, Монгол Улсын Их Хурлын дарга 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 16 цаг 50 минутад ёсчлон. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 01/126 тоот албан бичгээр ирүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулиудад дараах үндэслэлээр бүхэлд нь хориг тавьж байна.

1.Монгол Улсын Засгийн газар 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн бөгөөд Монгол Улсын Их Хурал уг хуулийн төслийг хэлэлцэж эхэлснээс хойш 2 өдөрт багтаан эцэслэн баталжээ.

Хуулийн төслийг боловсруулах хэлэлцэн батлах үйл явцад иргэн олон нийтийн оролцоог хангаагүй, эрх, хууль ёсны, ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагаар хэлэлцүүлж, саналыг нь аваагүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт иргэд бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.6 дахь заалт, 38 дугаар зүйлүүдийг тус тус зөрчсөн байна.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ардчилсан ёс, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн хэмээх заалтыг зөрчих нөхцөлийг бий болгосон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна хэмээн заасан.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэгт хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй хэмээн Үндсэн хуулиар хязгаарлалт тогтоосныг анхаарч байх ёстой.

Тиймээс хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа хууль тогтоомжийг боловсруулах, хэлэлцэн батлахдаа олон нийтийн оролцоог сайтар хангаж, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санаа бодлыг сонсож, олон улсын сайн туршилага, судалгаа шинжилгээнд суурилан Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчмыг чанд баримталж байх учиртай юм.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1-т Улсын Их Хурлын баталсан хууль бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд заасан байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэгт, энэ хуулийн 45.4-т заасны дагуу илгээсэн хууль, тогтоолыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж

авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хууль, тогтоолыг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ гэж заасан. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай болон түүнийг дагалдан батлагдсан нэр бүхий хуулиудыг дагаж мөрдөх хугацаа 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр байхаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох хэсгүүдийг зөрчиж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг хязгаарласан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч олон нийтийн сүлжээ, цахим орчны талаарх эрх зүйн орчныг тодорхой боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байгааг энд онцлон тэмдэглэе. Монгол Улсын хувьд энэ хууль төдийгүй, хууль тогтоомжийг батлан гаргахдаа эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдийн оролцоог хангах, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн холбоод, иргэдийн саналыг авч сайтар хэлэлцэн, хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлж саналыг тусгаж, асуудалд тооцоо судалгаатай, шинжлэх ухаанч байр сууринаас хандаж, олон улсын сайн туршилага, жишигийн стандартыг бүх талаас нь судлан өөрийн орны давуу тал, онцлогийг тусган хийгүй чамбай хууль гаргаж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дээрх хуулиудад тавьсан хоригийг хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданшатар: Одоо Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Энх-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад Монгол Улсын Ерөнхийлөгч 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг тус Байнгын хорооны хуралдаанд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу уг хуулийн төслийг хэлэлцэж баталсан бөгөөд холбогдох хуулийн заалтуудаас үзэхэд дээр хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзэх нь хэр үндэстэй болох талаар хуулийн тайлбар ажлын хэсгээс тодруулж, асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх буюу 81.8 хувийн саналаар Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад Монгол Улсын Ерөнхийлөгч 2023 оны 1 сарын 30-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан. Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасан журмын дагуу 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн

хуралдаанаараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Байнгын хорооны хуралдаанд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Содбаатар танилцуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах явцад иргэд, олон нийтийн оролцоог хангаагүй, мэргэжлийн болон судалгааны байгууллагаар хэлэлцүүлж санал аваагүй нь хориг тавих үндэслэл болсон тухай дурдаад Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль нийгэмд зайлишгүй хэрэгцээтэй төдийгүй иргэд цахим гэмт хэргийн хохирогч болж байгаа учраас иргэд, олон нийтийн оролцоог хангаж, эрдэмтэн судлаач, иргэний нийгмийн байгуулалтын саналыг авч дахин батлах нь зүйтэй талаар үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр буюу 100 хувийн саналаар Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол

Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгуугийн Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Алтангэрэлийн Бямбажаргал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Очирсүхийн Маашбат.

Ерөнхийлөгчийн хориг болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Цэндийн Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Ерөнхийлөгчийн хоригийг энэ Улсын Их Хурал хүлээж авах нь зүйтэй. Энэ дээр санал нэг байна. Гэхдээ өнөөдөр энэ олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах энэ асуудал үүнтэй холбоотой нийгмийн харилцааг зохицуулах асуудал өнөөдөр Монголын нийгэмд хамгийн тулгамдсан асуудлын нэг болсон. Улсын Их Хурал энэ хуулийг батлахдаа олон хууль тогтоомжийг зөрчиж оруулж ирсэн нь бол энэ Ерөнхийлөгчийн хоригоос тавьсан энэ мэдээллээс тодорхой байна. Бид энд дүгнэлт хийх ёстой.

Гэхдээ өнөөдөр энэ олон нийтийн сүлжээнд цахим гэмт хэрэг үйлдэгддэг нэр хаяггүй ийм олон сүлжээнээс бусдыг доромжилдог, нэр хүндийг нь унагаадаг, залилан хийдэг, түүнчлэн хүчирхийлэл сурталчилдаг, хүчирхийллийг дэмждэг ийм асуудлыг өнөөдөр энэ Монголын төр зохицуулах ёстой. Бид нийгмийн өмнө, олон нийтийн өмнө энэ асуудлыг зайлишгүй шаардлагатайгаар хуульчилж батлах ёстой. Энэ дээр санал нэг байна. Бид энд

дүгнэлт хийх ёстой. Олон нийт юу хүсээд байгаа юм? Дийлэнх олонх нь энийг хүсээд байна уу, хүсэхгүй байна уу? Судалгаа хийх ёстой.

Түүнчлэн энэ асуудлыг нийт олон нийтээр хэлэлцүүлэхгүйгээр олон улсын байгууллагын сайн туршлагыг шийдэхгүйгээр оруулж ирж, яаралтай горимоор баталсны үр дүн өнөөдөр Улсын Их Хурлын хууль батлах процессын нэр хүндэд, Засгийн газрын хууль санаачлах нэр хүндэд бас ийм цөв суулгасан ийм асуудал болсон шүү. Энэ дээр Засгийн газар Улсын Их Хуралд дүгнэлт хийх ёстой.

Харин Ерөнхийлөгч нь энийг хориг тавьж, засаж залруулж, хууль дээдлэх зарчмын хүрээнд зөв асуудлыг оруулж ирсэн гэж ойлгож байгаа. Энэ олон шийдлийг эрсэн, олон асуудлыг хөндсөн ийм асуудлыг бид энэ хоригийг хүлээж аваад, дахиж оруулж ирж тэр эрх нь зөрчигдөөд байгаа юм гэж яриад байгаа, тэр хүний эрхийн асуудал хөндөгдөөд байгаа тэр олон улсын байгууллагын сайн туршлагыг судлаад яаралтай дахиж батлах ёстой шүү. Энэ нийт Монгол Улсын эрх ашиг, хүний эрх дээдэлдэг ардчилсан парламентын засаглалтай улсын тухайд энэ асуудлыг шийдэхгүйгээр цаашилаад бид ямар асуудал болох юм. Энэ зөвшилцөж байж нийт Монгол Улсын эрх ашиг нийт иргэдийнхээ эрх ашгийг хөндсөн асуудлыг бид олон нийтээр, олон түмнээрээ, төртэйгөө, төрийнхөө институттэй харилцан бодлого болгож шийдэх нь өнөөдөр Монгол Улсын эрх ашиг байгаа шүү гэдгийг энд хэлье. Асуулт байхгүй.

Г.Занданшатар: Үг хэллээ. Ёндоннэрэнлэйн Баатарбилиг гишүүн.

Ё.Баатарбилэг: Гишүүддээ энэ өглөөний амрыг айлтгая. Мөн Монгол Улсад Зэвсэгт хүчний өдрийн мэндийг нийт зэвсэгт хүчний албан хаагчдад бас баярын мэнд хүргэе. Хууль боловсруулах энэ анх энэ цахим орчин дахь энэ хүний

эрхийг хамгаалах тухай хуулийн хэлэлцүүлэг нэгдсэн чуулганы хуралдаан руу орж ирэх энэ цаг үед л анх яг энэ ийм нөхцөл байдал үүсэх вий гэдгийг л хэлж байсан юм л даа. Хоёрхон гишүүн л энэ асуудал дээр ярьсан юм.

Хууль боловсруулах үндэслэл, шаардлага, хууль батлагдсаны дараа нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл судалгаа хийхдээ хэр бодитой хандаж байгаа юм бэ гэдэг дээр энэ хууль санаачилж байгаа хууль санаачлагчид, Засгийн газар, Их Хурлын гишүүд бид нар ч гэсэн өөрснөө бас нэлээд нухацтай хандахгүй бол болохгүй болжээ гэдгийг энэ хууль маш тод харуулж байна.

Хуулийн төсөл анх боловсруулахдаа олон нийтийн санаа бодлыг хэрхэн тусгасан юм? Одоо энэ олон нийтийн санаа бодлыг хуулийн төсөлд тусгах юман дээр ёстой саяын энэ явдаг зөвлөлдөх санал асуулга асуулга чинь явж баймаар байгаа байхгүй юу. Уг нь Үндсэн хууль энэ тэр гэж яаж байснаас яг ийм хуулийн төслүүд дээр, яг энэ нийгэм, эдийн засгийн ийм тодорхой асуудлууд дээр зөвлөлдөх санал асуулгаа явуулаад энэ хууль үнэхээр хэрэгтэй байна уу, үгүй юу энэ хуулийг боловсруулбал ямар асуудлуудыг тусгах вэ гэж олон нийтийн санаа бодлыг энэ хуулийн төсөлд тусгах байсан, тусгаагүй. Төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн төлөөллийн дуу хоолой хаана байсан? Байгаагүй гэдгийг энэ дунд сууж орж ирсэн хуулийн төсөл хэлэлцэхэд байсан улсуудаас асуусан. Бид нараас асуугаагүй гэдэг юм хэлсэн.

Хуулийн төсөл дээр сууж байгаа ер нь ганцхан энэ хууль биш хуулийн төсөл боловсруулахад сууж байгаад төрийн албан хаагчид бас тодорхой мэдээллийг өгч баймаар байгаа юм. Энэ хуулийн төсөл ахалж байгаа энэ дарга нартаа. Дарга нар нь, сайд нар нь ийм хууль оруулна, өргөн барина гэхихээр тэгээд л амыг нь дагаад л ингэж хийх гэхээр нь ингэж хийгээд л, тэгж хий гэхээр нь

тэгж хийгээд л. Дуугүй ийм амьгүй албат царайлж суусны нэг гор нь энэ. Энэ төрийн албан хаагчид ажлаа хиймээр байна. Эд нар бол мэдэж байгаа шүү дээ. Ямар хор хөнөөлтэй, ямар үр урхагтайг, ямар муу нөлөө үзүүлж болох вэ гэдгийг мэдэхийн цаагуур мэдэж байгаа юм. Зүгээр fail-дүүлж байгаа байхгүй юу. Дарга сайд нарыгаа эвгүй байдалд оруулж байгаа юм.

Дараагийн нөхцөлд энэ хуулийн төслийг санаачилж байгаа, боловсруулж оруулж ирж байгаа дарга, сайд нар нь энэ доодох албан тушаалтнуудынхаа үгийг нь сайн сонсож баймаар байгаа юм. Ингээд л оруулна, заавал ингэж ингэж хийнэ гээд ингээд зүтгэчихдэг. Үүнээс болж ийм юм оруулж байгаа юм.

Эцэст нь энэ Улсын Их Хурал, Улсын Их Хурлын дарга, удирдлагууд, холбогдох Байнгын хороод энэ хуулийн төслийг яг тэр явдаг дэг журмаар нь явуулмаар байна. 48-хан цагийн дотор баталсан шүү дээ.

Тэгээд энэ хаа хаанаа энэ удаагийн энэ хуулийн төсөл хаа хаанаа анхаарах энэ том сургамж боллоо гэж үзэж байна. Хууль батлах процесст, энэ удаагийн парламентад.

Тийм болохоор Ерөнхийлөгчийн энэ хориг бол цагаа олсон маш зөв хориг болсон. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авахыг бол дэмжиж байгаа юм. Би яах вэ энэ удаа асуултдаа бол яах вэ энэ хориг хүлээж аваад хуулийн төсөл ингээд хоригийн дагуу цуцлагдаж байна. Тийм болохоор сайд энэ хуулийнхаа төслийг ахиж оруулж ирэх үү, ахиж оруулж ирэхээр бол ямар шат дараалалтай яаж хэлэлцүүлэг зохион байгуулж оруулж ирэх вэ гэдэг энэ талаасаа юу гэж бодож байгаа вэ гэж. Яагаад гэвэл энэ хуулиар зохицуулах шаардлагатай нийгмийн асуудлууд байгаад байгаа болохоор энэ хууль байх нь хэрэгтэй. Тэгэхдээ саяын шаардлагуудыг хангаад л ороод ирэхээр

нь хэлэлцээд баталъя л гэдэг ийм байр суурьтай байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хуулийг ахиж өргөн барих, ахиж боловсруулж байгаад өргөн барих санаа бодол байгаа юу гэдгийг хууль санаачлагчдын зүгээс нь асууя.

Г.Занданшатар: Байнгын хороо хоригоос асууна уу гэхээс биш санаачлагчаас асуухгүй л дээ. Хууль санаачлагч хариулах уу? Хууль санаачлагч ахиж оруулж ирэхгүй гэсэн хориг тавьчихсан учраас. Байнгын хороо хариулах уу? Байнгын хороо хууль санаачлагч биш учраас хариулахгүй юм байна.

Дараагийн асуулт. Тайлбарлах хүн байхгүй юм чинь. Байнгын хороо тийм юм яригдсан юм уу? Яригдаагүй гээд л товч харуулчихъя. Бямбасүрэнгийн Энх-Амгалан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо.

Б.Энх-Амгалан: Энэ хууль бол чухал хууль. Тэрийгээ ойлгож байгаа. Нийгмийн хэрэгцээ шаардлагыг нь ч ойлгож байгаа, ач холбогдлыг нь ч ойлгогдож байгаа. Цаг үе нь болсон энэ гарах ёстой хууль гэдгийг бол Ерөнхийлөгчийн хоригууд дурдсан байгаа юм. Тэгээд яах вэ, энийг бол хийгүй хууль хийгээрэй, чамбай хууль хийгээрэй л гэж ингэж гол чиглэлээ болгож байгаа юм. Тэгээд энийг бол Засгийн газар дахиж боловсруулж оруулж ирэх ёстой. Засгийн газраас өчигдөр Дэгийн хуулиараа асууж болохгүй учраас энийг бол цааш нь ингээд явуулаад, сайжруулаад, улам чамбайруулаад оруулж ирэх нь зөв зүйтэй гэдгийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга хэлсэн.

Тийм учраас энийг бол дахиж оруулж ирэх нь зөв, зүйтэй гэдэг дээр санал нэг байгаа.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Би Улсын Их Хурлын гишүүний хувьд товчхон саналаа хэлье. Энэ хуульд нийгмийн зүгээс бас тодорхой шаардлага байгаа юу гэж үзэх юм бол бас байгаа л хууль л даа. Нэгнийгээ адилхан харлуулах ийм ажиллагаа бол яг энэ нийгмийн сүлжээгээр дамжаад гүтгэлэг явагдаж байгаа юм. Тэр талаас нь харах юм бол нийгмийг тогтворгүй байдалд оруулах маш их хор уришигтай. Бүүр лавируулж ярих юм бол улс орны эв нэгдэл, тогтвортой байдлыг сулруулах алхам ч хийж болохоор ийм зүйлүүд нийгмийн сүлжээгээр гадаад улс орнууд хийгдэж байгааг бас бид нар анхаарах хэрэгтэй. Нийгмийн сүлжээгээр Арабын хувьсгалууд явсан бусад орны хувьсгалууд явах бас нэг зохион байгуулалтын арга хэрэгсэл болж өгсөн. Энэ талаасаа анхаарах юм бол байгаа.

Гэхдээ тэглээ гээд нийтийн мэдээлэл хүртэх тэр эрхийг хязгаарлаж болохгүй. Өнөөдөр энэ нийгмийн сүлжээ байгаадаа энэ хулгай дээрэм, луйврууд, эрх мэдэлтнүүдийн дураараа дургих үйл ажиллагаа бас тодорхой хэмжээгээр хязгаарлагдаж байгаа юм. Энэ талаасаа харах юм бол нийгмийн сүлжээ үүргээ гүйцэтгэж чадаж байгаа.

Тийм учраас энийг хуулиар зохицуулах байсан уу гэдэг дээр би бас жоохон эргэлзээ бий. Мэдээж хэрвээ хуулиар зохицуулах байсан бол түрүүний миний хэлсэн зүйлүүд дээр л анхаарах ёстой байсан. Тэр гүтгэх, доромжлохыг зогсоох ёстой. Гүтгэхгүй байвал шоронд орохгүй шүү дээ. Одоо ингээд манай зарим хэвлэл мэдээллийнхэн үгүй одоо ингээд тэр гүтгэхийг Эрүүгийн хуулиас ав, оруулах юм бол шоронд орчихно гэж. Үгүй гүтгэхгүй л байхгүй юу даа. Тэгвэл юу гэж энэ чинь чирж аваачиж шоронд хийх юм бэ. Тийм юм байхгүй шүү дээ.

Тэгэхээр гүтгэх гээд байх сонирхол байгааг л би гайхаад байгаа юм. Гүтгэх гээд байх сонирхол. Энийг л таслан зогсоох хэрэгтэй. Тэгээгүй цагт бүгдээрээ адилхан хар байх болно.

Бүгдээрээ адилхан хар. Гүтгээд хаячихна. Нэг хэсэг нь тийм л гэж ойлгоно шүү дээ. Ерөөсөө ингэж гүтгэж алсаар нэг нэгнийгээ 30 жил явж ирсэн. Би энэ гүтгэлгийн заалтыг хатуу ялтай болгох гэж чадаагүй. Харин тэр 90-ээд оны дунд үед хөөрхий нэг эмэгтэй алтан амиа золиосолж байж гүтгэлгийг III-ээр барьж хорьдог болгосон байхгүй юу. Тэгэхдээ хожим нь мартаад ирэхийнхээ цагт дахиад нөгөөдхөө мөнгөн торгууль болгоод хувиргачихсан.

Тэгээд хэнийг ч гүтгэж болдог систем Монголд үйлчилдэг. Энийг бол зогсоох ёстой. Иймэрхүү зүйлийг нь зогсоогоод, харин тэр иргэдийн мэдээлэл хүртэх эрх ашиг руу нь халдаж болохгүй байсан байх. Тодорхой цензуруудийг нь тавиад. Тэгэхдээ тэр хоорондоо мэдээлэл солилцох, мэдээлэл авах, тэр болж бүтэхгүй байгаа юмыг бол мэдээлэх. Одоо тэр шүгэл үлээгчийн гээд л хууль яригдаад байгаа шүү дээ. Энэ чиглэлээсээ харах юм бол тэр нийгмийн сүлжээний хэвлэлийн тэр нэг улс төрийн хүрээнд тавьж байгаа цензурийг бид нар хязгаарлахгүй байх ийм шаардлага байсан. Ийм л хар явснаас энэ хууль өнөөдөр зогсох байдалд орчхож байгаа юм. Нийгэм тэгээд ойлгочихсон учраас.

Тэгэхээр би бол заавал энэ хууль гэлтгүйгээр зохицуулах боломжууд байна гэж бодож байгаа юм. Эрүүгийн хууль дээр тэр хүн гүтгэхийг нь ялтай нь болгоод л яв. Тэр улс орныг жишээлбэл үймүүлэх, самууруулах, тогтворгүй байдал үүсгэх гээд байгаа бол бусад хуулиар нь зохицуулаад явах боломжууд бүрэн байгаа шүү дээ. Үндэсний аюулгүй байдлаа хамгаалах чиглэлээр бид нар хуулиудад өөрчлөлт хийгээд явах бас боломжууд байгаа. Тийм учраас.../минут дуусав./

Г.Занданшатар: Хариулт хангалтгүй бол 1 минут гэсэн дүрэмтэй байгаа. Хэн хариулах уу? Байнгын хороогоор юм яригдсан юм уу? Хууль зүйн

байнгын хороо. Даваасүрэн гишүүн тодруулъя.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр хууль татлаа, эргэж орж ирэх эсэхийг нь би мэдэхгүй. Гэхдээ ер нь бол бусад хуулиуддаа энэ нэг болгоомжлоод байгаа юмнуудаа зохицуулсан заалтуудыг оруулж өгье. Эрүүгийн хууль тэгээд бусад хуулиудаар зохицуулаад явъя. Гүтгэхийг хязгаарлая, эмх замбараагүй байдал үүсэх гээд байгаа бол, хорлон сүйтгэх үйл ажиллагаа гаднаас явуулах гээд байгаа бол энэ бүгдийг нь чангатгасан хуулийн зохицуулалтаа бусад хуулиудтайгаа хийгээд ингээд явж байх би бүрэн боломжтой гэсэн саналыг хэлэх гээд байгаа юм.

Тэгэхгүй бол бас хэтэрхий замбараагүй байдал үүсэх, эмх замбараагүй байдал үүсэх иймэрхүү юмнууд бол тэр янз бүрийн өнгөт хувьсгалууд гарах ийм нөхцөлүүдийг бас нэг арга хэрэгсэл нь болчихоод байгаа гэдгийг бид нар бас анхаарахгүй байж болохгүй. Энэ үнэн үү? Үнэн. Бусад улс орнуудын амьдралаас гарсан зүйл. Тэгэхээр энэ чиглэлийн юмнуудаа бусад хуулиараа зохицуулаад явах асуудлыг бол орхиж болохгүй шүү гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хэллээ. Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Ерөнхийлөгчийн хоригийг дэмжиж байна. Тэгээд хүлээж авах зайлигүй шаардлагатай. Тэгэхдээ манай Монгол Ардын намын энэ хууль дээр дэмжээд, дэмжсэн тэр гишүүд ийм хоёр нүүртэй байна. Хоёр нүүртэй. Ерөнхийлөгч хориг тавихаар 100 хувиар Байнгын хороонууд нь хоригийг хүлээж авъя гээд л. Тухайн үед энэ хууль хэлэлцэж байхад сөрөг хүчнийхэн бүгдээрээ завсарлага аваад, хурлыг хаяад наадах чинь болохгүй гээд хэлээд байхад зөрсөөр байгаад л батлаад явуулсан шүү дээ. Тэгээд одоо болохоороо Ерөнхийлөгч

хориг тавингуут бүгдээрээ Ерөнхийлөгч зөв гээд л бүгдээрээ алга ташаад.

Тэгээд ийм байдлаар бид нар Монгол төрийг удирдаад парламент маань хуулийг ингэж хэлэлцээд явах юм бол дэндүү өрөвдөлтэй байгаагийн нэг жишээ бол энэ хууль дээр харагдаж байна.

Ер нь яагаад заавал энэ фэйсбүүкийн энэ аппликэйшны асуудал дээр бид нар бүгдээрээ энэ хүний эрх зөрчих, энэ тайван жагсаалыг зохион байгуулалттай хааж, боох гэсэн ийм заалтуудыг оруулж ирж Үндсэн хууль руугаа тэр хүний эрхийн асуудал руу дайраад байгаа юм бэ. Энэ чинь угаасаа Монголын төрийн тэр хууль сахиулах байгууллагууд энэ залилан, тэр гэмт хэрэг бүгдийг нь урьдчилан сэргийлэх үүрэгтэй шүү дээ. Тэр үүргийнхээ дагуу тэр хууль дээр заалтууд нь бүгд байгаа. Өнөөдрийг хүртэл тэр асуудлуудаа ярьдаггүй.

Тэгээд энийг бүр ингээд дээд цэгт нь хүргэж байгаад шууд дайрч байгаа довтолгоо нь болохоор хүний эрхийн бүхэл бүтэн, за ялангуяа тэр эрхүүд рүү дайраад эхэлчихсэн. Тэгээд энийгээ буцаагаад буруу нь энэ аппликэйшн болчихсон. Зүгээр л энгийн асуудал шүү дээ. Энийг тэр фэйсбүүктэйгээ хамтраад сайжруулалтаа хийх ёстой. Өнөөдөр Монгол Улсад олон хуурамч хаяг байгаа бол тэрийг нь байхгүй болгох талаар бид нар ажиллах ёстой. Энэ чинь бүгд техникийн шийдэлтэй асуудлууд байхгүй юу. Тэрнээс энэ дээр хэн нэгний эрхийг боох, үг хэлэх, тайван жагсах энэ бүх асуудлыг оруулж ирж болохгүй. Хамгийн ноцтой нь тэр Харилцаа холбооны тухай хуулийг дагалдуулаад орж ирсэн тэр хууль дээр Ерөнхийлөгчийн бүрэн эрх рүү бас халдсан байсан шүү дээ.

Тэгээд онц байдал тогтоогоод хийгддэг асуудлуудыг Засгийн газрын нэг сайд оруулж ирээд шийдээд явна. Ард иргэд тайван жагсангуут сүлжээг нь хязгаарлана, мэдээллийг нь хорино гээд ийм асуудлууд оруулж ирсэн. Ийм ноцтой

л асуудал байсан. Тэгээд яаруу сандран бүгдээрээ нийлж байгаад манай 62-ын бүлгийнхэн оруулж ирсэн нь үнэн шүү дээ. Зарим нэгэн гишүүд бас байр сууриа илэрхийлсэн. Харамсалтай нь намын нэгдсэн бодлого, намын удирдлага оруулж ирсэн, Засгийн газар оруулж ирсэн гээд энэ хуулийг оруулж ирсэн.

Тэгэхээр энэ дээр бид нар ямар сургамж авах ёстой вэ гэхээр намын дарга чинь, Ерөнхий сайд чинь, Засгийн газар чинь дандаа зөв юм хийдэггүй юм байна шүү гэдгийг бас та бүхэн маань бас ойлгосон байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Үг хэллээ. Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Баярлалаа. Гишүүдэд шинэ чуулганы мэнд хүргэе. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах гэсэн нэртэй олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хязгаарлах, боомилох ийм агуулгатай хуулийг сая намрын чуулганы төгсгөлийн өдөр баталсан. Үүн дээр Ардчилсан намын бүлгээс 3-н ч удаа удаа дараа завсарлага авсан. Яг сүүлийн эцэслэн батлах хурлыг бүгдээрээ орхин гарсан. Бүхий л чадлаараа энэ хуулийг байр суурийн хувьд бүгдээрээ эсэргүүцсэн.

Яагаад бас яг ийм нөхцөл байдал үүсчэв? Энэний цаана хүний Үндсэн хуулиар баталгаажсан тэр үзэл бодлоо илэрхийлэх эрхүүд хязгаарлагдаад байгаа юм. Үүнийг яагаад Үндсэн хуулиар баталгаажсан гэж хэлж байна гэвэл энэ өөрөө хүний заяагдмал эрх учраас Үндсэн хуулиар энийг олгодог ч эрх биш. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Үндсэн хууль Монгол хүнд өнөөдөр олгохгүй. Энэ заяагдмал учраас энийг зүгээр л баталгаажуулсан нь ийм хэмжээний заяагдвал эрхийг энд хөндсөн олон асуудлууд энд яригдсан.

Тэгээд яагаад энийг ийм яаралтай горимоор оруулж ирэв? Яагаад 2 сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ гэж

Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд цаг хугацааны хувьд хуртэл халдчихсан маш олон ийм зүйл заалтуудыг энэ дээр болзошгүй гэдэг тийм маш зүгээр субъектив гэх юм уу даа. байр сууринаас юу ч хийж болох, юуг ч хязгаарлаж болох ийм маш олон ийм аюултай заалтууд энэний цаана агуулагдаж байсан. Үүн дээр Ардчилсан намын бүлгийн зүгээс тодорхой байр сууриудыг илэрхийлсэн. Цаашид ч бас энэ дээр бас мэдээж илэрхийлж таарна. Энэ нь ийм ийм хүний эрхийг боомилсон энэ олон зүйл заалтууд.

Тэгэхээр Ерөнхийлөгчөөс орж ирж байгаа энэ хоригийг хүлээж авах нь зүйтэй. Тэр тусмаа энэ хуулийг, энэ хоригийг дахиж нэгэнт хүлээж авснаас хойш дахиж энэ агуулга бүхий хуулийг Засгийн газар болоод холбогдох эрх мэдэлтнүүд энэ ийм агуулга бүхий хуулийг өргөн барихгүй байх гэдэгт бас найдаж байгаа. Асуулт алга. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй.

Г.Занданишатар: Үг хэлчихлээ. Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Та бүхнийхээ амар амгаланг айлтгая. Өнөөдөр Монгол цэргийн өдөр. Дэлхийн хамгийн шилдэг цэргүүдийн өдөр юм. Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгч бид 2 цэргийн хүмүүс. 150 дугаар Мот буудлагын дайчин хорооны нөхдүүд. Тэгэхээр энэ цэргийн өдрийн өмнө та бүхэн бас Ерөнхийлөгчийн анхны хориг байх. Монголын ард түмэнд Монголын ард түмний нэрийн өмнөөс ярьж чадах цорын ганц субъект. Монголын ард түмнээс сонгогдсон. Тэгэхээр манай Дэлгэрсайхан гишүүн бас цэргийн алба хаасан юм шиг байна лээ. Хилийн цэрэгт. Энэ Монголын ард түмэндээ бэлэг болгоод ер нь хийх ёстой ажлаа хийгээд, энэ хоригийг бид нар 100 хувь хүлээж авъя. Энийг та нарын барьж байгаа маш сайхан бэлэг гэж би бас хүлээж авъя. Нэгдүгээрт энэ.

Ер нь энэ олон нийтийн сүлжээнд хориг тавих ийм юм хэрэггүй. Энэ чинь

Монгол Улсын дархлаа шүү дээ манай иргэдийн. Энэ ардчилсан зарчмаар ардчилсан улс орон ард түмнээ удирдаж сурмаар байгаа юм. Та бүхний хүчийг 2 удаа нэгтгэж өгсөн Монголын ард түмэн. Тэгээд ийм буруу зүйл хийгээд байдаг. Хуулиудыг яаж баталдаг вэ гэдэг чинь эндээс харагдаж эхэлж байгаа юм. Тэр Хууль тогтоомжийн хуулийг биелүүлдэггүй, яаравчилсан горимоор орж ирдэг, Засгийн газар нь давхар дээлтэй. Тэгээд нэг гишүүн нь, нэг сайд нь 2, 3-н гишүүнээ барьчихдаг. Дуртай хуулиа дураараа баталдаг. Энэ улс оронд хууль хэрэгждэггүй, хууль дээдэлдэг ийм юм байхгүй болсон. Тэгээд энэ улс орны чинь хамгийн баталгаагийн баталгаа чинь мэдлэгтэй, мэдээлэлтэй хүн шүү дээ. Иргэн шүү дээ. Бид нар юугаараа ялгарах вэ гэвэл энэ 2 том гүрнээс энүүгээрээ ялгарна. Бид нар чинь эрх чөлөөний баталгаа байхгүй юу. Энэ тэр янз бүрийн юм яриад байгаа. Тэрийг чинь Эрүүгийн, Зөрчлийн, Иргэний хуулиар шийдэж болно. Шийддэг.

Тэгэхээр энэ хуулийг ахиад сайн өөрчилж бариад оруулж ирнэ гэнэ үү? Тийм юм байхгүй байлгүй дээ. Ерөнхийлөгчийн Тамгын газраас тодруулчихъя. Ахиад иймэрхүү маягийн хууль битгий оруулж ир. Хар л даа өшөө л хүндэрнэ шүү дээ. Иргэдийг бухимдуулна. Хэрвээ Ерөнхийлөгч энэ хуульд цагаа олж хориг тавиагүй байсан бол 2 сарын 1-нээс эхлээд хэрэгжээд эхэлсэн бол энэ улс ард ард түмний бухимдал дээд цэгтээ хүрэх байсан. Энэ талбай дээр гараад ирэх байсан шүү дээ. Одоо хар тэрэг Гүржийн нөхцөл байдлыг. Энэ хуулийг би бас гадна дотнын нөхцөл байдлаар, захиалгаар батлуулах гэж оролдсон хууль байх гэж бодож байна. Ийм зүйлээ болих хэрэгтэй. Бид нар иргэдээ аль болохоор л эрх чөлөөтэй, мэдээлэл авах эрхийг нь хангасан ийм байдалтай байх хэрэгтэй.

Хар л даа ер нь Засгийн газар хууль бус зүйл их хийдэг шүү. Тухайлбал энэ гадаа жагсаал болж байхад тэр иргэдийн сүлжээг нь унагадаг гар утасных нь. Тэр

гар утас хувийнх нь шүү дээ. Тэр хүний. Тэр хүний хөрөнгөд яаж халдаж байгаа юм. Тийм хууль, эрх зүйн орчин бий юу? Байхгүй шүү дээ. Тэгээд 4 талд нь утасны сүлжээ унагаач тавьчихаад унагаад байдаг. Иргэд тэрийг чинь мэдэж мэдээлэлтэй байх тусмаа л улам л зөв зүйтэй л ажиллана шүү дээ. Тэрийг нь хаагаад, боогоод байхаар учир битүүлэг байдал үүсэж байж яг Гүрж шиг юм болно шүү дээ. Харин ч Гүржийн Засгийн газар зөв оновчтой ажиллалаа. Манайх энэ Засгийн газар.../минут дуусав./

Г.Занданшатар: Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга хариулъя. Энэ хуулийг ахиж оруулж ирэх юм уу гэж, ахиж оруулж ирэх нь зүйтэй юу, үгүй юу гэж асууж байна. Содбаатар дарга.

Я.Содбаатар: Гишүүдэд энэ өдрийн мэндийг. Тэгэхээр ер нь Монгол Улсад цахим орчин олон нийтийн сүлжээнд эрх зүйн зохицуулалт хийх зайлшгүй шаардлага байгаа юу гэвэл байгаа. Энийг ямар хуулиар хэрхэн хийх вэ гэдэг асуудал бол мэдээж хууль тогтоож байгаа парламентын бүрэн эрхийн асуудал.

Нөгөө талдаа өнөөдөр бид нар энэ цахим орчин, энэ шинэ нөхцөл байдал, энэ олон нийтийн сүлжээнд байж байгаа олон зүйлүүд бас сэтгэл эмзэглүүлж байгаа юм. Өнөөдөр цахим орчинд гарч байгаа гэмт хэргийн тоо жилээс жил болгон нэмэгдэж байна. Ялангуяа цахимаар, цахим орчноор дамжуулж залилах гэмт хэргийн тоо нийт гэмт хэргийн тооны 51.1 хувийг эзэлж байна. Хүчирхийлэлд уриалах, хүүхдийг садар самуунд сурталчлах гэмт хэрэг, бусад заналхийлэх, гүтгэх гэмт хэрэг гээд маш олон зүйлүүд бол байгаа. Тийм учраас энэ Ерөнхийлөгчийн зүгээс хориг тавихдаа ч гэсэн та бүхэн анзаарсан бол хоригийн тавьж байгаа юман дотор ч гэсэн бид нар энийг онцолж хэлсэн.

Ер нь энэ цахим орчны асуудлыг бид нар хууль эрх зүйн орчныг олон улсын сайн жишигийг авч, эрдэмтэн судлаачдын үг яриаг авч, ялангуяа эрх нь хөндөгдөж байгаа хуулийн, тэр эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлгүүдийн санал бодлыг сонсож олон талаас нь сайтар хэлэлцэж, олон нийтийн хэлэлцүүлгийг өрнүүлж, санал бодыг тусгаж байж энэ асуудлуудаа шийдвэрлээч гэдэг ийм талаас нь ярьж байгаа юм. Би энэнтэй гишүүд санал нэгдэх байх гэж бодож байгаа юм.

Ер нь бол бид нар энэ олон нийтийн сүлжээ, цахим орчин, энэ орчны эрх зүйн сайжруулах чиглэлээр олон улсад нэлээн олон жишиг байгаа. Олон орон ч зохицуулалтын хуулиуд гаргаж байгаа. Зарим орнууд бие даасан хууль гаргаж байна. Зарим орнуудад мэдээж Эрүүгийн хууль, бусад хуулиудын зохицуулалтаар бас явж байгаа. Зөрчлийн хуулийн зохицуулалтаар явж байгаа тохиолдлууд байна.

Тийм учраас манай улсын онцлог, манай улсад давуу тал болон сул талаа хараад тэгээд энэ эрдэмтэн судалгаа тооцоо хийж байгаад энэ асуудлыг эрх зүйн зохицуулалтаа сайжруулах ёстой гэдгийг Ерөнхийлөгч ч гэсэн Их Хурал дээр хийсэн мэдээлэлдээ бас та бүхэнд ярьж байсныг тодхон санаж байгаа байх гэж ингэж бодож байгааг энд хэлье.

Мэдээж энэ хуулийн процедурын юун дээр сая гишүүд бас саналаа хэлж байх шиг байна. Энэ хүрээнд бид холбогдох Үндсэн хууль, Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуулиудын тодорхой заалтуудыг зөрчсөн байна гэж үзээд Ерөнхийлөгч бүхэлд нь хориг тавьсан юм.

Г.Занданшатар: Тэгэхдээ Бямбажаргал зөвлөхөө, Содбаатар даргаа хууль дээдлэх ёстой. Хууль тогтоомжийн тухай хуульд нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн

төсөл. Мөн Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3.4.1, 3.4.3-д заасан асуудлаар боловсруулсан хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно гэж заасан шүү дээ. Тэгээд цаашидаа бол нэн яаралтай горимоор хэлэлцүүлсэн хуулиудыг бид өргөн барих, авахгүй болж зарчим тогтоож байгаа шүү одоо үүнээс хойш. Аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг заавал хэлэлцүүлж, холбогдох бүх саналыг авчирч бай гэж ийм зарчимд тохирох нь байна шүү. Ингээд Ганбат гишүүн асуулт асууя. Энэ хуулийн хэрэглээ чинь буруу шүү.

Д.Ганбат: Саяын Содбаатар даргын хэлж байгаа, мөн Ерөнхийлөгчийн явуулж байгаа наад утга санаан дотор бол мэдээж хэрэг энэ албан тушаалтай, энэ нөхдүүдийн юмыг хамгаалсан, өмгөөлсөн тийм зүйл байхгүй байх гэж бодож байна. Иргэд социал орчинд чөлөөтэй илэрхийлж бас хардах эрхээ эдэлж, энэ энэ муу муухай зүйлийг гаргахгүй бол бас болохгүй байх. Тэр талаас нь анхаарч ажиллах ёстой. Мэдээж хэрэг тэгэхгүй бол энэ дураараа авирладаг, энэ авлига, хээл хахууль тэр юмыг чинь өөрийнхөө нэрээр ч юм уу, өөрөө чөлөөтэй хэлэх эрх тийм бага байна шүү дээ. Тийм боломж муутай байна шүү дээ. Ингэж хараад байхад. Нөгөө хүнээсээ цалин пүнлүү авдаг юм уу, тиймэрхүү байдалтай байдаг учраас болохгүй байх. Тэгээд иргэд дарга нараа шүүмжлэх эрхээ эдэлсэн нь дээр байх. Төр засгаа ч гэсэн

Г.Занданшатар: Үг хэллээ. Одоо Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Баярлалаа. Тэгэхлээр нөгөө сануулж хэлэх хүн байхгүй бол сайн засаглал ч ялзарна гэж ийм үг байдаг. Тэгээд энэ хууль бол үнэхээр энэ хуулийг яг үнэндээ бол батлаагүй шүү дээ. Бид бүхэн 2, 3 удаа Ардчилсан намын бүлэг завсарлага авсан. 2 өдрийн, 3 өдрийн. Цагийн, минутын завсарлага өгч байгаа

юм. Хамгийн сүүлд бид бүхэн аргаа ядаад хурал хаяж гарсан. Хурал хаяж гараад Одонтуяа гишүүний өрөөнд ороход энэ хууль батлагдаагүй. Хэчнээн удаа батлаагүй гэхэд тэр ч кноп гацсан, энэ ч кноп гацсан гэж байгаад 3, 4 удаагийн хүчингүй үйлдэл хийсэн.

Тэгээд энэ яадаг вэ гэхлээр манай эрх баригчдын хийдэг л нэг байгаа. Наадам, цагаан сар, чуулганы хаалт хамгийн эгзэгтэй үед хууль батлах гэж чичирдэг. Энэ чичирсний нэг шалтгаан бол энэ болж хувирч байгаа юм. Өнөөдөр би та бүхэнд түрүүнд хэлсэн би Монгол Улс ардчиллын индексээрээ 22 онд 179 орноос 61 дүгээр байранд байж байгаад 77 дугаар байранд 16 байраар ухарсан. Хэрвээ энэ хууль батлагдаад цаашаа явах юм бол 16 байтугай хуулиар ухарна. Яагаад 16 хуулиар байраар ухарсан нэг шинж тэмдгийг нь би яг энэ хууль шиг бүр Үндсэн хууль руу ордог болсон. Үндсэн хуулийн цэц дээр эрх зүйн чадамжгүй төрийн албаны дээд хязгаар нь өнгөрсөн хүмүүсийг мануухай болгож байлгаж байгаад тэрүүгээр бүр Үндсэн хуулийг 3 цагийн дотор өөрчилдөг болсон.

Дараа нь наадам, цагаан сар, шинэ жил, хаврын чуулганы завсарлага иймээр ийм эгзэгтэй хуулиудыг оруулж ирдэг. Монгол ардын намын 65, өнөөгийн 62 амьгүй албатууд болсон. Энэ хуулийг болохгүй гэж ороход нь би энэ үүдний өрөөнд маш олон гишүүдтэй уулзсан. Та нар өөрсдийнхөө энэ хийсэн энэ магасанд өөрсдөө ч ажиллуулна шүү гэсэн нээрэн нь тийм байна гэсэн. Энд орж ирээд чичрээд бүгдээрээ дарсан. Тэгсэн мөртөө өнөөдөр эргээд Ерөнхийлөгчийг хориг тавингуут эргээд 100 хувь саваад чичрээд дарж байгаа байхгүй юу. Энэ Монголын төр гэж байна уу, ой санамж гэж байна уу?

Тийм учраас энэ асуудлуудыг хойшид гаргуулахгүй байх тал дээр манай аль аль хууль өргөн барьж байгаа асуудал анхаарах ёстой юм. Энэ хуулийг батлахад тэндээс Учрал гишүүн би та нараас гуйж байна. Энэ хууль батлагдсанаараа

Монголын ямар ямар зүйлүүд ямар ямар өндөр түвшинд гарна, ёстой гайхалтай хууль байгаа гээд чичрээд бүлтгэнээд байсан.

Тэгээд өнөөдөр ингээд батлагдахгүй бол яах юм. Монгол орон нурах юм уу, байхгүй болох юм уу. Энэ бол маш хэцүү хүний заяагдмал эрх рүү халдсан хууль байсан. Талбай дээр зогссон жагсаалыг, сүлжээ сааруулагч хийсэн, дотор нь тагнуул тавьсан, бичлэг хийсэн, хүний эрхэнд халдсан. Тэрийгээ туршиж үзчихээд энэ яг одоо болох юм байна, энэ ер нь ард иргэдийн амыг нь хааж болох юм байна, сөрөг хүчний амыг нь хааж болох юм байна гэдгээ хуульчилж оруулж ирж байна гэдгийг бид нар удаа дараа хэлсэн. Удаа дараа хэлсэн. Сөрөг хүчнээ сонсдоггүйн гай бол ийм болсон.

Харин энэ чуулганы эхнээс авхуулаад Их Хурлын дарга бидний үгийг таслахгүй байна. Хэлсэн зүйлийг бас хэлж байна. Ер нь яг үнэндээ карт сугалдаг, хүмүүсийг дуудаж санал өгүүлдэг, дандаа хүчээр хийдэг Ардын нам. Батлагдсан хуулийг бүр сүүл рүүгээ Үндсэн хуулийг хүчинддэг болсон, давхар дээлийг булааж авдаг болсон. Ард түмний эрх мэдлийг авдаг болсон. Тэр давхар дээлд нь юу нь олдож байна вэ? Хулгай, луйвар давхар дээлийнх нь завсар. Нүүрсний хулгай, Хөгжлийн банкны хулгай Засгийн газар руу орж байгаа. Ингэж ард түмний эрхийг авдаг гэдгийг энэ хориг бол онцгойлон харуулж байгаа юм.

Тийм учраас, тийм учраас энэ Монгол ардчилсан орон, энэ чөлөөт нийгэм, энэ бизнес рүү дайрдаг, хумсаа шигтгэдэг энэ асуудлуудыг энэ хуулиар хамгаалах гэсэн юм. Энгийг цаашид.../минут дуусав./

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн. Үг хэллээ. Асуулт Засгийн газраас асуу.

Б.Баярсайхан: Баярлалаа. Өнөөдөр хүн төрөлхтөн бодит ертөнц, цахим ертөнц гэсэн 2 ертөнцөд тэртээ тэргүй зэрэгцэн амьдарч байна. Энэ техник технологийн хөгжлийн өндөр энэ хөгжссөн үед бид цахим харилцаа чухал болж байна. Хүний нийгмийн харилцаанд олон эрх зүйн зохицуулалт байдаг тэгвэл одоо энэ сүүлийн 10 жил бүр идэвх идэвхэжсэн, энэ хөгжссөн цахим харилцаанд эрх зүйн зохицуулалт бол зайлигүй шаардлагатай байгаа.

Ялангуяа Монгол Улс бараг хүн амынхаа тооноос ихээр давхацсан энэ тоогоор фэйсбүүк хэрэглэж байгаа. Хүүхдүүд нь 4-өн наснаасаа тик токийн хэрэглэгч болж байгаа. Өсвөр насны хүүхдүүд нь бүгд цахим хэрэглэгч болсон. Өсвөр насны хүүхдүүдийн интернэтэд өнгөрөөж байгаа цаг өдөрт 4-7 цаг болсон ийм үед дэлхий нийтэд энэ цахим орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл ихсэж байгаа, манай улсад ч гэсэн энийг тойроогүй. 12-16 онд цахим хүчирхийлэл, сэтгэл гутрал энэ янз бүрийн байдлаас болж 92 хүүхэд амиа хорлосон ийм асуудал байгаа. Ийм орчинд байж байгаа.

Тэгэхлээр үүгээр би юу гэж хэлэх гэж байна гэхлээр томчууд бидний цахим орчинд өөрсдийнхөө энэ биеэ авч явж байгаа байдал, үг хэллэг, энэ муу муухай зүйл чинь хүүхдүүдэд маань шууд нөлөөлж байна. Бидний энэ ярьж байгаа бүдүүлэг үг хэллэг, энэ муу муухай зүйлийг хүүхдүүд маань дуурайгаад, хаалттай группүүдийг нээгээд дэлхийгээс зайл, халтруудаас салъя гэх мэтчилэн бие биеийгээ цахим хүчирхийлэлд өртүүлэх улмаар анги танхим, сургууль хот ишлжих, сүүлдээ мансууруулах бодис янз бүрийн буруу муу хүмүүст уруу татагдах ийм асуудал хүүхдүүдийн маань дунд байсаар байна.

Тийм учраас томчууд бид цахим орчинд соёлтой оролцох энэ цахим орчныг хүүхдүүд харж байгаа гэдгийг ямагт санаж байх хэрэгтэй байна. Энэ хуулийг батлуулахад цахим орчинд хүүхдийн

эрхийг хамгаалах хуулийг дотор нь оруулаад батлуулъя гэсэн ийм саналуудыг хэлж байсан. Энэ хууль бол бие даасан хууль байх ёстой гэдэг дээр улам итгэл төрж байна.

Тийм учраас эрхэм Улсын Их Хурлын даргаа, Нямбаатар сайдаа, Учрал сайдаа, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ, бүх хөгжингүй орнууд чинь хамгийн сүүлд сая Филиппин цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдээ хамгаалах бие даасан хуулиа баталчихсан. Тийм учраас Баярсайхан гишүүн миний бие энэ хуулийг санаачлан батлуулахаар энэ судалгаа ингээд дуусаж байгаа. Тун удахгүй энэ хуулийг дэмжих хэлэлцүүлгийг бас санал авах болно. Тэгээд энэ хуралдааныг анхааралтай ажиглаж байгаа эцэг эхчүүд болгон, томчууд болгон энэ цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах энэ хуулийг бие даасан хууль болгох энэ хуулийг дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна.

Ер нь хүүхдийн асуудлыг дандаа нэг зүйлд ингээд хавчуулан хавчуулж байдаг. Хүүхэд энд юу хийж байна, хүүхэд маань энэ дээр ямар байж байна гэдэг тал дээр томчууд бид төдийлөн анхаарахгүй байгаа нь үнэхээр харамсалтай. Тийм учраас би асуулт асуугаагүй, үг хэлж байгаа. Тэгээд Улсын Их Хурлын даргыг бас дэмжинэ гэж бодож байна. Уржигдар бол Монгол Улсын Засгийн газар гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийллийн эсрэг бас дорвитой арга хэмжээ авч ажиллах болно гэдгээ илэрхийлсэн. Тийм учраас Монгол Улс цахим орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллийг, хүүхдээ хүчирхийллээс хамгаалах энэ хуулийг батлах ёстой. Тэгээд үүнийг үүгээр мэдэгдэж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Зарим гишүүдийн хэлж байгаа үгтэй санал нийлэхгүй байна л даа. Энэ хуулийн

агуулга, мөн чанар, үзэл баримтлал буруу мушгиж тайлбарлаад, гуйвуулаад байх юм. Энэ хуульд иргэн хүний Үндсэн хуулиар олгогдсон үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, нэгдэж жагсаж цуглах энэ эрхийг хааж боосон юм нэг ч байхгүй шүү дээ.

Гэтэл олон нийтэд ийм байгаа юм шиг мэтээр буруу мушгиж, гуйвуулж ингэж ойлгуулаад байх юм. Харин энэ сошиал орчинд энэ эрх нь зөрчигдөж байгаа иргэдийн эрхийг хамгаалах л хууль юм байгаа юм шүү дээ. Гэтэл их айхтар ингээд л жагсаж цуглаж байгаа, үгээ хэлэх гэж байгаа иргэдийг л хааж боосон ийм л юм хууль баталчихсан юм шиг юм ярьж, ойлгуулаад байгаад би бас харамсаж байна шүү. Энэ хуулийн үзэл баримтлалыг бас өөрсдөө сайн уншиж үзэж, танилцаарай. Энэ хуулийг харин заавал ийм яаруу сандруу намрын чуулганы төгсгөл дээр ингэж оруулж ирж батлах хэрэгцээ шаардлага нь харин юу байсан юм? Ултай суурьтай нэлээд нухацтайгаар оруулж ирээд тэр санал хүсэлтийг нь аваад олон нийтийн оролцоог нь хангаад ингээд явчих тэр бололцоо боломж нь байхгүй байсан юм уу?

Ингэснээрээ бас ингээд Ерөнхийлөгчийг хориг тавих тэр нөхцөлийг бас бүрдүүлчихсэн байна л гэж би харж байна. Тэрнээс Ерөнхийлөгч энэ хуулийн үзэл баримтлал, агуулга дээр бол энэ цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийг өөгшүүлж байгаа асуудал нэг ч байхгүй шүү дээ. Зүгээр процедурын алдаа гаргасан байна, яаралтай горимоор хэлэлцсэн байна, олон нийтийн, иргэний нийгмийн байгууллагуудын, төрийн бус байгууллагуудын оролцоог хангаагүй байна л гэж ингэж л хориг тавьж байгаа гэж ойлгож байгаа юм.

Тэгвэл нийгэмд өнөөдөр энэ хуулийн хэрэгцээ шаардлага, зохицуулалт байна уу гэвэл үнэхээр байна шүү дээ. Энэ олон хулгай, луйвар, хүчирхийлэл, садар самуун, сурталчилгаа үгүй энийг тэгээд хараад

суугаад байх юм уу? Тэгээд энэ эсэргүүцээд байгаа улсууд энийг ингээд дэмжээд байна гэсэн үг үү? Ерөөсөө ойлгохгүй байна.

Тийм учраас би энэ хуулийг Байнгын хороон дээр хэлсэн үгээ дахиж хэлмээр л байх юм. Дахиж тэр Ерөнхийлөгчийн хориг тавьсан үндэслэл болох тэр процедурын алдааг нь засаж залруулаад, олон нийтээр хэлэлцүүлээд ингээд бас оруулж ирээч. Хэрэгцээ, шаардлага зайлиггүй байна шүү. Нөгөө талаас би энэ хориг бол Ерөнхийлөгчийн анх удаагийн анхны хориг гэж ойлгож байгаа юм.

Ер нь Их Хурал, парламент олонхоороо Улсын Их Хурал олонхдоо дүлдуйдаж гэдэг юм уу, олонхоороо түрээ барьж гэдэг юм уу хууль батлахгүй шүү. Дэгийнхээ дагуу, Хууль тогтоомжийн хуулийнхаа дагуу хуулиа батлах ёстой шүү гэдгийг бас дээр нь сануулсан. Ерөнхийлөгчийн институт байгаа шүү гэдгийг мэдрүүлсэн ийм ухамсрын шанаа өгч байна л гэж би хувьдаа ойлгож байгаа бас Их Хуралд.

Тийм учраас үнэхээр ийм зөрчил гаргасан гэж үзэж байгаа бол энийг нь засаж залруулаад л оруулаад л ирье л дээ. Тэгээд Засгийн газар энэ дээр бас анхаараад, энэ хуулийн хэрэгцээ шаардлага, би бол энэ хуулийг хэзээ нэгэн цагт батлагдах нь зайлиггүй цаг хугацааны асуудал гэж ойлгож байгаа. Яагаад гэхээр цахим гэмт хэрэг үйлдэгдэж байгаа хор хохирол, хохирогч нарын тоо, хэмжээ өдөр, сараар нэмэгдэж байгаа шүү дээ. Та бүхэн статистикийн хоорондоос харж байгаа шүү дээ. Энэ дээр цаашидаа төр засаг тодорхой арга хэмжээ авах л ёстой шүү дээ. Тийм учраас зайлиггүй орж ирэх ёстой хууль. Тийм учраас би бол энэ хуулийг дахиж энэ зөрчил алдаа юмаа засаж, залруулж оруулж ирээрэй л гэж.../минут дуусав./

Г.Занданшатар: Дахиж оруулж ирэх юм уу гэж асуусан. Энэ асуулт

хариултын дараа санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай. Нямбаатар сайд хариулах уу, Учрал Сайд хариулах уу? Ахиж оруулж ирэх үү гэж асуугаад байгаа юм. Ерөөсөө тэгээд 2, 3 удаа. Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Дамдинням гишүүнээр тасаллаа. Сая ч бүгдээрээ л үг хэлчихсэн л дээ. Асуулт биш дандаа л үг хэлчихсэн. Тэгээд л ахиад л үг хэлэх нь байна тээ. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Энэ хуулийн ач холбогдлыг бас жоохон мушганаж гуйвуулаад байх юм. Энэ хууль бол энэ терроризм, экстремизм, үндэсний эв нэгдлийг бусниулах, төрийн болон албаны нууцыг задруулах, террорист үйлдэл хийх, үндэсний болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэхэд өдөөн турхирах, уриалах, садар самууныг сурталчлах, амиа хорлоход хүргэх, уриалах ийм асуудлыг, 12-хон асуудлыг зохицуулж байгаа ийм хууль шүү дээ. Тэгээд Ерөнхийлөгчийн тавьж байгаа хоригийн асуудал бол юу вэ гэхээр зэрэг энэ хуулиа улам чамбайруулаадах, ач холбогдлыг нь ойлгож байна, нийгмийн хэрэгцээ шаардлагыг нь ойлгож байна, хийгүй чамбай хийгээд нэлээн сайн нэмж боловсруулаад оруулаад ирээрэй л гэсэн утга санаа шүү дээ.

Тэгэхээр зэрэг энийг ерөөсөө маш буруу хууль баталчихсан юм шиг нийгэмд ойлгуулахаа болих хэрэгтэй байгаа юм. Би нэг зүйлийг бол энэ статистик мэдээ хэлж өгье. Энэ одоо ингэж яриад байгаа хүмүүст. Энэ бол Харилцаа, холбооны зохицуулах хорооноос гаргасан өнгөрсөн онд гаргасан судалгаагаар Монгол Улсад интернэт хэрэглэгчдийн тоо 2.2 сая байгаа. Сошиал медиа хэрэглэгчдийн тоо 2.8 сая байгаа. Тэр дундаас 1.1 сая хэрэглэгч нь хуурамч хаяг байна гэж. Фэйсбүүк компанийг Хонг Конг, Тайвань, Монгол Улс дахь бодлого үйл ажиллагааг хариуцсан захирал Жорж Чин гэдэг хүн мэдэгдчихсэн шүү дээ. 1.1 сая хуурамч хаяг байна гэж. Энэ тэгээд байж байх ёстой юу? Нүүрээ нуучхаад, нүдээ

нуучхаад, нэрээ нуучхаад, утсаа уучхаад хүн доромжилж байх нь зөв үү тэгээд?

Хоёр дахь асуудал. Энэ АСЕМ-ийн үеэр 2016 онд мэргэжлийн байгууллагаас судалгаа хийхэд 650000 бүртгэлгүй дугаар байсан. Одоо энэ тоо 45000 болсон гэж Харилцаа холбооны зохицуулах холбооны тоо байна. Тийм учраас энэ бүртгэлгүй дугаартай холбоотой асуудлыг цаашидаа яах вэ гэдгийг бодох ёстой.

Гурав дахь асуудал. Энэ 2020 онд хийсэн судалгаагаар Монгол Улс кибер аюулгүй байдлын нөхцөл байдлын хувьд 194 орноос 120-д байна. Цахим засаглалын кибер аюулгүй байдлын индексээрээ 160 орноос 123-д байна. Монгол Улс руу чиглэсэн Кибер халдлагын тоо сүүлийн 3 жилд огцом өссөн. Өдөрт хийгдэж байгаа кибер халдлага 1870000 гараад явчихсан. Өдөрт шүү. Энэний 80 гаруй мянга нь гаднын тусгай албаны санхүүжилттэй байж болох ноцтой түвшиний халдлагууд байна.

Тэгээд бид нар энийг ингээд байлгаад байх ёстой юу? Гаднын сервер дээрээс тусгай нууцалсан дугаараар халдлага хийж байгаа нөхцөл байдал өндөр байна. Энийг байлгаж байх ёстой юу? Гэмт хэргийн тоо сүүлийн үед маш их өссөн. Энэ юу вэ гэхээр зэрэг 2019 онд 737 гэмт хэрэг цахим орчинд үйлдэгдсэн. Хохирол нь 985 сая төгрөг байсан. Тэгвэл 2022 онд энэ тоо 11 дахин дахин өссөн. 8563 болсон. Хохирол нь 22 дахин өссөн. 21 тэрбум 927 сая төгрөг болсон. Энэ бид нарт дохио өгөхгүй байна уу? Хүүхдийг гэмт хэрэгт уруу татсан, садар самуунд уруу татсан, хүүхдийг хүчирхийлсэн ийм нөхцөл байдлууд бол шүүхээр хүртэл шийдэгдэж байгаа баримтууд байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ нөхцөлүүдээ бид нар цааш нь харж, үзэх ёстой юм шүү гэдгийг энд бас хэлэх ёстой юм. Бидний яриад байгаа тэр ардчиллын үнэ цэнийг дээшлүүлээд байгаа, энэ ардчиллыг

хөгжсөн үндэс хүний эрхийг эрхэмлэн дээдэлдэг дэлхийн 17 орон яг энэ үндэсний эв нэгдэл, ардчилсан ёс, хууль дээдлэх ёс, нийгмийн тулгамдсан асуудлыг ишийдвэрлэх зорилгоор олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалттай болсон байна. Ингээж өмнө нь ЮНЕСКО-гийн судалгааны тайланд байна. 50 гаруй орон яг энэ асуудал дээр хуулиа гаргаж баталж байна. Тэгээд Монгол Улс бол ийм цахим дайн, цахим халдлагад бол өртөх ёсгүй.

Ялангуяа энэ дээр Турк, Сингапур, Өмнөд Солонгос, Холбооны Германы жишээ байна. Холбооны Герман гэхэд энэ цахим халдлагатай холбоотой, цахим гэмт хэрэгтэй холбоотой асуудал дээр 50 сая евро хүртэл торгууль тавьсан ийм хууль гаргаж байна шүү дээ.

Гэтэл бид нар бол ингээд хүний эрх гэдэг нэр доор хуулийг мушгин гуйвуулж тайлбарлаж болохгүй. Ерөнхийлөгчийн оруулж ирж байгаа санаа бол энэ хуулийг улам чамбайруул, хэрэглэж байгаа хүмүүсийнх нь юман дээр санал асуулгыг нь асуу, нийгмийн хэлэлцүүлэг явуул, хийгүй чамбай хууль гаргаадах гэсэн болохоос биш энэ хуулийг бүрэн зогсоо гэдэг утга биш гэж ойлгож байгаа.

Тийм учраас Засгийн газар энэ хуулийг дахин оруулж ирж, нэлээн сайн боловсруулж хийхгүй бол ирээдүй хойч үе Монгол Улсын оршин байх аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, үндэстэн хоорондын харилцааны асуудал мөн хүн хоорондын харилцааны асуудал дээр нэлээн томоохон ноцтой зөрчлүүд цаашдаа гарах болно. Энэ Үндсэн хуулиар олгогдсон энэ эрхийг бол бид нар хамгаалах ёстой, төр хамгаалах үүрэгтэй.

Мөн дээрээс нь энэ өнгөт хувьсгалын суурь болдгийг маш олон жишээ харуулж байгаа юм. Зөвхөн Евро майданы үеэр гэхэд Украйская правда гэдэг энэ цахим хуудсанд ханддаг

хүмүүсийн тоо ганцхан сарын дотор 4 дахин өсөж, 4.5 сая болсон.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Би Ерөнхийлөгчийн хоригийг нь хүлээж авах нь зүйтэй гэж бодож байна. Яагаад гэвэл Ерөнхийлөгч хориг тавихдаа энэ хэлэлцсэн байдал, олон нийттэй санал солилцох үйл ажиллагаа нь хангалтгүй явагдсан байна. Ийм учраас энэ талаас нь анхааруулж хориг тавьсан. Түүнээс энэ хуулийн агуулгатай холбоотой ямар ч үг үсэг Ерөнхийлөгчийн хоригт байхгүй. Би ийм хууль байх хэрэггүй, оруулж ирэх шаардлагагүй гэж яриад байгаа хүмүүст энэ хуулийн зарим заалтуудыг бүр зориуд уншиж сануулъя гэж бодож байгаа юм.

Хоёрдугаар бүлгийн 6 дугаар заалтууд байгаа. Зөрчилтэй контент. Сая Энх-Амгалан дарга бас нэлээд хэлчихлээ. Тэгэхдээ олон нийтэд сая бид нар ингээд орон нутгийн жишээ нь Батжаргал бид 2 ингээд сум 27 сумаараа бүгдээрэнг нь явсан. Гол яригдаж байсан хуулиудын нэг энэ. Маш их дэмжлэгтэй байгаа. Ялангуяа агуулгатай холбоотой юмнууд дээр.

Тэгээд би сануулъя гэж бодож байгаа юм. Үндэсний өв ёс, зан заншил, түүх соёлоо гутааж доромжлохоо больцгооё оо. Цахим сүлжээ ашиглаж хулгай хийж залилахаа больё. Хүүхдийн бие махбод, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлж байгаа, дарамт үзүүлсэн, уриалсан, сурталчилсан юмаа больё. Хүчирхийлэл, садар самууныг уриалсан, сурталчилсан юмаа больё. Хүнийг заналхийлдэг, амиа хорлодог, бие махбодод гэмтэл учруулаач гэж уриалж сурталчилж байгаа юмнуудаа больё. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээг уриалсан сурталчилсан юмаа больё. Extremist үйл ажиллагаа явуулж байгаа, үндэсний эв нэгдлээ бусниулж байгаа, төрийн албаны нууцыг задруулж байгаа, террорист үйлдэл хийх

хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг болон үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн шинж агуулсан гэмт хэрэг үйлдэхэд өдөөн турхирсан, уриалсан юмаа больё. Хувь хүн тодорхой бүлгийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шаашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварласан, гадуурхсан, дайсагнуулсан, эвдрэлцүүлсэн, салан тусгаарлахыг уриалсан, ухуулсан ийм юмнуудаа больё л гэж байгаа юм. Оюуны өмчийн эрхийн зөрчилтэй хулгай хийсэн юмаа больё гэж байгаа юм. Гэмт хэрэг зөрчлийн үйлдлийг нарийвчилж заасан яаж хүн алах вэ, яаж хулгай хийх вэ эс үгүй бол ийм юмыг хийхийг уриалсан, өдөөн турхирсан, хатгасан, сурталчилсан, дэмжсэн ийм юмыг больё гэж байгаа юм. Агуулгад нь. Хүүхдийг гуйлга гуйх, тэнэмэл, хараа хяналтгүй амьдрахад татан оруулсан, уриалсан, өдөөн хатгасан, сурталчилсан ийм юмнуудаа л больё гэж байгаа шүү дээ.

Түүнээс хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэхийг хориглосон заалт энэ дээр байхгүй. Чи хэрэв ийм юм та хэрэв ийм юм хийе гэж байгаа бол, үзэл бодлоо чөлөөтэй эрхэлье гэж байгаа бол өөрийнхөө нэрээр ил тод, буруу юм хийсэн байвал дараа нь хариуцлагыг хүлээх боломжтой ийм хэлбэрээр хийцгээе. Тэр Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу чөлөөтэй гэж байгаа юм. Ийм л зүйлүүд байгаа юм.

Агуулгад Ерөнхийлөгч хандаагүй. Хөндөөч үгүй. Дахиад хэлэхэд орон нутгаар сая явахад энэ олон нийтийн дэмжлэгийг хамгийн их авч байгаа ийм хуулиудын нэг байсан шүү. Тэгэхдээ үнэхээр тэр түргэн гаргасан, хэлэлцүүлэг нь дутуу явагдсан энэ дээр бол бидний буруу байгаа. Энийгээ хүлээн зөвшөөрөх ёстой. Энэнийхээ илэрхийлэл болгож бид нар энэ хоригийг хүлээж авах ёстой. Тэгээд Байнгын хороон дээр ч яригдсан юм байна. Сая гишүүдийн дийлэнх нь

ярьж байна. Үг хэлсэн гишүүдийн, санал хэлсэн гишүүдийн. Тэр гүтгэдэг, доромжилдог, энэ саяын хориотой энэ бүх зүйлүүдийг бол өөгшүүлээд явж болохгүй. Олон оронд яг энэ чиглэлээр гаргаж байгаа хуулиудын талаар сая Байнгын хорооны дарга маш тодорхой тоо баримттай ярилаа.

Тэгэхээр бид нар тавьсан хоригийнх нь үндэслэлийг зөв ойлгоод, дахиад хэлэхэд.../минут дуусав./

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Үгүй ээ, энд үгүй ээ, үгүй. Зарим нэг хүмүүс яг хуучин хэвээрээ байгаа юм уу, хаашаа юм. Үгүй тэгээд энэ Засгийн газар чинь 80 оны залуучууд, Ерөнхий сайд нь байж байгаа. Буцаагаад л 1980 он руу нь аваачих гээд байгаа юм уу энэ улс орныг? Хаашаа юм тэгж болохгүй шүү дээ. Энэ иргэддээ яагаад итгэдэггүй юм бэ? Иргэд чинь шал өөр болчихоод байна шүү дээ. Иргэд чинь юутай яаж унших вэ гэдэг чинь өөрт нь бас тийм шүүлтүүр байна шүү дээ. Энэ чинь 30-аад жил ингээд явчихсан. Энийг чинь ялгаж салгаж ойлгоод байдаг болчихсон байна. Яг л нөгөө хуучин шигээ мал хувьчилчихаар бүгдийг нь алаад, Улаанбаатарын балкон дээр авчраад тавьчихна. Орон сууцыг нь хувьчилчихаар бүгдийг нь зараад л гадагшаа гараад явчихна гэж боддоггоо болих хэрэгтэй шүү дээ энэ улсууд. Үгүй, тэр англи хэлтэй улсуудын унших эрхийг нь хязгаарлаад та нар чадахгүй шүү дээ. Бараг залуучуудын 70, 80 хувь нь англи хэлтэй болчихсон байгаа байх. Тэр аппликэйшнүүд чинь өөрөө тохиргоотой шүү дээ. Тэн дээр өөрийнхөө уншдаг юмнуудаа уншаад л байж байна. Үгүй ийм сайн дархлаатай болчихсон болохоор бид нар чинь энэ 2 хөршөөсөө ялгаад байгаа байхгүй юу даа.

Энэ чинь Ардчиллын үнэ цэн чинь үүндээ оршиж байгаа байхгүй юу. Иргэдийгээ битгий бас. Энэ сайн сайхан нэрээр хүний эрх чөлөөг боодог, багладаг

ийм юм байж болохгүй. Одоо манай холбоо харилцаа, цахим сүлжээ бол сүүлийн 10-аад жил маш сайн хөгжсөн салбар шүү дээ.

Яагаад вэ гэхээр төр оролцдоггүй байсан болохоор тэгж хөгжиж байгаа байхгүй юу. Одоо тэгээд яам байгуулаад өгөхөөр л тэр рүү нь давхиад орчихдог, хүмүүсийн юмыг хязгаарлах гээд л эрхийг нь боох гээд л. Өөрсдөө л цэвэр сайхан бай л даа. Өөрсдөө битгий авлига ав л даа. Үгүй, намайг янз янзаар хэлж л байдаг шүү дээ. Би тоодоггүй шүү дээ. Үгүй нэр цэвэр юм чинь яах юм. Юунаасаа та нар ингээд байгаа юм? Өмнө нь ингээд яваад байсан. Ардчилсан улс орныг ардчилсан зарчмаар удирдах эрхтэй нөхдүүд минь. Энэ чинь цаана нь улс эх орны баталгаа явж байгаа. Мэдлэгтэй, мэдээлэлтэй, эрх чөлөөтэй иргэн гэдэг чинь энэ улс эх орны баталгаа болж байгаа байхгүй юу. Тусгаар тогтнолын. Үгүй хар л даа. Жилийн өмнө яадаг байсан. 2 сарын 24-нд Украин, Орос хоёрын цэргийн тусгай ажиллагаа эхэлж байхад л бүгд л намайг нүд үзүүрлээд байсан шүү дээ. Энэ танхим дотор ч гэсэн олигтой дуугарчих хүн байхгүй. Украин Монголын далбаа тавьчихлаа. Энэ мангар эргүү гээд байсан. Наад шиг хүн алга л байна шүү дээ. Нийгэм 70, 80 хувь нь эсрэг байсан.

Одоо 70, 80 хувь нь энгийн номхон иргэдийг буудаж алж болдоггүй юм байна, том гурнууд жижгийгээ эзэлж болдоггүй юм байна, дайрч давшилж болдоггүй юм байна л гэсэн тийм юм толгойд нь суучхаж байгаа шүү дээ. Энэ чинь энэ мэдээллийн л ач тус шүү дээ. Ингэж болохгүй нөхдүүд ээ. Та нарын хүчийг нэгтгэж өгөхөөр ингээд л дандаа буруу юм хийх гээд байх юм. Энэ зөв юм хэлдэг, ярьдаг хүмүүсийн тоо энд бас цөөхөн байна шүү. Ганц, 2 сар чимээгүй болчихоор л тэгээд л хачин болчихсон байж байх юм та нар. Ийм юм байхгүй шүү нөхдүүд минь. Одоо ер нь байнга орж ирж ярина. Ер нь сая тойргоор явж байхад иргэд дуугардаг болчихсон байна

лээ. Ярьдаг болчихсон байна лээ, шал өөр болчихсон байна лээ шүү.

Үнэхээр ардчилсан улс орны иргэд ямар байдгийг харуулж байна лээ шүү. Энэ танхимд бол их сонин болчихоод байгаа шүү. Тэгээд нэг Засгийн газрыг харсан шинжтэй. Засгийн газар одоо сайн ажиллах ёстой, байнга шахах ёстой. Энэ үлдэж байгаа 1 жилд бол энэ Засгийн газрыг сайн ажиллуулах хэрэгтэй. Энэ балай хууль оруулж ирдгийг нь болиулах хэрэгтэй. Буцаагаад 1980 он руу явуулах биш 80 оны залуу тэр 2050 руугаа л явах ёстой шүү дээ. Айн тийм, буцаагаад л 1980 он руу явуулах гээд байдаг. Одоо энэ Учрал, Оюун-Эрдэнэ хоёр. Ингэж болохгүй залуучууд аа. Тэгээд л чаддагаараа 90, 2000 оны.../минут дуусав./

Г.Занданшатар: Гонгорын Дамдинням гишүүн. Дараа нь санал хураалттай гишүүд.

Г.Дамдинням: Энэ дижитал орчныг хянах хуулийг Ерөнхийлөгчийн хориг тавиад орж ирж байна. Мэдээж тэгээд Их Хурал хүлээж аваад, засах залруулах ёстой юм байх шиг байна. Зүгээр энэ олон гишүүд яриад байгаа дижитал энэ орчинд зохицуулалт хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Өөр яг бид нарын бодит амьдрал дээр амьдарч байгааатай ижилхэн зэрэгцээ ертөнц үүсчхээд байгаа байхгүй юу. Мета орчин үүсчихсэн байгаа юм. Фэйсбүүк, Твиттер тэгээд л энэ бүх л социал платформууд цаашаа хөгжөөд л явна. Зохицуулалт хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Зохицуулалт огт байхгүй юу гэж бас хэлж болохгүй. Иргэд төр засгаа шүүмжлэх, хэн нэгний буруутай үйлдлийг шүүмжлэх бүрэн эрхтэй, тэр нь нээлттэй байх ёстой.

Гагцхүү бодит өөрийнхөө дүр төрхөөр л байх ёстой. Энэ дээр ямар асуудал яригдаад байгаа вэ гэхээр компанийн гэрчилгээг хуурамчаар хийх, сургууль төгссөн дипломоо хуурамчаар хийх эсвэл өөрийнхөө паспортыг, гадаад

паспортыг хуурамчаар хийх бол тэртээ тэргүй хууль бус шүү дээ. Pool account гэдэг чинь яг л энэ л байхгүй юу. Хүнээс өөр, өөрөөс нь өөр хуурамч хүн үүсгээд хүн доромжлоод байгаа асуудал яригдаад байгаа шүү дээ.

Тэгэхээр бид нар энийг зохицуулахдаа нэг хүний эрх нөгөө хүний эрх дээр очиж зогсдог. Энэ эрх зүйн зарчим, ардчиллын зарчим дээрээ л суурилоод л бодит хүмүүс өөрсдөө ороод шүүмжилнэ үү, доромжилно уу, энүүгээрээ л явж байх нь нээлттэй болгох зохицуулалтыг л хийх ёстой юм байна лээ л дээ. Энэ асуудал зөвхөн манай асуудал болоод байгаа биш дэлхий даяар л байж байгаа. Сая энэ зарим гишүүд хэлж байна. Германд ч тэр, Японд ч тэр, Европын холбоонд ч тэр яригдаж байна. Америкт ч гэсэн эд яригдаж байна. Өмнөх сонгуулийнх нь үйл ажиллагаанд оролцож нөлөөлсөн асуудал судлагдаад л явж л байна шүү дээ.

Тэгэхээр энэ бид нар их тийм шинэ юмтай дэлхийгээс онцгойроод л, одоо манай Ганбат гишүүний яриад байгаа шиг коммунист аргаар тэмцэх гээд байгаа юм ерөөсөө байхгүй л дээ. Эндээс магадгүй давуу тал олж хэн нэгнийг гутаан доромжилж, улс төрийн давуу тал, эрх мэдлийн давуу тал, онооны давуу тал олдог хүмүүст бол бас их том зэвсэг юм шиг байгаа юм.

Тэгээд энийгээ хамгаалж үлдэхийн төлөө дэвшиж давшигцааж байх шиг байна зарим нь. Тэгээд энийгээ бол бас хүмүүс харж, ялгаж, салгаж байгаа байх. Тэгэхээр энэ хуулийг одоо энэ байгаа хэлбэрээр нь бол төр бүрэн хэмжээнд хянах ч гэдэг юм уу ийм зохицуулалтыг бол оруулах нь мэдээж буруу. Зүгээр иргэд, хүн өөрөө яг бодит дүр төрхөөрөө ороод төр засгаа шүүмжилнэ үү, улс төрчөө шүүмжилнэ үү, дарга нараа шүүмжилнэ үү эсвэл хүн гүтгэнэ үү тэр бол хамаагүй байхгүй юу. Тэгээд тэр хүн гүтгэх, хуурамч бичиг баримт бүрдүүлэх чинь тэртээ тэргүй хуулийн

зохицуулалттай учраас тэр зохицуулалтуудаараа шийдэгдээд явдаг энэ орчныг нь бүрдүүлчихэд л болох юм байгаа юм.

Ер нь бусад улс орнууд яг ингээж л шийдээд явж байгаа. Тэгээд энэ хуулийг дахиж засаж залруулж оруулж ирээд, зайлшгүй зохицуулах шаардлагатай байгаа. Олон улсын жишигт нь тааруулаад хүний эрхийг зөрчихгүйгээр дахиж бид нар энийг хийхгүй бол энэ хүүхдүүд дээр болж байгаа, залуучууд дээр болж байгаа энэ цахим гэмт хэргүүд, тоглоом, цахим тоглоомууд бол бас ядууруулж байна шүү дээ. Хүмүүсийг дампууруулж байна шүү дээ, амиа хорлосон байна шүү дээ. Зөндөө л юм сонсогдож байгаа шүү дээ. Худлаа биш байхгүй юу. Сургуулийнхаа хүүхдүүдийг нүүр царай, хувцас хунар, нийгмийн гарлаар нь доромжилж хэцүү байдал руу оруулж байгаа юмнууд зөндөө л байгаа шүү дээ. Бид нар энэ дээр их харахгүй царайлаад, шударга мундаг хүмүүс болоод дуугүй суугаад байж болохгүй шүү дээ. Зүгээр яг л бид нарын амьдарч байгаа амьдралтай ижилхэн зэрэгцээ орчин үүссэн. Энийг зохицуулах ёстой гэдэг энэ зарчмыг л барих хэрэгтэй гэсэн байр суурийг илэрхийлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь гэж зүйтэй гэж гишүүдийн олонх

үзсэн тул хоригийг хүлээж авсанд тооцлоо.

Ерөнхийлөгчийн хоригийн тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно. Тогтоолыг уншиж танилцуулна. Тэрний өмнө нэг зүйл тодруулж хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Монгол Улсын Засгийн газраас Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг чуулган хаахаас хэдхэн хоногийн өмнө 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Баатарбилиг тэргүүтэй зарим гишүүд яриад байна. Дэг зөрчөөд хэлэлцсэн юм шиг, олон гишүүдийг зөрчөөд санал авахгүй хэлэлцсэн юм шиг. Тэгээд Ерөнхийлөгчийн Тамгын газрын хориг ч гэсэн тийм санаа байна. Тэгэхээр хуулиа зөв хэрэглэх хэрэгтэй. Хууль тогтоомжийн тухай хуульд нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн төсөл мөн Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3.4.1-т, 3.4.3-т заасан асуудлаар хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй, шаардлагагүй гэсэн ийм заалт.

Нэн яаралтай горимоор өргөн барьсан бол дараалал харгалзахгүйгээр хэлэлцэх үүрэгтэй Улсын Их Хурал. Улс оронд нэн яаралтай асуудал тохиолдоно шүү дээ. Бид нар энэ хуулийн заалтаа тэгвэл өөрчлөх шаардлагатай болж байна одоо. Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.8 дахь хэсэгт хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын санаачлах хууль тогтоож тогтоомжийн төсөл энэ Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцсэн эсэхийг хянаад, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно гэж заасан. Энэ хуулийн заалтын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж,

зөвшөөрлөө ирүүлснийг үндэслээд Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор холбогдох хэлэлцүүлгүүдийг явуулаад, бүлгээр хуралдаад үндсэндээ 5 хоног хэлэлцсэн. Тэгээд энэ хууль хэлэлцэж баталсан.

Ер нь цаашидаа тэгэхээр бол хууль тогтоомжийн төслийг санаачлах, боловсруулах, олон нийтийн хэлэлцүүлэг хангах, эрх зүйн дүгнэлт хийн өргөн мэдүүлэхдээ олон нийтэд сурталчлахдаа түүний хэрэгжилтийг зохион байгуулахдаа бол энэ Хууль тогтоомжийн хуулиа яс барихаар тохирлоо шүү. Цаашидаа бол Засгийн газраас, Ерөнхийлөгчөөс, Улсын Их Хурлын гишүүдээс нэн яаралтай горимоор хууль өргөн барихад энэ шаардлагыг бид заавал шаардана би. 3 шаардлагад олон нийтийн энэ тулгамдсан асуудлыг шийдвэрлээгүй, ил тод нээлттэй байх зарчмыг баримтлаагүй, олон нийтийн оролцоог хангаагүй, судалгаа шинжилгээнд үндэслээгүй хуулиудыг өргөн барих асуудлыг хэрвээ хэлэлцүүлэхгүй бол Улсын Их Их Хурлын Тамгын газрыг хууль зөрчиж та нар Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах эрхэнд халдлаа гэж цаашидаа шаардлага тавьж болохгүй.

Гишүүдийн олонх бол энэ хүний эрх, эрх чөлөөг олон нийтэд, сүлжээнд хэрхэн хамгаалах талаарх эрх зүйн харилцааг шинэ тутамд зохицуулж байгаа анхдагч хууль болохынх нь хувьд энэ хуулийг олон тал, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг авч тал бүрээс нь нухацтай хэлэлцүүлж, дахин өргөн мэдүүлэх нь зүйтэй гэсэн ийм саналууд хэллээ.

Ийм учраас энэ дижитал орон зай олон нийтийн сүлжээний зөв хэрэглээ нь хүний эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх шинэ арга хэрэгслийг бий болгож, иргэний болон улс төрийн эдийн засаг, нийгэм, соёлын зэрэг бүх эрхэд эерэг нөлөө үзүүлдэг.

Харин үүний нөгөө талд зарим хэсэг бүлгийнхэн энэ орон зайг гадаад, дотоодоос онлайн дарамт, хүчирхийлэл, доромжлолын талбар болгон буруугаар ашиглах эрсдэл ямар байдаг юм. Сая Нэгдсэн Үндэстний Байгууллагаас эмэгтэйчүүдийн олон улсын эрхийн өдрийг тэмдэглэхдээ эмэгтэйчүүд нийгмийн сүлжээнд хамгийн их хохирч, ялгаварлан гадуурхагдаж байгаа, үүнээс хамгаалъя гэсэн уриатай ийм агуулгатай тэмдэглэсэн. Олон нийтийн сүлжээнд хүүхдийн эрх маш их зөрчигдөж байна. Олон нийтийн сүлжээг буруугаар ашиглах явдал нь тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт, хүний эрхийн зөрчилд хүргэж байгааг анхааралдаа авах шаардлагатайг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хорооноос гишүүн улсуудад сануулж, зөвлөж байна.

Ийм учраас Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ конвенцын хүрээнд цахим орчинд хүний эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зохисгүй доромжилсон, ялгаварлан гадуурхсан, хүний бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц, аливаа төрлийн хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан, уриалсан үг хэллэг, агуулга бүхий зөрчилтэй контентыг хязгаарлах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээнээс залуучууд, өсвөр үеийг хамгаалах, энэ нийгмийн сүлжээнд байгаа цахим луйврын эрсдэлээс, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь төрийн үүрэг мөн.

Ийм учраас төр энэ үүргээ биелүүлж, энэ цахим орчин дахь хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай гэж олон улсын хэмжээнд үзэж байна. Хоригийг хүлээж авахыг олонх дэмжсэн. Тэгэхдээ ер нь энэ агуулга зайлшгүй шаардлагатай гэж гишүүдийн олонх илэрхийлсэнтэй холбоотойгоор Хууль зүйн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Хүний эрхийн үндэсний комисстой хамтраад хэлэлцүүлэг зохион байгуулж,

олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн энэ төслийг шинэчлэн боловсруулах, саналыг нь авах, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлж procedурын алдаагүй боловсруулж, дахин өргөн мэдүүлэхийг чиглэл болгож байна.

Мэндчилгээ дэвшүүлье. Өнөөдөр манай Ганибал гишүүний төрсөн өдөр маргааш болж байгаа. Тэгэхдээ Монгол Улсад орчин үеийн зэвсэгт хүчин байгуулагдсаны 102 жилийн ой, Монгол цэргийн өдөр маргааш тохиож байна. Энэ өдрийг тохиолдуулаад нийт эрчүүддээ Монгол Улсын Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд, тусгай чиг үүрэг бүхий байгууллагын ажилтан, албан хаагчид, чөлөөнд байгаа генерал, офицер, ахмад дайчдадаа улаан залаат хөх Монголын удам залгасан Чингисийн эр цэргүүддээ Монгол Улсын Их Хурлын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье. Бид цэргийн баярын мэндчилгээг дэвшүүлж байна.

Тэгээд энэ өдрийн гол агуулга бол эх орныхоо тусгаар тогтнол, халдашгүй байдлын төлөө, аюулгүй байдлын төлөө тангараг өргөж зүтгэсэн эх орны жинхэнэ эр цэргүүдээрээ бахархаж, хүндлэн дээдлэхэд чиглэгддэг. Эр цэргийн дайчин уламжлалыг үр хойчдоо өвлүүлэх Монгол бахархлыг сэргээхэд чухал ач холбогдолтой. Монгол эх орныхоо дайчин харуул болсон эр цэргүүддээ улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутаг, хил хязгаарын бүрэн бүтэн байдлыг нэр төртэй хамгаалаад ирсэн та бүхэндээ, түүнчлэн улсынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг ард иргэдийнхээ амгалан тайван амьдралыг сахин хамгаалахад үнэлж баршгүй хувь нэмэр оруулсаар ирсэнд талархан тэмдэглэе.

Монгол цэргүүд дэлхийн халуун цэгт энхийг сахиулах үүргээ нэр төртэй биелүүлж байна. Монгол цэргийн жавхааг, хийморийг дэлхий дахин дурсаж байна. Энхийн цагт аюул осол, өвчин

гамшиг, хэрэг зөрчлөөс иргэдээ авран хамгаалах үйлсийг нэр төртэй гүйцэтгэж байгаагаар бид бахархдаг. Эх орноо батлан хамгаалах эрэлхэг цэрэг, хүндэт дайчид та бүхэндээ алтан соёмбот төрийнхөө далбаан дор өргөсөн тангарагтаа үнэнч байж, Монгол цэргийн суу алдрыг эгнэгт бадраан мандуулахыг ерөөлийг өргөн дэвшүүлье. Монгол цэргийн яруу алдар бадартугай.

Энэ өдөр төрсөн Их Хурлын гишүүндээ мэндчилгээ дэвшүүлье. 3 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибал эхээс мэндэлжээ.

Наянтайн Ганибал Гочоогийн Наянтайн, Содовын Нарангэрэл нарын отгон хүү болж энэ үед эр цэргийн баярын өдөр эхээс мэндэлсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибал танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. Төрсөн өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Ингээд дараагийн асуудалд оръё. Тогтоолоо танилцуулна. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1-дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурал 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон хамт баталсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Дараагийн асуудалдаа оръё.

11.45 цаг

Хоёр.Олон улсын нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс олон улсын иргэний нисэхийн тухай конвенцод 1989 онд нэгдэн орж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 162 дахь гишүүн болсноор энэ байгууллагын бодлого, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, гэрээ конвенцод нэгдэх, аюулгүй ажиллагааны аудитад хамрагдах зэргээр гишүүний үүргээ биелүүлж олон улсын агаарын тээвэр, агаарын навигацийн үйл ажиллагааг өргөжүүлсээр ирсэн билээ.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 2016 оны 39 дүгээр ассамблей чуулганаар олон улсын иргэн нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг баталж, зөвлөлийн гишүүн 36 орныг 40 болгон нэмэгдүүлсэн.

Зөвлөлийн гишүүн улсуудыг агаарын тээврийн салбарт тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг, агаарын навигацид их хувь нэмэр оруулдаг, газар зүйн болон голлох бүс нутгийн төлөөлөл гэсэн 3 ангиллаар ассамблейгаас 3 жилийн хугацаатай сонгодог.

Протокол нийт 128 гишүүн улсад нэгдсэнээр хүчин төгөлдөр болох бөгөөд өнөөгийн байдлаар 80 улс нэгдэж соёрхон батлаад байна. Монгол Улс багтдаг Ази, Номхон далайн бүсээс 7 улс буюу Австрали, Хятад, Япон, Энэтхэг, Сингапур, Малайз, Өмнөд Солонгос улсууд зөвлөлийн гишүүнээр 2022 онд сонгогдсон. Монгол Улс энэхүү протоколыг соёрхон баталснаар зөвлөлийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх олон улсын санаачилгад хувь нэмрээ оруулж, цаашид олон улсын иргэний нисэхийн байгууллагын бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд оролцох, зөвлөлийн гишүүнээр сонгогдоход дэмжлэг болох юм.

Протоколыг соёрхон баталснаар улсын төсвөөс нэмэлт зардал гаргахгүй, шинээр хууль боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлага үүсэхгүй юм. Олон улсын иргэн нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн түр хорооны дарга Энхтайвангийн Бат-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Э.Бат-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78

дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Баделхан баруун аймгууд руу нисэх тийзийн үнэ хэт өндөр байгаа тул үнийг бууруулах боломжтой эсэх, Баян-Өлгий аймгийн нисэхийн барилгын өргөтгөлийн ажил хэдийд эхлэх талаар ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, хариулт авсан бөгөөд гишүүд үг хэлээгүй болно.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, 72.7 хувийн саналаар соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Сандагийн Бямбацогт Зам, тээврийн хөгжлийн сайд, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхээгийн Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Чимэддоржийн Мөнхтуяа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Гүррагчаагийн Батбаяр.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Тогтохсүрэн гишүүнээр тасаллаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Энэ конвенцтой холбоотой болоод, иргэний нисэхтэй холбоотой энэ 2 асуулт байгаа юм. Олон улсын конвенцод нэгдэнэ гэдэг дээр дараа нь бас их олон асуудлууд гардаг. Яг энэ нисэхийн конвенцод нэгдсэнээр энэ нь олж авч байгаа давуу тал нь юу юм, бас гарч болох сул тал ер нь юу юм? Яг ярихад бол зөвхөн ямар ч сул талгүй, давуу талтай л гэдэг л зүйл яригддаг. Дараа нь бас яг ер нь энэ олон улсын энэ гэрээ хэлэлцээрүүдэд нэгдсэнээр бас олон асуудлууд гарсан зүйл бас дараа яригддаг.

Хоёрдугаарт нь өнгөрсөн оны 12 дугаар сард “Эрчис ойл” гээд төрийн өмчит нисэхийн шатахуун хангамжийн компани байгуулагдсан, төрийн өмчит компани байгуулагдсан. Энэ компанийн үйл ажиллагаа болоод тэр үед яригдаж байсан ажлын үр дүн нь өнөөдөр ямар байна вэ? Олон улсын энэ нисэх онгоцнуудыг цэнэглэх, дотоодын нисэх онгоцнуудыг цэнэглэх ингэснээр билетийг нь, замын зардлыг нь хөнгөлөлт үүснэ гэдэг ийм хүлээлт тухайн үед яригдаж, төрийн өмчит компани байгуулагдаж байсан. Бид бүгдийн хувьд ч гэсэн Ардчилсан намын талаас бол төрийн өмчит компани байгуулах нь буруу гэдэг байр суурьтай оролцож байсан.

Тэгэхээр нэгэнт энэ асуудал орж ирсэн Зам, тээврийн сайд байгаа дээр энийг тэр саяхан батлагдсан хуулийн үр дүнгийн талаар та бас мэдээлэл өгөөч.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн, сайд хариулах уу?

С.Бямбацогт: Олон улсын иргэний нисэхийн байгууллагууд 1944 онд олон улсын иргэний нисэхийн тухай конвенц гэж байгуулсан юм байна лээ. 1944 онд. Одоогийн байдлаар энэ конвенцод дэлхийн 193 улс нэгдсэн. Монгол Улс 1989 онд энэ конвенцод нэгдэж орсон. Үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ конвенцын хүрээнд үндсэнд олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагууд агаарын

тээвэрлэгч компаниудын нисээж байгаа онгоцнуудын нислэгийг зохицуулдаг дэлхийн хэмжээнд нэгдсэн бодлого зохицуулалтаар удирдаж ингээж ингэдэг ийм зорилготой байгууллага.

Энэ байгууллагыг бас жил болгон удирддаг тийм зөвлөл гэж байдаг. 3 жилийн хугацаатай томилогддог. Энэ зөвлөл нь бол тус байгууллагын тогтвортой үйл ажиллагааг хангах буюу олон улсын иргэний нисэхэд мөрдөх стандартуудыг мөрдүүлэх бас зөвлөмжүүд батлах гаргах. Мөн бас олон улсын иргэний нисэхийн байгууллагын санхүүг захиран зарцуулах, агаарын тээврийн хороо, Агаарын навигацийн үйлчилгээний хороо, Санхүүгийн хороо, хууль бус үйл ажиллагааны хороо, Техникийн хамтын хороо гэсэн олон хороодыг бас удирдаж энэ олон 193 улсын агаарын тээврийн иргэний нисэхийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангадаг ийм байгууллага юм байна лээ.

Энэ байгууллагын зөвлөл нь 36 гишүүнтэй байсан. 36-тай гишүүнтэй байсныг нь 40 болгож нэмэгдүүлэх ийм шийдвэр 2016 онд гарсан. Энийг дэмжээд дэлхийн 193 улсаас 80 улс нь конвенцыг баталчихсан байгаа юм. 128 улс баталчих юм бол энэ конвенцод үндсэндээ 36 улсаас 40 болж нэмэгдэх юм байна лээ. Энд л үндсэндээ Монгол Улс бас өөрийнхөө энэ конвенцыг гишүүн орныхоо үүргээ биелүүлж элсэхээр ийм зорилго тавьж байгаа. Үндсэндээ бол олон улсын иргэний нисэхийн байгууллага бол бас навигацийн байгууллага шүү дээ. Та бүхэн мэдэж байгаа байх. Энд нэгдэж ордог. Үүргээ л биелүүлж элсэх, энэ конвенцыг батлах гэж байгаа юм. Зорилго бол. Сул тал гээд асуудлууд яригдахгүй байх. Дэлхий нийтээр хүлээсэн, дэлхийн хамтын нийгэмлэгийн байгууллагууд Монгол Улс олон улсын гэрээгээр нэгддэг. Энэ гэрээнийхээ үүргийн хүрээнд л нэгдэж байгаа. Ямар нэгэн эрсдэл сул тал гарахгүй гэж харж байгаа.

Хоёрдугаар асуулт. Газрын тосны тухай хуулийн 7.2-т өөрчлөлт оруулсан. Үүнтэй холбоотойгоор ер нь бол агаарын тээврийн шатахууны үнийг хямдруулах зорилгоор “Эрчис ойл” компанийг байгуулсан. “Эрчис ойл” компани маань санхүүгийн хувьд бас жоохон үйл ажиллагаа бас доголдолтой байгаа. Мөн бас бид дэмжээд Газрын тосны тухай хуулийн 7.2-т өөрчлөлт оруулаад газрын тосны бүтээгдэхүүнээ зөвхөн давамгайл байдалтайгаар зөвхөн дотоодын компаниуд нийлүүлдэг байсан бол бас гаднын оролцоотой компани нийлүүлж болох хуулийн зохицуулалт хийсэн.

Энэ хүрээндээ бид нар бас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, дээрээс нь тэр “Эрчис ойл” компани, Ашигт малтмал, газрын тосны эрхлэх газрыг бас шахаж байгаа. Нөгөө шатахууны үнэ хямдрахгүй байна хямдруул аа. Анх бол 7.2-ыг батлуулах үедээ ярьж байхдаа Сингапурын биржийн үнээс 260 доллароор хямд шатахуун Монгол Улсад нийлүүлнэ гэж ярьж байсан. Яг өнөөдрийн байдлаар яг ийм хүрээгүй байгаа. Урьд нь бол өнгөрсөн зун, өнгөрсөн намар бол Сингапурын биржийн үнээс үндсэндээ 500-600 долларын үнэтэй шатахуун манай дотоодын агаарын тээвэрлэгч компаниуд хэрэглэдэг байсан бол одоо Сингапурын биржийн үнийн ойролцоо болсон байгаа.

Гэхдээ биржийн үнэ арай хүрээгүй байгаа. Энийг үндсэндээ ийм үнээр шатахуун нийлүүлээч гэсэн шаардлагыг бас Зам, тээврийн хөгжлийн яам бас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон бас газрын “Эрчис ойл” компани бас шаардлага тавьж ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууна.

О.Цогтгэрэл: Тэр шатахууны үнээс хамаараад нислэгийн тийз хямдрах гэдэг асуудлыг хууль орж ирж байхад маш их тодорхой зүйлүүдийг ярьж байсан. Жишээ нь ажлын үр дүнгийн тухай л

асуугаад байна л даа. Одоо 12 сард батлагдсан өнөөдөр 3 дугаар сарын дундуур болж байна. Бас эхний үр дүнгүүд, тэр тусмаа яг энэ зөвхөн энэ түүхий эд гэдэг чинь хөрөнгө оруулалт баахан юм хийх гэж байгаа биш үр дүнгүүд гарчихсан баймаар байна. Дахиад л яг төрийн өмчит компани байгуулаад ямар нөхцөл байдал ямар үр дүн гардаг вэ, дахиад яг ямар тайлбарууд явдаг вэ энэ жишээ л бараг саяын наадах дээр чинь л харагдаж байна л даа. Яг үр дүн байхгүй. Төрийн өмчит компани байгуулагдсан. Бодвол баахан төрийн албан хаагч тэнд бий болсон л байгаа. Яг нөгөө яриад байсан үр дүн маань хэдэн хувь ч билээ бараг шатахууны зардал нь 30 хувь, нийт тийздээ тодорхой хувиар нөлөөлнө л гэж байсан. Өнөөдөр ямар ч үр дүн байхгүй ийм л байдалтай байгаа юм байна.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Үр дүн байхгүй гэж хэлж болохгүй Цогтгэрэл гишүүн ээ. Үр дүн байгаа. Би түрүүн хэллээ шүү дээ. Хууль батлахын өмнө бол Сингапурын биржийн үнээс 500-600 долларын үнэтэй шатахуун Монголын агаарын тээврийн компани хэрэглэж байсан бол одоо Сингапурын биржийн үнийн орчимд үнэтэй шатахуун болсон байна. Энэ бол нэг үр дүн. Үүнтэй холбоотойгоор онгоцны нислэгийн тийзүүд хямдарсан. Сөүлийн чиглэлд 2 сая 500-гаар билет авдаг байсан 2 талдаа 1 сая 200 мянга болсон. 2 дахин буурсан. Тийм, Туркийн чиглэл, Станбулын чиглэлд 4 сая 500 байсан бол 2 сая 500 болсон.

Гэхдээ мэдээж тийзийг урьдчилж 2 сарын өмнө сарын өмнө авах юм бол хамгийн хямд тийз авч байгаа, тулгаад авах юм бол өндөр үнэтэй тийз авч байгаа. Энэ бол олон улсын агаарын тээврийн компаниудын барьдаг нийтлэг зарчим. Монголчууд маань маргааш явна гэж билет аваад харьцангуй өндөр үнэ билет авчхаад буугаагүй байна гэж ярьж байгаа боловч яг урьдчилаад төлөвлөөд

сарын өмнө авах юм бол хямд тийзийн үнэ хямдарсан, хямд хийж авах бололцоотой болсон байгаа гэдгээ бас хэлье.

Г.Занданшатар:

Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

Н.Ганибал: Энэ конвенцод энэ соёрхон баталж байгааг дэмжиж байна. Тэгээд ер нь Монголын нисэх салбар гэхээр МИАТ-аар ингээд Монголын ард түмэн төсөөлдөг. Олон улсад МИАТ ингээд манай агаарын гол авиа компани болоод харагддаг. Бид нар ер нь нисэх салбар гэхээр МИАТ гэдэг нэг ойлголттой ингээд яваад байгаа юм. Тэгээд Бямбацогт сайд болсноос хийсэн хэд хэдэн асуудал байгаа. Маши талархууштай. Нисэхийн авиа компаниуд нислэгийг либералчлах энэ асуудал дээр онцгой анхааран ажиглаж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхлээр зэрэг Байгаль орчны сайд таны өмнөөс яриад яваад байна лээ шүү. Тэр хийх хийх ёстой асуудлуудаа хийгээд яваарай тэр Байгаль орчны сайд. Аялал жуулчлалын сайдын ажил биш. Танай салбарын ажилд энийг хийж байгаа гэж ойлгож байна. Бас сая тэр тийзийн үнийн асуудал яригдаад байна л даа. Энэ дээр мэдээж 2 асуудал байгаа.

Нэгт нь шатахууны асуудал байгаа.

Хоёрт нь тэр либералчилсан олон авиа компаниуд нислэг хийж байгаатай холбоотойгоор л үнэ буурч байгаа. Өрсөлдөөн. Тэгэхээр бид нарын хувьд бол аливаа асуудлыг шийдэх хамгийн том гарц бол мэдээж энэ зах зээлийн энэ цаг үед чөлөөт өрсөлдөөнөө л бид нар дэмжих ёстой. Бүгдэд нь боломж олго. Тэр бензин шатахууны тухай асуудал дээр зөвхөн нэг компанид, бас компанид зориулсан хууль батлахаа хэдүүлээ бас болимоор байгаа юм. Дараагийн удаа тэр “Эрчис ойл” гэнэ үү тэр “Сод Монгол” гэнэ үү бүгдээрэнг нь биш, тэр 2-т зориулсан биш бүх шатахуун түгээх тэр

боломжууд импорт хийж байгаа аж ахуйн нэгжүүдэд тэр боломжийг нь олго. Ингээж байж илүү их бид нар боломжоор нээнэ. Энэ ч сая харагдаж байна.

Тэгэхээр 1 удаагийн тэр хууль маань 1 компанид зориулсан хууль маань буруу байна. Тэрийгээ улам сайжруулаад бүгдэд нь нээлттэй болгох энэ боломжийг нээж өгөх зайлиггүй шаардлагатай.

Хоёрт нь Иргэний нисэхийн авиа компанийн нүүр царай болоод байгаа тэр МИАТ гэдэг компани хувьчил. Энийг яаралтай хувьчил. Хувьчилж байж бид нар өрсөлдөөнөө улам сайжруулна, нэмэгдүүлнэ. Өнөөдөр Монголын бас үндэсний дотоодын авиа компаниуд бий болчихлоо. Изинис гэнэ үү, Хүннү гэнэ үү? Тэгээд бусад компаниуддаа бас боломж олгох өрсөлдөөнийг нь улам чөлөөтэй болго. Ийм л асуудал байна.

Тэгэхээр энэ тал дээр таны бодол, санаа бас юу байна вэ гэж сонсмоор байна.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт Зам, тээврийн хөгжлийн сайд.

Н.Ганибал: Ганибал гишүүнтэй санал нэг байна. Ер нь зах зээлийн зарчмаараа бизнес үйл ажиллагаа хөгжиж явах ёстой. Төр бол үнэтэй боломжийг л бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүд иргэдэд олгож байх ёстой. Боломжийг. Төр гацаадаг, саатуулдаг, хүнд суртал гаргадаг байгууллага байх ёсгүй. Төрийн албан хаагч, төрийн үүрэг үндсэндээ иргэн аж ахуйн нэгжүүддээ явал боломжийг бий болгож, өрсөлдөөнийг дэмжих вэ? Хүн болгон тэгш боломжийг олгож, өрсөлдөөнийг дэмжих ёстой. Энэ агаарын тээврийн салбарт үндсэндээ энэ бодлогыг хэрэгжүүлж байгаа.

Урьд нь нислэгийн томилгоог ганц ганцаар нь авиа компаниудтай уулзаад нэг нэгээр олгодог байсан бол иргэний

агаарын тээврийн 5 авиа компани 5-уулаа ярьж байгаад бид 5 ингээж ойлголцлоо, ингээж тохирлоо, ийм томилгоо бид хүсэж байна гэж орж ирдэг болсон. Ингээд үндсэндээ хүссэн томилгоо нь шууд өгдөг болсон. Үндсэндээ өөрсдөө шийддэг болсон. Энэ хүрээндээ үндсэндээ Монгол Улсаас гадагшаа нисэх нислэгүүдийн тоо, нислэгийн цэгүүдийн тоо нэмэгдсэн. Онгоцны тоо нэмэгдсэн. Ийм байдлаар үндсэндээ урьд нь МИАТ гэж ганцхан компани илүү давуу эрхтэй, илүү монопол төрийн өмчит компани учраас, үндэсний агаарын тээвэр учраас энэ компанийг дэмжих ёстой гэсэн бодлого явдаг байсан бол одоо өрсөлдөөнийг бий болгоод үндсэндээ бусад авиа компаниуд маань хөгжиж байна.

Мөн бас гадаадын авиа компаниуд Монголд бас нисэх бололцоо боломж нээгдэж байгаа. Оросын Холбооны Улсын 2 авиа компаниас чинь зөвшөөрөл авлаа. Туркийн авиа компаниас зөвшөөрөл авлаа. Солонгосоос ганцхан KAL нисдэг байсан бол одоо 3 авиа компаниуд нисдэг боллоо. Ийм байдлаар үндсэндээ өрсөлдөөнийг дэмжиж байж билетийн үнэ буурч байна. Өрсөлдөөнийг дэмжиж байж нислэгийн тоо нэмэгдэж байгаа. Энэ бодлогоо цаашид нь явуулна. Урьд нь Америкийн Нэгдсэн Улсууд ч гэсэн 2002 оноос хойш “Open sky” хэлэлцээр ярьсан юм байна лээ. Хийдэггүй. Яагаад гэвэл энэ “Open sky” хэлэлцээр хийчих юм бол иргэний агаарын тээвэрлэлт үндэсний компанидаа бас сөрөг болчихно. МИАТ-д сөрөг болчихлоо гэдэг байдлаар 20-иод жил дарчихсан. Уул нь иргэд Америкийн Нэгдсэн Улс руу хямд тийзээр хурдан хугацаанд шууд нисэх сонирхол байгаад байдаг.

Гэтэл бид нар үндэсний компани хамгаалах ёстой гэсэн бодлого явуулаад ийм удчихсан ийм байсан. Тэгвэл энэ асуудал шийдэгдээд явж байгаа. Иймэрхүү байдлаар бид нар цааш цаашидаа өрсөлдөөнийг дэмжсэн бодлогыг явуулна. Ганцхан үндэсний агаарын

тээвэл биш МИАТ компанийг ганцхан ялгаж дэмжинэ гэсэн бодлогыг цаашидаа баримтлахгүй.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Байнгын хорооны саналаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Эцэслэн батлах санал хураалт Дэгийн тухай хуулийн 44.2-т заасны дагуу нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцно гэж заасны дагуу нийт гишүүдийн олонхоор буюу 39-өөс дээш гишүүн дэмжиж байж энэ хууль батлагдана. Тамгын газар, бүлгүүд, бүлгийн удирдлагууд ирцээ бүрдүүлнэ үү. Нийт гишүүдийн олонхоор хуулийг батлан батална.

Хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Баасан гаргийн 10 цагт батлах бөгөөд хэрвээ шаардлагатай гэвэл бусад тохиромжтой цагт баталж болно гэсэн ийм эцэслэн батлах санал хураалтын заалттай. Тийм учраас дараагийн асуудлыг хэлэлцээд тэгээд нэг мөр энэ 2 хуулийг эцэслэн батлах санал хураалт явуулъя. Дараагийн асуудалд оръё.

12.02 цаг

Гурав.Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Энэний дараа нийт гишүүдийн олонхоор хууль батлах

тул гишүүдийг санал хураалтад чуулганы танхимд урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Олон улсын иргэний нисэхийн байгууллага нь агаарын навигацийг өргөжүүлэн гишүүн улсуудын санаачилгыг дэмжиж, 2016 оны 39 дүгээр ассамблейн чуулганаараа олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг баталж, Агаарын навигацийг комиссын гишүүний тоог 19 байсныг 21 болгон нэмэгдүүлсэн.

Агаарын навигацийн комисс нь олон улсад агаарын навигацийн хөгжүүлэх бодлого тодорхойлох, мэдээлэл цуглуулах, стандарт шаардлага тогтоох, зөвлөмж боловсруулах, техник технологийн асуудлаар дэд комисс томилон ажиллуулах зэргээр олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөлд зөвлөгөө өгөх үүрэгтэй байнгын ажиллагаатай комисс юм.

Уг комиссын бүрэлдэхүүнийг гишүүн улсаас нэр дэвшүүлсэн иргэний нисэхийн салбарын шинжлэх ухаан, практик ажлын зохих туршлага, мэргэжилтэй хүмүүсийн дотроос зөвлөлийг сонгон шалгаруулж томилдог.

Протокол нь гишүүн орны гуравны хоёр буюу 128 улс нэгдсэнээр хүчин төгөлдөр болох бөгөөд өнөөдрийн байдлаар 80 улс нэгдэн ороод байна. Монгол Улс энэхүү протоколыг соёрхон баталснаар агаарын навигацийн комиссын үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах, цаашид олон улсын иргэн нисэхийн байгууллагын агаарын навигацийн өргөжүүлэх, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд оролцох мэргэшсэн хүний нөөцийг комиссын бүрэлдэхүүнд ажиллуулах боломж бүрдэхийн зэрэгцээ бүс нутгийн агаарын навигацийн гол түшиц орон зай болох олон улсын нисэх буудлуудын

ашиглалтыг сайжруулах агаарын тээвэр өргөжин хөгжихөд дэмжлэг болно гэж үзэж байна.

Протоколыг соёрхон баталснаар улсын төсвөөс нэмэлт зардал гарахгүй шинээр хуулийн төсөл боловсруулах нэмэлт, өөрчлөлт оруулах болгон хүчингүй болгох шаардлагагүй юм.

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд өмнөхтэй мөн адил овог нар, ажил, албан тушаал. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд? Гочоогийн Ганболд гишүүн. Энийг хүчингүйд тооцлоо. Санал, хураалт байхгүй.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын Гишүүн, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал хариуцсан түр хорооны дарга Энхтайвангийн Бат-Амгалан танилцуулна. Индэрт урж байна.

Э.Бат-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн Монгол Улсын авто замын хэвтээ тэнхлэгийн зүүн чиглэл болох Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн хатуу хучилттай замын Цагаан хоолой гэдэг газрын нийт 50 километр замыг улсын комисс хүлээж аваагүй. Замын эвдрэл, гэмтэл их байгаагаас шалтгаалан иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө эрсдэлд орж байгаа тухай, Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин 2022 онд Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрдөг нислэг буурснаас үүдэн навигацийн ашиг орлого буурсан эсэхийг ажлын хэсгээс тодруулж, асуулт асуусан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн Дорнод аймгийг Улаанбаатар хот бусад аймагтай холбох улсын чанартай гол замын чанар стандартад анхаарч ажиллах тухай, Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан Говь-Алтай аймгийн Цээл сумын нутгаар дайрах агаарын хаалгыг нээх. Дундад азаар дамжин зүүн хойд зүгт Хятадын Шинжаан Уйгар, Манжуурын чиглэлд болон Хайнань, Шанхайн чиглэлд МИАТ хязгаарлагдмал хариуцлагатай компаниас нислэг хийх тухай асуудлыг анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн болно.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, 75 хувийн саналаар соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Одоо асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Тогтохсүрэн гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүнээр хаалаа. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Бямбацогт гишүүнээс 2 зүйлийг тодруулъя. Энэ иргэний нисэхийн энэ навигацийн орлого гэж байгаа. Энэ навигацийн орлогын асуудал ер нь ямархуу байгаа вэ? Тэр аялал жуулчлалын хууль яригдаж байх үед энэ олон улсын нислэг болон дотоодын агаарын тээвэрлэлтийн үнэ тарифыг хямдруулна гэсэн. Түүнчлэн улсын төсөв батлагдаж байх үед баруун аймгуудад улсын төсвөөс татаас өгс өгнө гэдэг ийм асуудал ярьж энэ хууль батлагдсан гэж ойлгож байгаа.

Гэтэл өнөөдөр энэ навигацийн орлого чинь хаашаа орж байгаа нь ч мэдэхгүй, мэдээлэл байхгүй, дээр нь энэ үнэ хани нь ингээд бууруулахгүй байгаа асуудал нь энэ ямар асуудал байна? Энд ямар эрх ашиг ингээж үйлчлээд байна? Улсын төсвөөс ингээд санаачлаад ингээд оруулаад, өнөөдөр тэр татаас өгнө гээд навигацийн орлого бусад зүйлээс энэ хувийн компаниуд руу энэ мөнгө төгрөгийг төсвийн хуулиар ингээд шийдсэн байх тухай бид бүгдээрээ мэдэж байгаа.

Гэтэл өнөөдөр энэ авиа компаниудын чинь үнэ хани яагаад буудаггүй юм бэ? Энд ямар ашиг сонирхол байна?

Хоёрдугаарт нь Ховд аймгийн нисэх буудлын менежментээр хувьчилна гэдэг ийм асуудал яригдаад байна. Энэ ямар бодлогын үүднээс энийг хувьчилж хэн авах гээд байгаа юм? Энд тодорхой янз бүрийн мэдээлэл яваад байх юм. Энэ салбар хариуцсан сайдын хувьд, Ховд аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний хувьд энд албан ёсны хариулт сонсмоор байна.

С.Бямбацогт: *Адъяаа гишүүн энэ навигацгийн орлого ордог газраар руугаа орж байгаа, орж байгаа. Юм алга болоогүй тийм. Хэн нэгний карма руу ороогүй. Та санаа зоволтгүй байж болно, та бас шалгуулж болно.*

Навигацгийн орлого буурсан. Навигацгийн орлого яагаад буурсан бэ гэхээр Оросын Холбооны Улс, Украин дайнтай холбоотойгоор буурсан. Үндсэндээ 2019 оны эхний 2 сард улсын төсөвт навигациас Монгол Улсад 21 тэрбум төгрөг орж байсан бол 23 оны эхний 2 сарын байдлаар 6 тэрбум төгрөг буурсан байгаа юм. 2022 онд навигацгийн орлого 100 гаруй тэрбум төгрөг Монгол Улсад орсон. 2019 онд 300 гаран тэрбум төгрөг орж байсан. Ингээд үндсэндээ бол энэ юутай холбоотой вэ гэхээр энэ дайнтай холбоотойгоор Монгол улс дээгүүр нисдэг нислэгийн тоо огцом буурсан юм. Оросын Холбооны Улс дээгүүр, Монгол дээгүүр нисээд цааш нь Оросоор дамжаад Өмнөд Азиас Хойд Америк руу нисдэг байсан. Энэ олон нислэгүүд буурсантай холбоотойгоор навигацгийн орлого нэлээн буурсан. Энийг та бас ерөнхийдөө нээлттэй байгаа энэ мэдээлэл.

Навигацгийн орлого буурснаас шалтгаалаад үндсэндээ иргэний нисэхийн байгууллагын үйл ажиллагаа нэлээн хүндрэлтэй бас байгаа. Энийг танд 1 дүгээрт нь хэлчихье.

Хоёрдугаарт нь онгоцны тийзийн үнэ буулгах талаар түрүүн би бас асуултад хариулсан. Ер нь гадаад нислэгүүд дээр онгоцны тийз нэлээн буурсан. Сөүлийн чиглэлд 2 сая 500 байсан бол сая 200 орчим болж буурсан. Турк Станбулын чиглэлд 4.5 сая байсан бол 2.5 сая болж буурсан. Иймэрхүү гадаад нислэгүүд дээр нислэгийн тоо нэмэгдсэн.

Дээрээс нь онгоцны тийзийн үнэ буурсан байгаа. Дотоод нислэгүүд дээр харьцангуй буурахгүй байна. Буурахгүй байна. Энэ дээр бас Монгол Улсын

Засгийн газар, манай Зам, тээврийн хөгжлийн яам нэлээн анхаарч ажиллаж байгаа. Тодорхой хурдан хугацаанд буулгах талаар өнгөрсөн жил Улсын Их Хурлын бас төсөв батлахдаа бас энийг буулга гэсэн Улсын Их Хурлын тогтоол гарсан. Үүнийг хэрэгжүүлэхээр бас Монгол Улсын Засгийн газар ажиллаж анхаарч ажиллаж байна.

Ер нь дотооддоо бас нислэг сэргээх ёстой. 2012 онд 11 аймаг руу онгоц шууд Улаанбаатараас нисдэг байсан. Одоо бол үндсэндээ 2, 3-хан аймаг руу нисдэг болж буурчхаад байгаа юм. Дотоодын нислэг үндсэндээ уналтад орчихсон. Нисэхдээ маш өндөр үнэтэй нисэж байгаа юм. Ховд, Баян-Өлгий рүү бол 1000000-1500000 хүртэл өндөр үнэтэй нисэж байгаа. Энийг бас буулгах талаар тодорхой шийдлүүдийг бид бас ярилцаж байгаа.

Авиа компаниуд маань 2 нисэж байгаа. “Хүннү”, “Аэро Монголиа” 2 авиа компаниуд үндсэндээ Оюутолгойн чиглэл хэт их нисээд, ашиг хөөгөөд, дотоод нислэгийг бас хийхгүй байна. Тийм учраас бид МИАТ компанийг сонгон оруулж ирж, дотоодын нислэг бас ашиглахаар бас үндсэндээ ийм бодлого барьж байна.

Мөн бас онгоцны нислэгийн тийзийг хэрхэн бууруулах талаар бас Засгийн газар дээр ажлын хэсэг гараад, буулгах талаар ажиллаж байгаа гэдэг танд хэлье. Ойрын үед бас буулгах бодолтой, буучих байх гэж найдаж байгаа.

Ховдын нисэх буудлыг хувьчилна гэж байна, хэн авах гээд байна вэ бас тодорхой мэдээлэл байгаа гэж байна. Мэдээлэл байгаа байх танд. “Areo Mongolia” компани бас авъя гэсэн санал тавьж байгаа. Тэгвэл энэ үүнийг “Areo Mongolia” компани шууд хуйвалдаад янз янзын байдлаар өгчихгүй гээд, давуу эрхээр нь олгочихгүй.

Зөвхөн Ховдын нисэх буудал биш Ховд, Дорнод, Хөвсгөл, Өмнөговь гэсэн 4 аймгийн нисэх буудлыг төр хувийн хэвилийн түншилэлийн хүрээнд концессоор хувьчилъя гэдэг асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яам Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам Засгийн газраас энэ асуудлыг ярьж байгаа. Ганцхан олон улсын буудалтай биш, 4 хойд, урд зүгтээ баруун, зүүн бүстэй бас олон улсын нисэх буудалтай болъё. Ингэхдээ Монголын төрд Монгол Улсад энэ Засгийн газарт мөнгө байхгүй учраас хувийн хэвилийнхэнтэй хамтраад, нисэх буудлуудыг бас олон улсын болгоё бас олон чиглэлд нисдэг болгох ийм бодлогын хүрээнд явж байгаа.

Энэ дээр үндсэндээ концессын тендер зарлагдана. Үүнд хамгийн сайн санал, хамгийн сайн нөхцөл тавьсан улсуудад энэ онгоцны буудлыг төр хувийн хэвилийн түншилэлийн хүрээнд ВОТ нөхцөлөөр олгох ийм асуудлууд яригдана гэдгийг танд бас хэлье.

Г.Занданшатар: Тогтохсүрэн гишүүн асууя. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн тодруулж асууя.

Ш.Адьшаа: Энэ улсын төсөв батлагдаж байхад энэ татаасны мөнгө тавьсан гэж ойлгоод байгаа хэдэн төгрөг тавьсан юм бэ? Энэ яагаад энийг тэр мөнгө судалж байгаа л гэж яриад байх юм. Бид нар чинь санал оруулаад, төсөвт тодорхой хэмжээний татаас суулгасан байх дутагдаад байгаа юм. Энэ талаар хариулт авъя.

Дээр нь бол энэ тэр нисэх буудлын хувьчлалын асуудал энэ тэр дээр бас нэлээн бас асуудал байгаа байх гэж би бодож байна. Энэ дээр бол хэдийгээр төр хувийн хэвилийн асуудал байгаа ч гэсэн энэ дээр бас цаашидаа бол яах вэ гэдгийг иргэд, олон нийт, салбарынхантай бас сайн ярьж, шийдэх л асуудал. Шийдлийг л олох ёстой байх л гэж ийм бодолтой байна. Тэр талаар хариулт нэмж авъя.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Орон нутгийн нислэг сэргээх чиглэлээр улсын төсөв баталж байх үед бид нар хэлэлцэж байх үед бол 9 тэрбумын татаас өгчхөөч энүүгээрээ бид нар орон нутгийн иргэдийг хөнгөлөлттэй үнээр нисгэе гэдэг саналыг бас Улсын Их Хурлын гишүүд, миний бие ч гэсэн гаргаад ингээд явсан. Харамсалтай нь Их Хурал дээр олонхын дэмжлэг аваагүй. Хэрвээ тэр татаасыг шийдсэн бол орон нутгийн иргэд маань хямдралтай үнээр нисдэг, түүнийгээ дагаад орон нутагт нислэг сэргээд мөн гадаадын жсуулчдаас орон нутаг нисэх бололцоо, боломж бүрдэнэ гэсэн шийдлийг бид оруулсан боловч Их Хурал дээр дэмжлэг аваагүй. Тийм учраас татаас мөнгө тавигдаагүй гэсэн үг.

Нисэх буудлын тухайд юу гэдэг юм, нам нийлж сэм хуйвалдаад юм уу хулгайн аргаар хуйвалдаж хувьчилчих вий гэж бас та хардаж байх шиг байна. Тийм юм бол байхгүй. Нээлттэй, ил тод, шударгаар асуудлыг шийднэ. Та санаа зовохгүй байж болно. Та их хартай хүн. Тийм, битгий хардаарай. Тэгээд санаа зовохгүй байж болно. Энэ дээр бол тэгээд надаас өмнө тийм үү, намайг сайд.../минут дуусав./

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн. Асуулт асууж, үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ их чухал асуудал байгаа юм. Би тэгээд нэг зүйл тодруулъя гэж бодож байна л даа. Энэ Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон болгох тухай асуудлыг бид нар хэлэлцэж байгаа юм.

Тэгэхээр далайд гарцгүй Монгол Улсын хувьд энэ үнэхээр чухал асуудлын нэг мөн. Бид энэ иргэний нисэхийн байгууллагыг либералчилж байж их олон

гуравдагч их олон орнуудтай харилцаж байж, энэ их чухал ач холбогдолтой болох юм.

Тэгэхээр би ганцхан л асуулт асуух гээд байгаа юм. Энэ протокол соёрхон батлагдсанаараа Монгол Улсад ямар ач холбогдолтой юм бэ? Бидэнд ямар давуу тал, боломж гарч ирэх юм бэ л гэдэг асуудал байгаа юм. Бид чинь бас энд тэндхийн протокол хэлэлцээр янз бүрийн юманд нэгдсээр байгаад зарим нэг нэгдсэн хэлэлцээрүүд маань чөдөр тушаа болдог юмнууд байдаг. Чөдөр тушаа болдог юмнууд байдаг.

Тийм учраас бол хамгийн гол юм энэ ач холбогдол, давуу тал юу юм бэ гэдэг талаас нь асууж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданишатар: Үг хэллээ. Хариулах юм уу? Хэн хариулах вэ? 82 уу? Хэн хариулах юм бэ? Хариулах хүн ядаж гараа өргөчих. 82.

Ч.Мөнхтуяа: Агаарын навигаци манай улс хөрш орнуудын газар нутгийн хувьд хөрш орнуудын агаарын навигаци үйлчилгээнээс хамаардаг. Би хариулах уу тээ?

Г.Занданишатар: Хариулаач. Микрофондоо ойрхон хариул. Микрофоноо ойртуул ам руугаа. Сонсогдохгүй байна.

Ч.Мөнхтуяа: Сайн байцаана уу? Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Мөнхтуяа хариулъя. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын агаарын навигацийн комиссын тоог нэмэгдүүлэх энэ бодлогод Монгол Улс оролцсоноор агаарын навигацийн үйлчилгээ, техник, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг тус комисст ажиллуулах, дэмжлэг авах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын иргэний нисэхийн байгууллагын бодлого зорилгод нийцсэн гишүүнийхээ үүргийг биелүүлж байгаа юм.

Г.Занданишатар: Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Чимэддоржийн Мөнхтуяа хариулъя. Протоколд үлдэж байгаа учраас нэр усаа тод хэлж байх ёстой. Наад бүх үг, үсэг чинь протокол болж үлдэнэ шүү дээ. Энэ чинь протокол. Болчихсон уу? Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт асууж, үг ч хэлж болно.

Г.Ганболд: Бид нар энэ Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд өөрчлөлт оруулах гэж байгаа тухай л юм байна л даа. Яг энэ 56 дугаар зүйл нь юу юм бэ? Ямар заалтад өөрчлөлт орох гээд байгаа юм? Тэгээд давуу байдал нь юу юм? Одоогийн байдлаар миний энэ ойлголт авахад 128 улс энийг баталж, санал өгч байж энэ 56 дугаар зүйл хүчин төгөлдөр болох юм байна л даа. Одоо яг 60 улс энийг баталснаа илэрхийлээд байгаа юм байна.

Тэгэхээр манайх магадгүй 61 дэх болох нь л дээ. Цаана нь байгаа энэ 128 улсаас 68 улс нэмж баталж байж энэ конвенцод өөрчлөлт орох нь. Энийг яг эсэргүүцэж байгаа улс жишээлэх юм бол байгаа юу энийг? Энэ ямар хугацаанд энийг өөрчлөлт оруулаач гэдэг хүсэлтийг илэрхийлээд, ямар хугацааны дотор энэ 60 улс энэ хуулийг баталсан юм бэ? Энэ яг 56-гаа эхлээд ойлгоодохмоор байх юм. Бид нар 56 л гээд байдаг яг ямар заалт өөрчлөх гээд байгаагаа мэдэхгүй шүү дээ.

Мэдээж энэ бол бас ингээд унших дээр зэрэг нэлээн олон комисс энэ тэр байгуулдаг, техникийн дэд комиссууд байгуулдаг ийм бас нэлээн том байгууллага юм байна л даа. Зардал төсөв байж таарна. Улсын төсвөөс нэг ч төгрөг төлөхгүй л гээд байна. Иргэний нисэхийн ерөнхий газраас яг энэ байгууллагууд руу төлдөг мөнгө байгаа юу? Эсвэл манай иргэний нисэхийн байгууллагуудаас энэ олон улсын байгууллагын энэ техникийн дэд комиссуудад томилогдоод сонгогдоод ажиллаж байгаа тийм инженер

техникийн ажилчид байна уу? Ийм хүмүүс орж байж энэ улс орны эрх ашгийг хамгаалах тухай ярихгүй бол зүгээр ингээд баталсан болоод яваад байх юм бол энэ чинь үр дүн муутай л даа. Дотор нь орж нөлөөлж, Монгол Улсын энэ агаарын орон зайг яаж ашиглах вэ тэгж байж яаж энэ навигацийн орлогоо нэмэгдүүлэх вэ гэдэг бодлогын асуудал бид нарын хувьд чухал байгаа шүү дээ.

Тэгээд энэ дээр өмнө нь орж байсан, шийдүүлж байсан асуудал юу байгаа юм гэдгийг нэг асуугаадахъя. Тэгээд бид нар түрүүн сайд ярьж байна л даа. Ер нь иргэний агаарын, иргэний нисэхийн байгууллагуудаа либералчилна гээд. Зөв тэгж байж энэ үнэ ханш бууна л даа. Бид нар бол МИАТ-аа дэмжиж байна гээд бас нэлээн үнэ өртөг дээр ч гэсэн хатуу бодлого явж байсан тохиолдлууд байгаа байх нь. Энэ конвенцод орсноор зөвхөн агаарын орон зай юу, эсвэл энэ иргэний энэ нисэх буудлуудын асуудал яг энэ байгууллагуудад харьяалагдаж явдаг юм уу?

Одоо бид нар ингээд хараад байх дээр зэрэг байна шүү дээ. Энэ Солонгосын төр бол бас бодлогоороо энэ өөрийнхөө авиа компаниудыг дэмжээд л байх юм. Бид нар ажиглаад л байгаа. Жишээлэх юм бол Монгол Солонгосын хооронд явж байна гэхэд KAL болохоор 2 дугаар терминалаасаа нисгэнэ. МИАТ-ийг 1-ээс. Тэгэнгүүт 2 дээр буусан хүмүүсийн ачаа барааг нь шалгахгүй. 2 дугаар терминалаас Монгол руу сууж байгаа хүмүүсийн юу гэдэг юм нөгөө татварын хөнгөлөлт энэ тэр авахад суугчийн талоноо авахад ямар ч хүндрэлгүй ингээд аягүй тухтай үйлчилнэ.

Нэгдүгээрт терминал дээр МИАТ-ийг буунгуут буусан хүмүүсийн ачаа барааг нь түнхээд, ухаад л. Буцаад очоод нөгөө наашаа нисэх гэж байгаа хүмүүсийн билет суудлаа авахад нь хүндрэл учруулаад л, дараалал чирэгдэл учруулаад л. Энэнээс болоод иргэд чинь ингээд хүссэн хүсээгүй ингээд шахалтад

ороод Korean air-ыг сонгох магадлал нь өндөр байгаад байгаа байхгүй юу. Энэ бол цаанаа хэдийгээр илт биш ч гэсэн иргэний нисэхийн байгууллагуудынхаа, нисэх буудлынхаа менежмент бодлогоор нь ингээд манайхыг шахаад л байна шүү дээ.

Тэгэхээр манайх энэний эсрэг яг МИАТ дээр юм уу, KAL дээр ямар арга хэмжээ авах юм. Энэ бодлогуудаа барьж энэ олон улсын конвенцууд нэгдэж байхгүй бол энэ чинь Солонгосын тал бол бодитойгоор л шахалт үзүүлээд байгааг бид нар мэдсээр байж МИАТ-аа дэмжихгүй үнийн өрсөлдөөнд оруулна гээд сууж байгаа нь зөв бодлого уу?

Г.Занданшатар: Сайдын байр суурийг сонсъё. Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт.

С.Бямбацогт: Ганболд гишүүний асуултад хариулъя. Олон улсын иргэний нисэхийн конвенц гэж 1944 онд байгуулагдсан ийм конвенц байдаг юм байна лээ. Дэлхийн 193 улс нэгдэн орсон. Асуудал бол дэлхийн 193 улсаасаа 128 буюу гуравны хоёроор шийддэг. Ийм юутай. Тэгээд энэ конвенцод тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа юм. Та 56 дугаар зүйл нь юу юм бэ гэж асуусан. 56 дугаар зүйл нь болохоор агаарын навигацийн комиссын гишүүний тоо 19 байна гэж заасныг 2016 онд бас энэ олон улсын навигацийн иргэн хэсгийн байгууллагууд хуралдаад энийг тоог 21 болгож нэмэгдүүлье гэсэн шийдвэр гарсан. Энийг л үндсэндээ 56 дугаар зүйлд байгаа 19 гэснийг 21 болгох энэ протоколыг бид нар батлах гэж байгаа юм. Бид нар.

Энэ комисс нь ямар үүрэгтэй байгууллага юм бэ гэхээр энэ комисс бол үндсэндээ агаарын навигацийн комисс нь олон улсад агаарын навигацийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлдог, мэдээлэл цуглуулдаг мөн стандарт шаардлага тогтоох зөвлөмж боловсруулах, техник технологийн асуудлаар дэд комисс томилох зэрэг бас үүрэгтэй ажлуудыг

хийж, хэрэгжүүлдэг юм байна лээ. Энэ протоколыг батлахаар 128 улсын саналаар батлагдах ёстой. Үүнээс одоогийн байдлаар 80 улс нь дэмжээд өгчихсөн байж байгаа. Бид нар энэ протоколыг батлах юм бол үндсэндээ 81 дэх улс болно. Ийм байдлаар ингээд цаашаа явсаар байгаад 128 хүрэх юм бол энэ 19 гэсэн тоо 21 болж өөрчлөгдөх юм байна лээ.

Ер нь бол бид энэ олон улсын иргэний нисэхийн байгууллагад нэгдээд энэ үйл ажиллагаа явуулснаараа Монгол Улсын нөгөө навигацийн орлого гэж ярьдаг. Улсын төсөвт томоохон орлого оруулдаг энэ үед агаарынхаа орон зайг ашиглуулсны. Мөн бас дэлхийн бусад улсуудын агаарын орон зайг ашиглахад бас Монголын авиа компаниуд нисэхэд юу гэдэг юм зохицуулдаг зохицуулалттай. Ийм үүрэг хүлээж нэг талдаа эрхээ эдэлдэг, нөгөө талдаа үүргээ хүлээдэг ийм байдлаар Монгол Улсын агаарын орон зай дээгүүр гаднын онгоцнууд ч нисдэг, Монголын авиа компаниуд гадаадын оронд улсуудын агаарын орон зайгаас ашиглаж нисдэг. Энийг л үндсэндээ зохицуулдаг. Дэлхийн Нэгдсэн Үндэстний байгууллагын дэргэд ажилладаг ийм байгууллага байгаа юм. Энэ байгууллагууд жилдээ бас тодорхой хэмжээний хураамж төлдөг. Энэ олон улсын иргэн нисэхийн байгууллагын гишүүнийхээ хураамжийг манайхан бас төлж ажилладаг гэдгийг бас хэлье.

Ингээд нэмээд хариултыг Мөнхтуяа даргаас өгчхөөрэй.

Дараагийн асуулт дээр агаарын тээврийн либералчлалын хүрээнд үндсэндээ бол урьд нь KAL, МИАТ гэсэн хоёрхон компани нисдэг байсан бол Солонгосоос 3 авиа компани нисэхээр болж байгаа. 3, 4 ч авиа компанийн нисэхээр болж байгаа. Мөн бас зөвхөн Сөүлийн чиглэлд нисдэг бол Бусан, Инчон биш, Бусан нөгөө юу билээ, Дэгү, Мёнду билүү дээ энэ 3 хот руу шууд нисдэг болох ийм бололцоотой болж байгаа. Мөн

хоолойны асуудал ярьж байна. 1 дүгээр терминал, 2 дугаар терминал гээд. Энэ дээр үндсэндээ бол манай авиа компаниудын бас нөгөө нисэх буудлуудаас авах үйлчилгээний тарифтай холбоотой.

Одоо хамгийн тохитой тухтай байдаг юм уу, хамгийн юутай хоолой дээр буухад илүү өндөр төлбөр төлдөг. Одоо юу гэдэг юм, таны ярьж байгаа тэр хоолой тавихад илүү арай жосоохон бага зардал төлдөг ч гэдэг юм уу иймэрхүү байдлаараа бас зохицуулалтууд нь явдаг юм байна лээ. Гэхдээ энэ дээр бол бас цаашидаа бид бас аль болох үндэстний агаарын тээвэрлэгч компаниудаа аятай тухтай юу гэдэг юм, иргэдээ бас аятай тухтай үйлчлэх тал дээр бас бид анхаарна.

Ер нь бол өрсөлдөөн дээр л үнэ тогтдог, өрсөлдөөн дээр үйлчилгээ чанар сайжирдаг. Өрсөлдөөн их байх тусмаа үнэ хямдарна, нөгөө талдаа үйлчилгээний чанар сайжирна. Энэ л бодлогыг бид нар барьж байгаа. Ингэхдээ мэдээж дотоодын авиа компаниудаас аль болох дэмжих энэ бодлогыг бас бид нар Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам анхаарлын гадна орхигдуулахгүй гэдгээ бас танд хэлье.

Г.Занданшатар: Одоо Мөнхтуяа дарга нэмж хариулъя. 82.

Ч.Мөнхтуяа: Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Чимэддоржийн Мөнхтуяа нэмж хариулъя. Олон улсын иргэний нисэхийн байгууллагад манай улс 1989 онд нэгдэн орсноос хойш гишүүнчлэлийн татвар төлж ирж байгаа. Конвенцод зааснаар гишүүнчлэлийн үйл ажиллагаанаас нь хамаараад нийт тус төсвийнх нь тэг 0.06-25 хүртэл гэж хуваарилаад энэ гишүүн 193 улстайгаа оногдуулдаг. Канад доллар болон америк доллароор 2 янзын төлбөр төлдөг.

Манай улс ер нь жилд 175-180 сая төгрөгийн төлбөр төлдөг. Энийг

болохоор жил болгон өөрчлөгддөг. Гэхдээ Монгол Улсын хувьд ер нь тогтмол үйл ажиллагааныхаа оролцоогоор ингэж төлдөг юм. Энэ нөгөө конвенцын тухайд 80 улс орсон 128 улс нэгдэн орсноор хүчин төгөлдөр болно гээд. Энэ үндсэн Чикагогийн конвенцтой манай улс нэгдэж орсон.

Гэхдээ гишүүнчлэл болон ач холбогдлоо харгалзаад энэ болохоор жил болгон ийм ийм конвенц, протоколд нэгдэж орооч гээд гишүүн орныхоо үүргийг биелүүл гэдэг нэг талаар шаардлага болон зөвлөмж тавигддаг учраас бид 2016 оны хэлэлцээрт одоо ингээд 7 жилийн дараа, уг нь энэ асуудал жил болгон, 3 жил тутам болдог Ассамблейн үеэр ер нь илүү идэвхтэй хэрэгждэг.

Бид болохоор агаарын навигацийн зөвлөлийн гишүүдийн тоог нэмэх энэ протоколд нэгдэн орсноор нөгөө үндсэн конвенцтой нэгдээд орчихсон учраас энэ бол манай Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа. Бид олон улсын гишүүний үүргээ нэмэгдүүлэх оролцоогоо хангах тэгээд Монгол Улс ер нь өөрөө агаарын навигацийн үйлчилгээний Ази Номхон далайн бүсийн газар нутгийн хувьд ингээд давуу байдлаа ашиглаж энэ үйлчилгээг илүү түлхүү хөгжүүлэхийг, бодлогын хувьд дэмжиж, тодорхой хэмжээний орлогыг олж, хураамж төвлөрүүлж, улсын төсөвт дэмжлэг үзүүлэх гэдэг бодлогоо ингээд хэрэгжүүлэх зорилгоор энэ протоколд нэгдэх нь зүйтэй гэж үзээд явж байгаа юм. Хариулт болсон.

Г.Занданишатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 2018 онд төлөвлөлт гаргасан байх. Тэгээд төлөвлөлт гарсны дагуу 2019 онд 380 тэрбум төгрөгийн би үргэлжлээд хэлчихлээ шүү 380 тэрбум төгрөгийн навигацийн орлого олно гээд түүнийгээ бас үр ашигтай бараг 50-иад тэрбумын

ашигтай ингээд гарч байсан байна л даа. Тэрнээс хойш төлөвлөлт яаж төлөвлөгдсөн юм? тэгээд дээрээс нь орлого яаж багассан юм, алдагдал яаж нэмэгдсэн юм? Энэ талаар Иргэний нисэхийн ерөнхий газрын даргыг яг он оноор нь яагаад гэвэл протоколд оруулах зорилгоор он оноор нь бас хэлээд өгөөч гэж хүсэж байна.

Г.Занданишатар: 82, Мөнхтуяа дарга хариулъя. Чимэддоржийн Мөнхтуяа дарга.

Ч.Мөнхтуяа: Иргэний нисэхийн газрын дарга Чимэддоржийн Мөнхтуяа хариулъя. Ер нь бол агаарын навигацийн үйлчилгээний орлого гэдэг маань агаарын зайгаар дамжин өнгөрөх 100 километр тутамд агаарын хөлгийн даацаас нь хамаарч авдаг хураамж байгаа юм. Энэ ингээд олон улсад тогтоох аргачлал нь байдаг. Тэрний дагуу манайх ингээд 2017 онд шинэчлэн тогтоогоод мөрдөж байгаа. Энэ нь үндсэндээ 100 километр тутамд 50 тонн хүртэлх болон 400 тонноос дээш гэдэг ангиллаар 100 километр тутамд 34-96 долларын хураамж авдаг юм.

Тэгээд манайх болохоор агаарын зайн олон улсын байгууллагын шаардлага нь болохоор чиг, шулуун, богинохон аль болохоо эдийн засгийн үр өгөөжтэй байх талаас нь агаарын тээвэрлэгч талаас нь мөн энэ нь болохоор агаарт шатаах шатахууны хэмжээг бууруулах, нүүрс хүчлийн хийг бууруулах, байгаль орчинд ээлтэй байх гэдэг зорилгоор аюулгүй ажиллагаа хангасан хэмжээнд энийг тоноглож тогтоо гээд агаарын замыг бид тогтоон ашигладаг.

Тэгэхээр манайх хамгийн богино агаарын зам бол 461 километр, хамгийн урт нь болохоор 1978 километр гээд ийм агаарын зайгаа тогтоогоод, олон улсад зарлаад бид мөрдүүлдэг. Үндсэндээ ер нь нийт агаарын замын ашиглалтын хувьд болохоор, нийт агаарын замын 40 хувь нь 1244 километр буюу ийм агаарын зайг

ашигладаг. Энэ нь болохоор нэг агаарын хөлөг дээр даацаасаа хамаараад 423-1194 долларын хураамж авдаг юм.

Тэгээд ер нь бол бид жил болгон агаарын навигацийн хураамжийг төвлөрүүлж улсын төсөвт төвлөрүүлж ирсэн. Үүнээс тухайлбал 2019 онд 326 тэрбум төгрөгийн хураамж авч, 175 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлж байсан бол одоо 22 онд 115 тэрбум навигацийн орлого авч 16 тэрбумыг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Г.Занданишатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би түрүүн хэлсэн 380 тэрбум төгрөгөөр 2019 онд та нар төлөвлөлт хийж байсан байна. Гэтэл 2022 онд та нар 153 тэрбум төгрөгөөр төлөвлөлт хийгээд тэрнээсээ 71 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаад, нийтдээ 82 тэрбум төгрөгийн л орлого олсон байна. Тэгэх дээр нөгөө 2019 онд буюу дайн гарахаас өмнө 380 тэрбум төгрөгөөс өнөөдрийн орж байгаа 82 тэрбумыг олохоор та нар чинь 300 тэрбум төгрөгийн алдагдалд орчихоод байгаа байхгүй юу даа. Зүгээр сайхан явж байсан тэр энэ юу чинь энэ дайны байдлаас болоод, дээрээс нь энэ санкцаас болоод Европын Холбоо болон Америкийн Нэгдсэн Улсын тавьж байгаа санкцуудаас, улс орнуудын санкцаас болоод бид нар ингээд хохирчхоод байна.

Тийм учраас бид нарт бас энэ компенсацыг авах тийм боломжууд бас байгаа. Энэ талаар ямар ажил хийж байгаа юм бэ? Үүгээрээ бас хариулт өгнө үү.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ? Байж бай, байж байгаарай. Батбаяр, 84. Батбаяр.

Г.Батбаяр: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. 2022 оны 2 сарын 24-нөөс үүссэнээс хойш үүсээд байгаа агаарын навигацийн орлого, бүрдэлт

муудаж байгаа Оросын Холбооны Улс болон Оросын Холбооны Улсын агаарын зам, агаарын орон зай хаагдсантай холбогдуулан Монгол Улсаар дамжихгүй байгаатай холбогдуулан энэ асуудалтай холбогдуулан ерөнхийдөө Ази Европын хооронд нисэж байгаа нислэгүүд болон энэ Ази Европын хооронд нисэж байгаа нислэгийн агаарын замыг ашиглаж байгаа аль ч улсаас, аль ч тээвэрлэгчээс одоохондоо компенсагийн асуудал тодорхой Засгийн газраасаа эсвэл тодорхой энэ санкцуудтай холбоотойгоор компенсац шаардсан компенсац нөхөн олговор олгооч ээ, алдагдалд ороод байна гэсэн байдлаар санал илэрхийлсэн юм бол одоогоор нэг ч улсаас юм байхгүй.

Энийг бол олон улсын нөхцөл байдлыг харж байхад барууны орнуудын гаргасан санкцад болон.../минут дуусав./

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт товч үг хэлж дууслаа. Үг асуулт энэ конвенц дээр цуг явдаг юм. Дэгээ сайн уни. Дэгээ сайн уни. Дэгээ сайн уни. Би асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу гэж асуусан. Ингээд, горимын санал гэж байхгүй. Горимын санал гэж байхгүй. Санал хураалт дээр бүлгийн удирдлага л санал авах эрхтэй. Ганибал, Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Ардчилсан намын бүлгийн гишүүд энэ навигацийн асуудал дээр завсарлага авах хүсэлтэй байгаагаа илэрхийлж байна.

Г.Занданишатар: Ардчилсан намын бүлгээс завсарлага авах санал ирүүлсэн учраас Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 5 хоногийн завсарлага.

12.38 цаг

Даргын дэргэдэх зөвлөл хуралдана. Хэдээс хуралдах уу? Ингээд завсарлага авсан учраас үдээс өмнөх нэгдсэн

хуралдаан завсарлаж байна. Чуулганы нэгдсэн хуралдаан завсарласныг мэдэгдье.

Баасан гараг 17 Гуравдугаар сар 2023
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 06 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Сайд Хаянгаагийн Болорчулуун үдээс өмнөх хуралдаан тасалсан учраас Өнөөдрийн үдээс хойших хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хойшлууллаа.

Дөрөв.Мал сүргийн хаваржилт, хаврын тариалалтын бэлтгэл хангах, нөөцийн мах худалдаалах арга хэмжээний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун мэдээлэл хийнэ.

Хаянгаагийн Болорчулуун сайд индэр дээр.

Х.Болорчулуун: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Мал аж ахуйн салбарын талаар мал аж ахуйн салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг та бүхэнд танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэд Шуурхай штаб байгуулан аймгуудтай өдөр тутам холбоотой мэдээ, мэдээлэл солилцон мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байхын зэрэгцээ Улсын онцгой комисс, Шадар сайдын ажлын алба Улсын онцгой комиксын нэгдсэн шуурхай штаб, Онцгой байдлын ерөнхий газрын мэдээллээр хангах, эрсдэлийг бууруулах, дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргахад нэг бодлого чиглэлтэй ажиллаж байна.

Өнөөгийн нөхцөл байдал нь нийт нутгийн 60 хувьд нь эрсдэл өндөртэй байснаас 15 аймгийн 64 суманд цагаанд зудархуу өвөлжлөө. Одоогийн байдлаар нийт нутгийн 30 орчим хувьд нь 23 сантиметр хуртэлх цастай байгаагаас Баян-Өлгий аймгийн Сагсаа, Увс аймгийн Тэс, Давст, Хяргас, Баруунтуруун, Зуунговь, Ховдын Алтай, Үенч, Булган, Завхан, Завханы Цагаанхайрхан, Хөвсгөлийн Цэцэрлэг, Улаанбаатарын Багануурт нягтарч хатуурсан зузаан цастайн улмаас цагаан зудын байдалтай байна.

Мөн Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө, Төвийн Эрдэнэ, Хэнтийн Жаргалтайн, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Дорнодын Баян-Уул зузаан цастайн улмаас цагаан зудархуу байдалтай байна. Хаврын мал төлөлт, төл бойжилт, малын вакцинжуулалт, бүртгэлжүүлэлт, отор нүүдэл зэрэг улирлын чанартай технологит ажлуудад цаг агаарын аюулт үзэгдлүүд эрсдэлийг нэмэгдүүлсээр байна.

Тухайлбал, 2023 оны 3 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд Ховд, Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Дорнод, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Төв аймгийн нутгаар цас орж салхины хурд 16-24 метр секунд, зарим үед 27-34 метр секунд хүрч, цасан болон шороон шуурга шуурч, цаг агаарын онц аюулт үзэгдлийн хэмжээнд хүрсэн.

Цаг агаарын аюулт үзэгдлийн улмаас Дундговь, Дорнод аймгуудад 5 иргэн төөрснийг аймгуудын Онцгой комисс ажиллаж иргэдийг эсэн мэнд олж ар гэрийнхэнд нь хүлээлгэж өгсөн.

Мөн 9 аймгийн 15 суманд нийт 41 айлын гэр, 1 саравч, 27 айлын хашаа нурж 10 байшингийн дээвэр хуурсан. Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт Мандалговь, Тавантолгой чиглэлийн 220 киловаттын цахилгаан дамжих агаарын шугамын тулгуур багана унаж гэмтлийг цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ

компани, хангай, говийн, төвийн болон Улаанбаатар бүсийн салбарын 88 ажилтан 17 техниктэйгээр ажиллаж хэвийн горимд оруулсан.

Хаваржисж буй малын тоо эдийн засгийн эргэлт, Монгол Улс 2022 оны эцэст 71.1 сая мал тоолуулж өмнөх оны оноос 5.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс 21.8 мянган өрхийн 9.5 сая мал отроор өвөлжлөө. 2022-23 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 20 сая мал эдийн засгийн эргэлтэд оруулаа. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн зөвлөмжөөр үхрийн түүхий мах 8000 тонн, дулааны аргаар боловсруулсан үхрийн мах 5000 тонныг, харин адуу, хонь, ямааны түүхий болон дулааны аргаар боловсрон махыг бодлогын гэрээний үндсэнд хязгаарлалтгүй экспортлохоор баталсан.

Мал махны экспорт Бүгд найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улс, Япон, Казахстан, Киргизстан, Узбекистан, Азербайжан, Иран, Арабын Нэгдсэн Эмират, Катар, Хонг Конг, Вьетнам улсууд руу хийгдэж байна.

22 онд 16.1 мянган тонн мах, дайвар бүтээгдэхүүн экспортолсон бөгөөд үүний 10000 тонн нь 11-12 дугаар саруудад хийгдсэн.

23 он гарсаар 17.3 мянган тонн мах экспортод гарсан. Энэ нь малын гоц халдварт шүлхий өвчин тайван байгаагийн эерэг нөлөөлөл гэж үзэж байна.

Засгийн газрын 22 онд гаргасан нэг шийдвэр бол амьд малын экспорт юм. 22 онд 10-12 сард 2.4 сая ам долларын өртөг бүхий 28500 толгой мал, 2023 он гарснаар 2.1 сая ам долларын өртөг бүхий 23440 толгой мал гараад байна. Энэ нь оны эхний нийт малын 0.07 хувийг эзэлж байна.

Өвс тэжээлийн хангамж, Малчдын түвшинд 1.1 сая тонн сүрэл, 15000 тонн ногоон тэжээл, 88000 тонн үйлдвэрийн тэжээл авах, 32.4 мянган тонн гар тэжээл, 47.9 мянган тонн дарш, 13.1 тонн хужир шүү, 92000 тонныг тос бэлтгэсэн байсан малчдын түвшинд бэлтгэсэн өвс тэжээлийн 80 гаруй хувь нь зарцуулалттай байна. Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөц 22 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар 22000 тонн өвс, 8.4 мянган тонн тэжээлтэй байсан бол борлуулалтаас 5.5 мянган тонноос 3.14 мянган тонн тэжээлийг нэмж татан авч, өвсний 74 хувь, тэжээлийн 66 хувийг зарцуулан одоогийн байдлаар 7.2 мянган тонн өвс, 4000 тонн тэжээлийн нөөцтэй байна.

Өвөлжсний нөхцөл байдал Улсын онцгой комиссын шуурхай бүлгийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан Засгийн газар олон улсын байгууллагаас дараах арга хэмжээг авч, орон нутаг, малчдад дэмжлэг үзүүлсний үр дүнд малын зүй бус хорогдол хэвийн хэмжээнд байна.

Үүнд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, Засгийн газрын тогтоолоор нөхцөл байдал хүндэрч буй Баян-Өлгий, Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар, Дорнод аймаг Баян-Уул сум дахь Гал түймэр унтраах алба, Говь-Алтай аймгийн Алтай, Завхан аймгийн Баянтөгс, Тэс, Ховд аймгийн Булган, Алтай, Увс аймгийн Бөхмөрөн, Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр, Өндөрширээт, Өмнөговь аймгийн Гурвантэс, Завхан аймгийн Отгон сум зэрэг сумдын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвүүдэд туулах чадвар сайтай автомашин нийт 16-г олгосон.

Мөн улсын нөөцөөс Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Төв, Баянхонгор, Дундговь, Ховд, Өмнөговь, Өвөрхангай, Увс, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудад 1170 тонн өвс, 8600 тонн тэжээлийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олголоо.

Цас их орсон сумдад зам гаргах, иргэдийн эрүүл мэндийн болон бусад тусламж үйлчилгээг хүргэхэд зориулж Ховд аймгийн Онцгой комисст 30 тонн дизель түлш, 20 тонн 92 бензин, Архангай, Завхан аймгуудад Хүнс, хөдөө аж ахуйн газруудад малчдын үзүүлэх нийгмийн үйлчилгээ өвс тэжээл татан авахад зориулж тус бүр 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

Олон улсын байгууллагуудаас “Дэлхийн Зөн Монгол” олон улсын байгууллагаас Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймгийн эмзэг бүлгийн 1770 өрхөд 150000 ам долларын бэлэн мөнгө, 1 өрхөд 300000 төгрөг олгосон. Монголын Улаан загалмайн нийгэмлэгээс Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай, Завхан, Дорноговь, Дундговь аймгийн 1000 өрхөд зуун дал аравны таван мянган ам долларын бэлэн мөнгө, 1 өрхөд 350000 төгрөг олгосон.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Өмнөговь, Өвөрхангай, Увс, Ховд зэрэг 11 аймгийн 51 сумын 510 өрхөд малын өвс тэжээл, эрдсийн нэмэгдэл хүндрэлтэй сум тус бүр 1 сая төгрөгийн шатахуун, нийт 450 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Японы “Хүүхдийг ивээх” сан, Говь-Алтай, Завхан аймгийн 6 сум 600 өрхөд бэлэн мөнгө, тэжээлийг нэмж үзүүлэхэд зориулж 110000 ам долларыг батлуулаад байна.

Америкийн хөгжлийн хөтөлбөрийн төлөөлөгч Хэнтий, Увс, Ховд аймгуудад газар дээр нь ажиллаж дэмжлэг үзүүлэх талаар төлөвлөлтийн шатанд хамтран ажиллаж байна.

Салхи шуурга шар усны үер, ой хээрийн түймэр ихэссэн энэ үед мал

төллөлт, төл бойжилт, малын вакцинжуулалт, бүртгэлжүүлэлтийн улирлын чанартай технологит ажилд анхаарлаа хандуулан цаг агаарын аюулт үзэгдлийн мэдээ, мэдээллийн шуурхай хүргэх, мэдээлэл солилцох замаар орон нутагтаа байнгын хамтын ажиллагаа үргэлжлүүлэн ажиллах болно.

Хоёрт, Хаврын тариалалтын бэлтгэл ажлын талаар,

2023 онд улсын хэмжээнд 393000-д үр тариа, үүнээс 369000-д улаан буудай, 69000 тонн малын тэжээл, 66000 тонн тосны ургамал, 19.8 мянган тонн төмс, 12000 га-д хүнсний ногоо, 7.9 мянган га-д жимс, жимсгэнэ, нийтдээ 586000 га-д тариалалт хийж, 542000 тонн үр тариа, үүнээс 510000 тонн улаан буудай, 173000 тонн малын тэжээл, 33000 тонн тосны ургамал, 231000 тонн төмс, 122.6 мянган тонн хүнсний ногоо, 3.1 мянган тонн жимс жимсгэнэ хураан авч, 350000 га-д урьш боловсруулалт бэлтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Таримал ургамлын үрийн чанар хангамжийг сайжруулах зорилгоор Хөдөө аж ахуйн дэмжих сангаас энэ хаврын тариалалтад зориулж, нийтдээ 10000 тонн улаан буудайн үр болох бөгөөд үүнд дотоодын ургацаас бүрдүүлсэн 4.9 мянган тонн, Оросын Холбооны Улсаас нийлүүлэх 5000 тонн улаан буудайн элит үрийг оролцуулан тооцож байна.

Мөн улсын төсвийн 620 сая төгрөгийн санхүүжилтээр хүлэмжийн аж ахуйд тариалах нарийн ногооны үр худалдан авах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд хэрэгцээт үрийг технологийн хугацаанд шуурхай нийлүүлэхээр ажиллаж байна.

Улсын Их Хурлын 22 оны 36 дугаар тогтоол баталсан Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөтөлбөрийн хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн зээлийг арилжааны

банкаар дамжуулан олгохоор ажиллаж байна.

Энэхүү арга хэмжээний хүрээнд 5 хувийн хүүтэй 110 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгогдох бөгөөд үүнээс үр тарианы үйлдвэрлэлд 90 тэрбум, хүнсний ногооны үйлдвэрт 20 тэрбум төгрөг байхаар зохицуулалт хийж байна.

Мөн газар тариалангийн үйлдвэрлэлийн барилга байгууламж болох зорь, агуулах, үр тарианы үтрэм, өвлийн хүлэмж барих услалтын систем байгуулахад зориулан 232 тэрбумын төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл олгоно.

Түүнчлэн төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтыг сайжруулах, техник технологийн шинэчлэл хийх зорилгоор тухайн жилд худалдан авсан техник тоног төхөөрөмжийн үнийн дүнгийн 50 хувийг тариаланчдад буцаан олгох, бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна.

Хүнсний нарийн ногооны тариалах 20 га өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй, 500-2500 тонн багтаамжтай механикжсан агуулах, сумдад байгуулах агар паркийн нэг маягийн зураг төсөл, тооцоог үндэслэн орон нутагт газар тариалангийн зориулалттай барилга байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Алслагдсан бүсэд тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан баруун, зүүн бүсэд тус бүр 10000 тонны багтаамжтай үр тариа хадгалах элваторын суурийг байгуулахын зэрэгцээ Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 500 тонн багтаамжийн төмс, хүнсний ногооны зорь барьж, ашиглалтад оруулах ажлыг зохион байгууллаа.

Хөрсний үржил шимийг хамгаалах зорилгоор тариалангийн талбайг хашаажуулах, ойн зурвас зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд жимс жимсгэний суулгац, үржүүлгийн төвүүдийг орон нутагт байгуулах ажлыг зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Гурав, Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэлт худалдаалахтай холбогдон авах зарим арга хэмжээний тухай.

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тогтворжуулах зорилгоор Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас 22 онд гол нэрийн төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухайн хууль, Гурил, махны үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 174 дүгээр тогтоолыг тус тус баталсан.

Уг тогтоолд нөөц мах бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжид 130 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй олгож, зээлийн нийт үнийн 10.5 хувьтай тэнцүү хэмжээний хөнгөлөлтийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр ишийдвэрлэсэн.

Үүний дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монголбанктай хамтран нөөцийн мах бэлтгэлийн эх үүсвэрийг банкны саналд үндэслэн урт хугацааны рипо арилжаагаар 2 банк. “Хаан” банк, Худалдаа хөгжлийн банк. 53.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг мах бэлтгэн нийлүүлэгч 12 аж ахуйн нэгжид тус тус олгосон.

Энэхүү санхүүжилтээр 7900 тонн мах бэлтгэж нөөцлөхөөс 2023 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар гүйцэтгэл 99.7 хувьтай байна. Нийт бэлтгэж буй махны 30 хувь буюу 1800 тонн үхрийн мах, 65 хувь буюу 5600 тонн хонины мах, үлдсэн 5 хувь буюу 500 тонн ямааны махаар бүрдүүлээд байна.

Аж ахуйн нэгжийн бэлтгэж нөөшилсөн маханд Монгол Улсын Засгийн газрын Хэрэглэх газрын даргын 23 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 13 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг газар дээр нь очиж чанар, аюулгүй байдалд хяналт шалгалт хийж ажилласан.

Бэлтгэсэн нөөцийн махыг 23 оны 3 сарын 15-ны өдрөөс эхлэн үхрийн 1 килограмм ястай махыг 10700 төгрөг, хонины ястай махыг 8600 төгрөг, ямааны махыг 6400 төгрөгийн үнээр нийслэлийн 9 дүүргийн 431 хүнсний дэлгүүрээр татварын цахим төлбөрийн баримтын системд үндэслэн хүртээмжтэйгээр худалдан борлуулах бэлтгэл ажлыг нийслэл, дүүргийн холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Нөөцийн махны худалдаалах үнийг Хүчит шонхор захын энэ оны 3 сарын 13-ны өдрийн бөөний дундаж үнэтэй харьцуулахад үхрийн ястай махыг 300 төгрөг буюу 2.7 хувь, хонины ястай махыг 900 төгрөг буюу 9.5 хувиар, жижиглэнгийн дундаж үнэтэй харьцуулахад үхрийн ястай мах 2800 төгрөг буюу 20.7 хувь, хонины ястай мах 2400 төгрөг буюу 22 хувь, ямааны ястай мах 2100 төгрөг буюу 25 хувиар тус тус хямд үнэтэй байна. Энэ эх үүсвэр.

Мөн нөөцийн махны худалдаалах үнийг томоохон зах худалдааны төвд худалдааж буй энэ оны 3 сарын 6-ны өдрийн махны жижиглэнгийн үнэтэй харьцуулахад үхрийн ястай мах 28 хувь, хонины ястай мах 31.5 хувь, ямааны ястай мах 34 хувиар тус тус хямд үнээр нийслэлийн иргэд худалдан борлуулахаар

бэлтгэл ажлыг бүрэн хангаад ажиллаж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл мэдээлэлтэй холбогдуулж үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, инфляцаас улбаатайгаар иргэдийн цалин орлогын худалдан авах чадвар улам бүр буурч, өр зээл өдөр өдрөөр өссөн, бизнесүүд сульдсан. Ган, цас, хүйтэн, шүлхий, малын өсөлтөөр нөхцөлдсөн зудтай өвөл жил гаруйн дараа эхлэх ээлжит сонгуульд өнгөрсөн 8 жил үнэмлэхүй засагласан ч үзүүлэх ажил биелүүлсэн амлалтгүй эрх баригчдын үлгэн салган ажиллагаа, үүнд нь бухимдсан нь хилэнтэй ард иргэд гэсэн улс төр, нийгмийн амьдралын улайтал буцлах халуухан, хатуухан, хахир хавар та биднийг хүлээж байна.

Малын тоо толгой бэлчээрийн даацаас хэд дахин хэтэрч түүнийгээ даган хавар нь халгаатай, зун, намар болгон дэлгэр биш, өвөл нь хүнд болдог болсон.

Гэвч үүнийг хараагүй мэт харалган, үзээгүй мэт үрэлгэн нь өдөр хоногийг өнгөрөөсөн нь урьдынхаараа л аргалсан бодлогууд өнөөг хүргэн эргэж үргэлжилсээр байна.

Өвөл, хаварт малчдад өгсөн тэжээл пресс, хорогдсон малын тоо, олон улсын байгууллагуудаас авч тараасан тусламж тэргүүтэй ийм усан гэж хэлмээр тайланг Засгийн газраас ёс мэт оруулж ирж уншин тойрог, тойргийнхоо зовлонг тоочиж ахиухан тусламж ард иргэддээ хайртай нэр олох гэсэн гишүүд

цайны хэдэн асуултыг тойруулж асууж аргалсаар анаа л бид нар бас он жилүүдийг өнгөрөөлөө.

Энэ хооронд харин хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх зорилттой гоё, ганган нэртэй хөтөлбөр, тусламж, төслүүд олиширч, үүнийг дагасан өр зээл хэрэгждэггүй цааснууд нэмэгдсэн ч малчдын амьдралын чанар орлого үүнийхээ эсрэг улам бүр уруудлаа. Монгол Улсын нийт газар нутгийн 70 хувь буюу 110 сая га газрыг малын бэлчээрийн зориулалтаар ашигладаг.

Гэтэл сүүлийн үеийн судалгааны дүгнэлтүүдээр 65 хувь нь талхлагдсан. Үүнээс 100000 га нь цөл болчихсон учраас олон газарт мал төллөх боломжгүй, мал маллах боломжгүй нөхцөл байдал руу илжжиж байгааг дурдаж байна.

Бэлчээргүй мал, малгүй малчин, малчингүй Монгол гэж байхгүй нь тодорхой. Ийм учраас цөлжилт, бэлчээрийн даац, малын өвчлөл, түүхий эдийн эрүүлжүүлэх вакцин, туулга, угаалга, чанаржуулах үйлдвэр, угсаа, чанарлаг байдал, бэлчээрээ хамгаалах отор, хаваржаа өмчлөх гэх мэт урьд урьдынхаасаа илүү анхаарах, хурдтай ажиллахыг цаг үе бас бид нараас шаардаж байна.

Бүтээгч, үйлдвэрлэгч улсын баян, эрүүл ирээдүйдээ итгэлтэй аж ахуйн эзэн, малчин, тариаланч иргэдтэй болох бодлого биш. Хөрш орнуудын хөдөө аж ахуйн түүхий эдийн ханган нийлүүлэгч байх бодлого бид нарт бас хэрэгжсээр л байна. Түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, стандартыг мөрдүүлэх, улмаар боловсруулан экспортлох боломжийг дэмжиж уламжлалт нүүдлийн мал ахуйгаа урагшлуулах хүндээ, малчдадаа, тариаланчдад ээлтэй бодлого дутагдалтай байна.

Жинхэнэ зуд малчны хотондоо биш, салбарын яаманд жинхэнэ ган

тариан талбайд биш Засгийн газрын хөдөөгийн хөгжлийн бодлогод оршоор байгааг бид нар бас байн байн л ярьж байгаа.

Хахир хаврыг хэрхэн эрсдэлтэй давах вэ гэх цаг үеийн шинжтэй гал унтраах ажлынхаа хажуугаар Монголын өдөө аж ахуйг хэрхэн дэлхийн жишигт хүргэх юм бэ? Их алсын бодлого, бодлогын асуудалдаа анхаарч, малаасаа өртөж, малчнаа тарианаасаа өмнө тариаланчдаа эрхэмлэсэн бодлого барин ажиллахыг Засгийн газарт бас уламжлахыг хүсье.

Эрх баригчид та бүхний өмнөх сонгуулиудад амласан арьс ширийг дотооддоо боловсруулдаг болно. Махны экспортын хэмжээг 150000 тоннд хүргэн гэх тэр амлалтуудыг тойрог тойргийн уулзалтууд дээр иргэд бас сануулан нэхэж байсныг энд дурдъя. Боловсруулалтыг нэмүүлэхдээ хүчилж хаах биш, хөгжих боломжийг хувийн хэвшил, бизнесүүддээ олгох ёстойг мөн сануулъя.

Атарын анхдугаар аяныг зарлаж Монголын тал нутагт тракторын дуу хангинаж, тариа найгаж эхэлсээр нэгэн жаран өнгөрчээ. Уламжлалт нүүдлийн мал аж ахуйтай, ургацын богино улиралтай, хуурай сэрүүн цаг уурын нөхцөлтэй Монголын тал нутагт тариа тарьж ургуулна гэдэг бас амар ажил биш. Үүнээс амаргүй сааруулагч, хязгаарлагч хүчин зүйлүүд нь бордоо, ургамал хамгааллын бодис нийлүүлдэг, үр, техник оруулж ирж зардаг, зээл олгодог, бүтээгдэхүүн худалдаж авдаг гэж хийхгүй бизнесгүй шахаа болчихсон нь яам ойлгомжгүй төрийн бодлогыг олон тариаланчид, хөдөө аж ахуйн оролцогчид бас хэлдэг.

Уг нь бас үл үзэгдэх гартаа бид нар бас найдаж орхивол технологи хөрөнгө оруулалтаа татаад, тэмцээд, босоод өрсөлдөх, хөгжих боломж чадал нь Монголын тариаланчдад бас бий. Өртгийн сүлжээний үе шат бүхэн дор нь

өрсөлдөх мөртөө өөрсдийнхөө хийх ёстой бодлого, зохицуулалтын ажлыг хангалтгүй хийж байна.

Хүчээ нэгтгэе гэж сурталдаг мөртөө өдийг хүртэл бодлогоо нэгтгэж чадаагүй эрх баригчдын бодлогын алдаа хүнс, хөдөө аж ахуйн салбарыг тойроогүй. Тариалалт ургац хураалтын явцыг сум, аймгаар дамжуулан яаманд нэгтгэх нэгэн босоо гэмээр бүтэц бүхий бодлого нь аймаг, сумдын түвшинд асуудлаа шийдэх, нутгийн брэндийг бий болгох, эдийн засгийн бүсүүдийг бий болгох бодлогуудыг орхигдуулсаар л ирсэн.

Төв аймгийн Жаргалант, Борнуур, Сэлэнгийн Баянгол, Зүүнхараа тойрсон төмсний бүс нутаг байна. Архангай, Өвөрхангай, Булган аймгийг дамнасан Орхон, Орхоны хөндийн айргийн, Баянхонгор, Хөвсгөл, Архангайг дагасан сарлагийн, Өмнөговь, Дундговийг дагнасан тэмээний гэх мэт эдийн засгийн хөдөө аж ахуйн бүсүүд интеграцид орж, бодлого брэндийгээ нэгтгэж, дэлхийд өрсөлдөх боломж байгаа ч бид анаа л ашиглаж чадахгүй бас алмайрсаар л байгаа.

Улирал уламжлалын онцлогоор хавартай хот суурин газруудад тасалдаж, үнэ өсдөг махан дээр улсын төсвөөс татаас, дэмжлэгтэйгээр хугацаа урттай нөхцөл сайтай зээлийн бүтээгдэхүүн гарган нөөцөлдөг болсоор бас багагүй хугацаа өнгөрсөн.

Арилжааны банкаар дамжуулдаг аль болох хямд махаар хэрэглэгчдийг хангахыг чухалчилдаг гэх мэт сайшаах өнцгүүд бий ч даргын гарын үсгээр дамжуулан эрх авч, махны чанар аюулгүй байдлыг томилогдсон ажлын хэсгийнх нь үзэж шалгадаг. Төрөөс, даргаас хамаарсан тогтолцоо өнөөг хүртэл үргэлжилсээр байгаа нь хэр оновчтой вэ? Үнийн зөрөөгөөр биш, бэлтгэх махны хэмжээгээр олгогдох бага хүүтэй зээлийг нэрлэсэн компаниудад олгож байна. Зах

зээлийг либералчлах, чөлөөт эдийн засгийг дэмжих зэрэг та бидний зорьж буй эдийн засгийн загвар, тэмүүлэлтэй хэрхэн уялдаж байгаа вэ?

Махны нийлүүлэлт үнийн хөөргөдлийг зохицуулах чиглэлээр нөөцийн мах бэлтгэл рүү богино хугацаанд төрөөс, төрийн зүгээс оролцсон. Магадгүй оролцох шаардлага бас өмнөх үеүдэд бас байсан. Одоо харин дунд, урт хугацаанд махны нийлүүлэлтийг зах зээлийн голдирол, зарчим руу нь оруулах алхам руу шилжихгүй бол өрсөлдөөний тэгш бус байдлыг үүсгэж, зах зээлийг гажуудуулж, эрүүлээр хөгжих боломжийг олгохгүй бас боомилж байна.

Мах, сүү гэх мэт малын гаралтай өргөн хэрэглээний бүтээгдэхүүний нийлүүлэлт үнийн улирлаас хамаарлыг арилгаж шинэ чанартай бүтээгдэхүүнийг иргэд, хэрэглэгчдэд тасалдалгүй, эрүүл, чанартай бүтээгдэхүүнийг хэрэглэх боломжийг бүрдүүлэх бодлого дээр хариуцсан яам төр засгийн зүгээс илүү уртыг харсан бодлого дэвшүүлэн ажиллах шаардлага байгааг бас онцгойлон хэлэх ёстой.

Урьд эртнээс уламжлагдан ирсэн дараа хойшдоо өвлөгдөн үлдэж, үндэсний онцлог, бахархлыг маань тээж үлдэх манай хөдөө аж ахуйн салбарт уламжлалаа, шинэчлэлтэй уялдуулан дэлхий нийттэй өрсөлдөж чадах өрсөлдөөнд ялан дийлэх үүнийхээ үр шимийг малчид, тариаланчид төдийгүй нийт Монголчууд хүртэх боломж, потенциал бий гэдэгт бас эргэлздэггүй. Үүнийг бодит болгон хэрэгжүүлэх боломжоо амьд болгон биелүүлэхэд та биднээс урт хугацааны зөв бодлого, стратеги хүлээгдэж буй нь гарцаагүй.

Эрүүл, эко хүнсээр зорилтот зах зээлийг хангахаар зөв онилж чадвал тооны араас хөөцөлдөлгүй урт хугацаанд хүлээлгүйгээр хүссэндээ хүрэх боломж бидэнд бас бий. Гагцхүү үүнийг хэрэгжүүлэх хүсэл сэдэл, манлайлал бүх

түвшинд төрийн эрх мэдлийг хянаж буй эрх баригчдад та бүхэнд дутагдаж буйг бас дахин сануулъя.

Монголын хөдөө аж ахуйн салбарыг төрийн өрлөг нь данхар савраас чөлөөлж, экспортод зорьдог эрүүл, чанартай бүтээгдэхүүнтэй, орлого ашигтай, өвөл хавраас айдаггүй, залуус нь тэмүүлж очдог, сэтгэл хангалуун аж төрж болдог бизнес аж ахуй болгох бодлого чиглэлийг нэн яаралтай гаргаж бодлого, зорилго бүрийн эхэнд тавьж малчдаа, тариаланчдаа иргэдээ эрхэмлэн үзэж ажиллахыг эрх баригчдын бодлого та бүхнээс, бид бүгдээс дахин дахин шаардаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ. Тэгээд цөөнхийн бүлгийн гишүүд. Тэгээд сүүлд, энэний дараа. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Туваан: Улсын Их Хурлын чуулган дээр Ерөнхий сайдын мэдээлэл дээр хаваржилт, газар тариалан, нөөцийн махны асуудал яг цаг үеийн асуудал орж ирж байна. Одоо цагаан сар өнгөрсөн. Хаврын урт шар дээлтэй үе ирсэн, энэ цаг үе эхэлж байна.

Хаваржилтын асуудал дээр энэ сайдын мэдээлэлд ч гэсэн гарч байна. Энэ зудтай сумууд дээр чинь одоо яг үхэл эхэлж байна. Энэ жил онцгой хүйтэн байсан, дээрээс нь Төв аймгийн зүүн тал, зүүн урд талын сумууд бол маш их зудын байдалтай байгаад мал нь тийм нөхцөл байдалд өвөлжсөн.

Тэгээд тэр өвлийг зудын нөхцөл байдлаас гарч ирээд, одоо жинхэнэ мал ядардаг энэ цаг эхэлсэн. Яг үүнтэй зэрэгцээд өвсний үнэ 20000 гараад явчихсан. Ногоон тэжээлийн үнэ 25000 гараад явчихсан. Энэ дээр ямар бодлого байна? Малаа тэжээх өвсгүй болсон

байгаа малчдад энэ өвс тэжээлийн үнэ маш том дарамт болж байна. Энэ дээр ямар бодлого явж байна вэ гэдэг асуулт.

Хаврын тариалалт эхлэх гэж байна. Сая тойрогт ажиллаад ирсэн маш олон иргэд ярьж байна энэ Улсын Их Хурлаас, энэ Засгийн газраас энэ газар тариалангийн салбарт нэлээн том бодлогуудыг хэрэгжүүлээд байна. Тухайлбал үнэ тогтворжуулах хөтөлбөр, үнэ тогтворжуулах хууль, дахиад дээрээс нь энэ газар тариалангийн салбарт өгч байгаа, гурилын үйлдвэрүүдэд өгч байгаа энэ хөнгөлөлттэй, нэн хөнгөлөлттэй зээлүүд ингээд өгч байхад зэрэгцээд энэ гурилын үнэ маш өндөр болоод байна гэдэг асуудал дээр бүр маш их ярьж байна.

25 килограммын шуудайтай гурил 60000, 50 килограммын шуудайтай гурил 110000 гараад явчихлаа гээд. Тэгэхээр цалин тэтгэвэр дорвитой нэмэгдээгүй байгаа энэ цаг үед ийм нэмэгдлүүд орж ирээд байна. Энэ дээр энэ хаврын тариалалтаас өмнө ямар бодлого барих вэ гэсэн асуултуудыг Төв аймгийн иргэд бараг бүх сумд дээр энэ асуудлыг асууж байна. Энэ дээр хариулт авъя.

Газар тариалан дотор энэ хүнсний ногооны асуудал байгаа юм. Тэгэхээр энэ хүнсний ногоон дээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр бид нар тогтоол гаргаад Засгийн газар руу хүргүүлсэн. Бүх сумуудад 10 га түүнээс дээш хэмжээний газруудыг бий болгож, тэндээ хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мод бут тарих ажлыг эхлүүлж гэдэг шийдвэр гарсан. Энэ дээр ер нь ямар ажил явагдаж байна вэ? Энэ талаар асуулт асууя.

Хоёрдугаарт энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар явагдаж байгаа хүнсний хангамж аюулгүй байдал дээр явж байгаа энэ нөгөө зээл, 1 их наядын гэж байгаа юм. Хүүгийн татаас нь улсын төсөв дээр суучихсан. Одоо яг ярьсаар байтал энэ цаг хугацаа тулаад

ирчихлээ. Энэ дээр яг банк нь шалгарсан уу? Хүү нь хэдээр тохирсон бэ, яаж өгөх гэж байгаа юм бэ гэдэг энэ асуудалд хариулт авъя.

Дараа нь энэ Борнуурын сангийн аж ахуй гэж дээр үеэсээ Монгол Улсын Төв аймаг улсын хэмжээний төмс, хүнсний ногооны 60-70 хувь, тэр дундаа манай аймгийн голлогч хүнсний ногоо тариалагчид сум өвөлжингөө фэйсээр асуудал тавьсан. Энэ Борнуурын иргэдээс Улсын Их Хурлын гишүүдтэй очиж уулзах үеэр нь маш их асуултуудыг тавьсан, яаман дээр ч гэсэн асуудал хандаж ирсэн. Энэ асуудлыг одоо шийдэхгүй бол яг нөгөө усжуулалтын системийн толгойн барилгын асуудал дээр асуудал үүсэх юм бол Монгол Улсын хүнсний ногооны нийлүүлэлт дээр маш том асуудал үүснэ. Энэ дээр ямар арга хэмжээ авч байна гэсэн асуултыг асууя.

Нөөцийн махан дээр бид бүхэн энэ нөөцийн махны асуудлыг хийж байгаад энэ хөдөө аж ахуйн салбарт үйлдвэрлэл хийж байгаа малчдынхаа махны үнийг давхарт нь цохиж унагаадаг ийм асуудал яваад байгаа юм. Тэгэхээр энэ дээр цаашидаа ер нь өөрөөр хэрэгжүүлэх бодлого гэж юм ер нь төлөвлөж барьсан юм байна уу, эс үгүй бол ингээд л нөөцийн махаараа яваад л тэр нь гарч ирэхээрээ энэ чанар муу мөртөө малчдын авчирч борлуулж байгаа махны үнэд нөлөөлдөг энэ байдал чинь олон жил үргэлжиллээ шүү дээ. Энэ дээр ямар асуудал, бодлого цаашаа явж байгаа вэ?

Хүнсний ногооны тариалалт дээр хүнсний ногооны урамиуулал явж эхэлсэн. Өнгөрсөн оны гүйцэтгэлийн урамиууллын дүн хэдэн ногоо чинь хэдэн тонн ногоонд хэдэн төгрөгийн урамиуулал авахаар болсон бэ энэ дүн эцэслэж гарсан уу гэдэг асуултыг асууя.

Хамгийн сүүлд нэг салбартай холбоотой асуудал байгаа учраас нэг зүйлийг асууя. Ноолуурын үнэ дээр малчид маш их санаа зовж байна. Яагаад гэхлээр

хоёрхон орлого олж байгаа бүтээгдэхүүн цаг улирал нь дөхөөд ирсэн. Энэ нөгөө ноолуурыг түүхийгээр гаргах, угааж самнаж гаргах энэ асуудлууд чинь ер нь яг ямар түвшинд ямар шийдвэр гарсан бэ гэдгийг маш олон малчид чих тавин хүлээж байна. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөдхөөч гэсэн ийм.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Туваан гишүүний асуултад хариулъя. Энэ зудтай сумдад өвс тэжээл, өвс 20000 хүрээд, ногоон тэжээл 25000 хүрчихлээ. Энэ дээр ер нь цаашидаа ер нь ямар бодлого баримт ажиллах вэ гэж байна.

Энэний урьд жил бол өвс, ногоон тэжээлийн үнэ бол маш их хямд байсан шүү дээ. Тийм ч учраас 22 онд бол ногоон тэжээл, өвс бэлтгэх байдал бол бүр тайвширч бага бэлдсэн гэж хэлж болно. Тэгээд эрэлт, нийлүүлэлтээсээ болоод өвс тэжээлийн үнэ өссөн.

Ер нь цаашидаа бол ногоон тэжээлийг сум болгон тарих ийм бодлого хэрэгжүүлэх нь энэ цас зудтай, байгалийн гамшиг, хүндрэлтэй тэмцэхэд бол чухал зүйл болно гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам үзэж байгаа. Сумдаас санал аваад ногоон тэжээлийн үрээр хангах ажлыг зохион байгуулна гэсэн ийм байдалтай байгаа юм.

Ер нь цас зуд, байгалийн гамшигтай тэмцэх үүрэг нь бол аймаг орон нутгийн үүрэг байгаа шүү дээ. Хуулиараа. Онцгой тохиолдолд бас Улсын онцгой комисс ажиллаж дэмжлэг үзүүлэх ийм байдалтай байгаа. Амарсайхан Шадар сайд бид нар бол цас зудын байдал хүндрэлтэй бүх аймагт баруун Ховдоос авхуулаад Сүхбаатар, Дорнод хүртэл Увс, Завхан гээд бүх л аймагт газар дээр нь очиж ажиллаж, тодорхой шийдвэрүүдийг гаргаж, дэмжлэг үзүүлж бас ажилласан гэдгийг бас хэлэх байна.

Хоёрт нь үнэ тогтворжуулах арга хэмжээнүүд авсан. Гэтэл гурилын үнэ өндөр байна гэж байна. Ганц гурил гэхгүй бүх л барааны үнэ өссөн ийм статистик тооцоо гарсан байна лээ. Манай улсын гурил будааны үнэ бол бас бусад улс хөрш зэргэлдээ улс орнуудаас нь эрс өндөр зүйл байхгүй.

Одоо гаднаас улаан буудай, гурил орж ирэхэд манайд зарагдаж байгаагаас өндөр орж ирэх гэж байна. Оросын Холбооны Улс гэхэд хажуугаасаа түли, шатахуун, үр бордоо бүгдийг аваад тэгээд га-ын өндөр ус авдаг. Тэгсэн мөртөө гурил будааны үнэ үнэтэй байна, гурилын үнэ өссөн үндсэн шалтгаан бол гурилын үнийн зардалд 70 хувь нь улаан буудайд нөлөөлдөг. Үндсэн түүхий эдийнх нь үнэ нөлөөлдөг. Өнгөрсөн жил 600, 650-тай байсан улаан буудай 21 онд 22 онд 900-аас 1100000 хүрлээ. Ийм учраас үндсэн түүхий эд үнээс өссөн зах зээлийнхээ жамаар. Ингээд гурилын үнэ нь тодорхой хэмжээгээр бас 28 хувь өссөн ийм үзүүлэлттэй байгаа.

Тэгэхдээ 1 дүгээр гурилын үнэ бол бөөний үнэ 1600-1700 төгрөгтэй байна. Янз бүрийн тэр дээд, дээдийн дээд энэ тэр бол харилцан сайгүй өндөр өртөгтэй байгаа л даа.

Гуравт нь 135 тэрбумын их наядын 135 тэрбумыг 23 онд Хүнсний хангамж, аюулгүй байдлын тухай 36 дугаар тогтоолын хүрээнд зээлийн хүүгийн татаас олгоно. Энэ нь бол үндсэндээ 1 их наядын зээл гэсэн үг. Энэ 13 хувийг төрөөс даана. Жишээлбэл 18 хөдөө аж ахуйн хүнсний чиглэлийн аж ахуйн нэгжүүд банкнаас зээл авахад 18 хувийн хүүтэй зээл одоогоор авч байгаа. 13 хувийг нь төрөөс даахаар 5 хувьтай жилийн 5 хувьтай ийм хөнгөлөлттэй зээл авах ийм боломж бүрдэнэ. Энэ нь бол хүнсний хувьсгал, 33 дугаар тогтоолын хүрээнд явагдаж байгаа ажил гэж хэлж болно.

Борнуурын услалтын систем тэр толгойн барилга нь эвдэрсэн. Энэ дээр аймгийн даргаас манай яаманд бичиг ирсэн. Сумын дарга нар уулзсан. Эхний ээлжид 127 сая төгрөг

Г.Занданишатар: Хариултаа гүйцээ. Товч, тодорхой хариул.

Х.Болорчулуун: 127 сая төгрөг хэрэгтэй гэж байна. Энийг орон нутаг аймгаас өөрсдөөсөө та нар бас нөөцөөсөө энэ тэр гарга, бид харин цаашидаа энэ Борнуурын услалтын системийг сайн даацтай сайн сэргээхэд бол төслийн хөрөнгө оруулалтыг Хүнс, хөдөө аж ахуйн яам шийдье гэсэн ийм чиглэлтэй байгаа гэдгийг бас хэлье.

Тавт нь нөөцийн махан дээр махны үнийг нөөцийн мах гэж гарч ирээд малчдын махны үнийг унагадаг гэж байна. Олон жил бид нөөцийн мах бэлдэж нийслэлийн ард иргэдээ хямд махаар хангаж ирсэн. Энэ 22-23 онд ч гэсэн энэ ажил бас хийгдэж байгаа. Түрүүнд нөөцийн махны үнийн талаар бол 20 гаруй хувиар хямд байгаа. Зах зээлийн үнээс гэдгийг бас хэлсэн байгаа.

Ер нь цаашидаа бол нөөцийн махыг бэлдэх нь бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ажил биш. Энийг бол нийслэлд нь өгнө гэсэн ийм чиглэлтэй бичиг тоотуудыг илгээгээд байгаа. Нийслэл бол зорь, саваас гадна тэр сүлжээ дэлгүүрүүд бүгд ложистик нь байдаг учраас нийслэлд нь өөрсдөө бол ард иргэдээ хямд багатай байлгах дээр анхаарч ажиллах хэрэгтэй гэдэг үүднээс ингэж нийслэл рүү шилжүүлж байгаа. Нийслэл ч ер нь авахаар энэ жилээс бэлтгэл хангана гэж хэлээд байгаа юм.

Зургаад нь хэдэн тонн ногоонд урамшуулал өгсөн бэ гэж байна. Ер нь энэ жил анх удаа хүнсний ногоог Монгол Улс 73 хувиар хангалаа. Дотоодын хангамж. Урамшууллын нарийн тоог манай ажлын хэсэг, манай яамны газрын дарга хариулчих.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн 85.

Д.Есөн-Эрдэнэ: Туваан гишүүний асуултад хариулъя. Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ. Засгийн газрын 2022 оны 118 дугаар тогтоолоор дотоодын үйлдвэрлэлээс зах зээлд борлуулсан 10 нэр төрлийн хүнсний ногоонд урамшуулал олгодог болохоор ингээд шийдвэрлэсэн байгаа. Тэгээд өнгөрсөн оны 8 сараас эхлээд ингээд урамшуулал олгоод явж байгаа. Өнгөрсөн 5 сарын хугацаанд нийтдээ 32000 тонн хүнсний ногоонд 3.2 тэрбум төгрөгийн ийм урамшуулал олгосон байна. Нийтдээ 553 иргэн, аж ахуйн нэгжүүд хамрагдсан байгаа. Энийг сар болгон урамшууллын шинэ журмаараа сар болгон урамшууллыг нь олгоод явж байгаа.

Г.Занданишатар: 10 га, ноолуур хоёрыг хэн нь хариулах юм бэ? Болорчулуун сайд гүйцээж хариулъя.

Х.Болорчулуун: Туваан гишүүн ноолуурын үнэ асуулаа. Ноолуур бол бас энэ хаврын тарчиг үед малчдыг ёстой ганц мөнгөжүүлдэг, санхүүжүүлдэг ийм үнэ цэнтэй түүхий эд байгаа. Энэ жилийн ноолуурын үнэ ерөнхийдөө өнгөрсөн жилийнхээс буухгүй, магадгүй бага зэрэг өсөлттэй байх ийм дүр зураг харагдаж байна. Яагаад гэвэл ноолуурын үндэсний компаниуд барууны орнуудтай гэрээгээ өнгөрсөн жилийнхээ үнээс буухааргүй хийж байна. Урьдчилгааг энэ жил 130-аас зарим аймгуудад 150 төгрөгөөр урьдчилгаа тараагдсан ийм байдалтай байгаа учраас ноолуурын үнэ унахгүй, унахгүй гэсэн ийм ерөнхий чиглэлтэй, урьдчилсан прогнозтой байна.

Гэхдээ мэдээж ноолуурын үнийг бол яам ч юм уу тогтоохгүй зах зээлийнхээ жамаар явна. Энэ хэмжээгээрээ ноолуурын үнэ унахгүй болохоор малчдын орлого буурахгүй гэсэн ийм прогноз, урьдчилсан байдал харагдаж байна гэдгийг хэлье.

Г.Занданишатар: 83 Болорчулуун дарга.

Ц.Болорчулуун: Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Туваан гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Саяын сайдын хэлсэн ноолуур энэ дээр бас Монгол Улсын Засгийн газраас хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг гаргаж байгаа. Нийтдээ Монголбанкаар дамжуулаад 9 банкин дээр 500 тэрбум төгрөгийн ноолуурын эргэлтийн хөрөнгийн зээл гаргасан. Энэ удаа бид аж ахуйн арилжааны банкнуудтайгаа гэрээгээ байгуулаад, аж ахуйн нэгжүүдийнхээ мэдээллийг хүргэсэн. Нийтдээ 40 орчим үндэсний үйлдвэрүүд энэ зээлд хамрагдаад энэ хаврын ноолуур бэлтгэлд зээл аваад орохоор байгаа.

Тийм учраас ноолуурын үнэ дээр бас тодорхой хэмжээний өнгөрсөн жилээс ахицтай байна гэдэг энэ мэдээллийг бас хэлье.

Хүнсний ногооны 10 га нь энэ агро паркийн сум болгонд барина гэсэн ийм нэг маягийн зураг хийлгэсэн байгаа Энэ дээр тухайн сумдаа үр өгөөжөө өгөх, “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнтэй холбоотой Их Хурлын баталсан 36 дугаар тогтоолтой холбоотой энэ 10 га-гийн сум болгоны загвар зургийг гаргасан. Энэ ойролцоогоор 1 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн ийм тооцоо, судалгаа, зураг төслийг нь боловсруулчихсан байгаа. Энэ хүрээнд бол аж ахуйн нэгжүүд, сум орон нутаг руу энэ хөрөнгө оруулалт явах юм.

Гэхдээ энэ нь өөрөө 36 дугаар тогтоол дээр нэг заалт болоод орчихсон. Яг үүнтэй холбоотой хөрөнгө мөнгө хараахан тавигдаагүй хөрөнгө оруулалт дээр. Тэгэхдээ бид нар бол энэ гаднын зээл тусламжаар хэрэгжүүлэх тухайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдийн санхүүжилтээр энийг бас

хэрэгжүүлэхээр ингээд чиглэлийг нь өгөөд ажиллаж байгаа.

Тийм учраас энэ дээр бол зураг төсвийн дагуу бас тодорхой сумуудад ажлууд эхэлнэ байх гэж ингээж үзэж байгаа. 36 дугаар тогтоолын зээл бол яг бид арилжааны банкнууд руу манай яамнаас бүх саналуудаа өгөөд хамтарч гэрээ байгуулах энэ хүсэлтийг гэрээний загваруудаа хүргүүлчихсэн. Ирэх 7 хоногоос бол арилжааны банкнуудтай суугаад гэрээгээ байгуулчихвал зээлээ гаргаад эхлэх ийм бүрэн бололцоотой.

36 дугаар тогтоолын нийт 114 арга хэмжээнд тусгагдсан арга хэмжээнүүдээс бид нар энэ жилийн төсөвтөө багтаагаад бүх арга хэмжээ болгоноор нь төсвөө нарийвчлаад, задлаад банкнуудад хүргүүлчихсэн байж байгаа.

Г.Занданишатар: Ноолуур байна уу? Ноолуур нь болчихсон уу? Одонгийн Цогтгэрэл гишүүн асууна.

О.Цогтгэрэл: Хөдөө аж ахуйн салбарын асуудал яригдаж байна л даа. Эндээс мал аж ахуй гээд ярихлаар бэлчээр нь талхлагдсан зун, намар эндээс нэг өвлийн бэлтгэл, эндээс цас, цасаар залгаад зуд, зудаа залгаад малын хорогдол, энийгээ тойроод баахан өвс тэжээл хүргэж өгсөн ийм тайлан л ярьдаг.

Газар тариалан гэхлээр хаврын тариалалт, энийгээ дагаад ус гүйдэл, ган, ургац алдалт энийгээ дагаад тариаланчдын асуудал, өр зээл гээд яг ийм гинжин хэлхээ буюу нэг ийм асуудлын илрэл үзэгдлүүдийг л бид нар ингээд энэ чуулганы танхимд олон ч ингээд тойроод л ярьж байна. Яг асуудлын шалтгаан руугаа бид нар яг хөдөө, аж ахуйн салбарт ямар бодлого ер нь тавигдаж, хийгдэж байгаа юм бэ?

Жишээ нь тэр мал аж ахуйн салбарт гарч байгаа энэ хүндрэл

бэрхшээлийн чинь цаана ямар шалтгаан байгаа юм? Энэ бэлчээрийн талхагдалтын эсрэг одоо чинь хэдэн зуун мянган га-аараа зарим нь аймгийн нутагтай тэнцэх хэмжээний бэлчээр талхлагдчихлаа, дахин сэргээх боломжгүй болчихлоо л гэж байна.

Жишээ нь энэ бэлчээр дээр ямар бодлого баригдах юм? Энэ бэлчээр нь нөхөн сэргэдэг, мал нь ашиг шимтэй байдаг, ашиг шимээ дагаад малчид нь орлоготой байдаг энэ загвар руу ямар тоо хэмжээнд энэ загвар руу төрийн бодлого хөдөө Монголын хөдлөө аж ахуйн салбарын, мал аж ахуйн салбарын бодлого яаж чиглэж байгаа юм? Энэ бодлого чинь зөв зүйтэй чиглэвэл саяын тэр илрэлтэй тэмцээд байдаг цаст зудад хэдэн пресс онцгой байдлаас хүргэж өгсөн гэдэг энэ тайлангаас арай өөр зүйл бид нар уг нь ярьдаг болмоор байна шүү дээ.

Газар тариалангийн салбарт ч бас яг адилхан. Энэ бодлогын өөрчлөлт, шинэчлэлт маань хаана байгаад байгаа юм бэ? Энэ дээр бас та бүхэн байр сууриа болоод тэр бодлогоо бас зах зухаас нь хэлж өгөөч. Нууц биш бол.

Хоёрдугаарт нь ер нь энэ хөдөө аж ахуйтай чинь холбоотой бүтээмжгүй, бүтээмжгүйгээсээ болоод орлогогүй, орлогогүйгээсээ болоод хөрөнгө оруулалтгүй, хөрөнгө оруулалтгүйгээсээ болоод өрсөлдөх чадваргүй, өрсөлдөх чадваргүй гэдэг чинь тэгээд л бүх юм байхгүй л гэсэн үг. Энэ нэг циклийг гарахын тулд хөдөө, аж ахуйд энэ илүү нэмүү өртөг бий болдог илүү үнэ цэн бүтээдэг тэр арга барил, тэр бодлогын өөрчлөлт, яг хаана ямар бодлого барьж байгаа вэ? Энэ бүгд дээр ингээж бодлогоо та бүхэн энэ олон нийтдээ, энэ салбарынхандаа, магадгүй энэ шийдвэр гаргаж байгаа Улсын Их Хурал дээр энэ олон зүйлийн бодлогын өөрчлөлт танилцагдахгүй болохоор ийм асуудлын илрэлтэй тэмцээд явдаг, тэрийг орж ирээд энд тайлан болгоод ярьдаг, энэ цас зуд бид нар мянга мянган жил ийм л

нөхцөл байдалд, ийм л цаг агаарын нөхцөлд амьдарсаар л ирсэн шүү дээ.

Цаашидаа ч мянга мянганаар л ингээж л амьдарна шүү дээ. Тэгээд л энийгээ л яриад яваад байх юм уу? Тэгэхээр тэр бодлогын өөрчлөлт гэдэг зүйлийг л сонсохыг хүсэж байна. Энэ дээр тодорхой зүйлүүд байвал хэлж өгөөч.

Г.Занданишатар: Болорчулуун сайд бодлогын өөрчлөлт гэдэг юм байна уу гэж асууж байна.

Х.Болорчулуун: Монгол Улс социализмын үед 30 сая малтай байсан бол 71 сая малтай, төлтэйгөө бүр 90 сая хүрчихлээ. Энэ нь өөрөө бэлчээрийн талхагдалд оруулж байна. Бэлчээрийн даацыг бол 70 хувиар, ихэнх аймаг зүүн 2, 3 аймгаас бусад нь бол 70 хувь нь бэлчээрийн талхагдалд хүрсэн гэсэн ийм дүгнэлт, судалгаа гарсан байна.

Энэ нь бол болзошгүй аюул гамшиг, цас зудын үед бол бас энэ жил ч бас ханатай. Нөгөө оготно үржээд бэлчээргүй болгоод, өөрөө идэх өвсгүй болонгуутаа нэг л өвөл үхэцгээдэг шиг малыг ч гэсэн яг бэлчээрийн малыг бас ийм байдалд хүргэх ийм болзошгүй гэсэн ийм байдал харагдаж байгаа юм.

Тийм учраас цаашидаа малыг бол тоонд нь биш чанарт анхаарах нь зайлшгүй шаардлагатай. Энийг үеийн үе л ярьж ирсэн. Гэхдээ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас бол боомт бүхий газруудыг олон улсын жишигээр эрүүл бүс бай байгуулж, мал, махаа эрүүлжүүлж, эрүүл гэдгийг нь баталгаажуулж, олон улсын экспортод үнэ цэнтэй мах экспортод гарах ийм зорилготой төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ дээр баруун 3 аймаг, Увс, Ховд, Баян-Өлгий эрүүл бүс болно.

Хөвсгөл, Булган аймгийн 7 сум, Халх гол сум ийм хойд, баруун, зүүн гэсэн 3 газар эрүүл бүс байгуулахаар төлөвлөж ажиллаж байна. Тэгээд энэ дээр бол

малын бүртгэлжүүлэлт, ээмэгжүүлэлт энэ болгон хийгдэнэ. Олон улсын мал амьтны эрүүл мэндийн байгууллагын хяналт доор энэ эрүүл бүс явагддаг. Тэрнээс эрүүл бүс гэж дураараа өөрсдөө бид зарлах боломжгүй. Яг графикийн дагуу хугацаанд нь туулга, вакцин, тарилга болгоныг хийж явна. Энэ болгоныгоо ОИЕ-д мал амьтны эрүүл мэндийн байгууллагад мэдээлж байдаг ёстой.

Гол замууд дээр бол мал эмнэлгийн пост байгуулна. Үүнтэй холбогдуулан Мал, амьтны эрүүл мэндийн хуульд өөрчлөлт оруулна. Энэ хаврын чуулганаар оруулахаар бас бэлдээд байна. Ер нь бид бол олон улсын жишигээр л малаа экспортод гаргах ийм бодлого бол яг үнэндээ бол өнөөдрийг хүртэл яваагүй. Урсгалдаа амьдаар нь гаргаад, дулааны аргаар гэж Хятадтай хаана ч байхгүй тэр чанаж гаргадаг бол Хятад манайх хоёрын хооронд л тохиролцоо болохоос хаана ч байхгүй шүү дээ. Ийм байдлаар л мал махаа гаргаж байна.

Хоёрдугаарт, малаа эрүүлжүүлэхийн тулд энэ Хүнсний хангамж, аюулгүй байдлын тухай 36 тогтоолд 144 тэрбумыг тарилга вакцин тавьсан байгаа. Зөвхөн энэ онд 41 тэрбумыг малын эм тариа, вакцинд зарцуулахаар төлөвлөөд байгаа. Энэ бол ингэснээрээ бид малаа эрүүл болгож, бас өвчин тэр мялзан, шүлхий, цэцэг, халдварт өвчин нь сүүлийн үед ихэссэн энэ байдлыг багасгах, бууруулах, арилгах ийм боломж бүрдэх юм гэдгийг бас хэлэх байна.

Г.Занданишатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Өнгөрсөн жил өвс 4000 төгрөг байсан. Энэ жил 20000 төгрөг хүрлээ. Ногоон тэжээл 5000 төгрөг байсан энэ жил 25000 төгрөг хүрч байна. Тэгэхээр энэ нь юуг илэрхийлж байна вэ гэвэл яах вэ цас зудгүй жил үнэ хямд байдаг, цас зудтай жил яг энэ

талаар бизнес хийдэг тэр хүмүүс зовлон дээр зоолдог гэдэг л юм болчихоод байна л даа. Тэгэх дээр энэ юуг цаашидаа ямар чиглэл рүү аваачих вэ гэх дээр ерөөсөө сум болгон өөрсдөө өвс тэжээлээ бэлтгэдэг, ногоон тэжээлээ бэлтгэдэг, тэгээд тэр нь аягүй бол ингээд төрөөс, энэ төсвөөс ишийдэх маягаар тийм байдал руу аваачих дээр нөгөө жирийн бизнес хийж байсан тэр хүмүүс бас асуудалд орох ийм зүйл рүү очиж байгаа юм.

Тэгэхээр ер нь бол ийм манай яг энэ бизнес хийж байгаа хүмүүс 5 дахин нугалж юм хум зардаг. Зүгээр үедээ болохлоор 4000, 5000-аар юмаа зарчхаад яг ингээд зовлон болохоор 5 дахин нугалдаг ийм юм чинь арай л хэтрээд байна л гэж би хараад байгаа юм л даа.

Тийм учраас энэ баруун аймагт байгаа малчид өнөөдөр маш өндөр үнэтэйгээр өвс, ногоон тэжээл хэрэглээд байгаа юм. Тэгэхээр цаашидаа энэ ер нь сум болгон л өөрсдийнхөө одоо байнга л тэр өвс, ногоон тэжээлээ бэлтгээд, зудгүй жил ч гэсэн бас бордоод илүү өндөр жинтэй малаа нядлах, тэрнээсээ үр ашгаа хүртэх ийм л юм руу бүр хүрэх зайлиггүй шаардлага гарчхаж байгаа юм.

Тэгэхээр ер нь хэт их шуналтай байгаад байх юм бол бизнесүүд ээ энэ рүү чинь бас төр орж тэгээд та нарын бизнес чинь бүр байхгүй болох ийм юм руу л явах юм шиг харагдаад байгаа юм.

Яах вэ, ер нь энэ махны экспортын хувьд энэ квот гэдэг зүйл гарсан. 2016 онд нийтдээ жилийн эцсийн тооллогоор 75 сая толгой малтай байсан. Тэгэхэд 82000 тонн мах экспортолж байсан юм. Тэгээд улайдаггүй Улаан гэдэг нөхрийн квотын ачаар жил болгон экспорт буурсаар байгаад өнгөрсөн жил 2022 онд 91 сая толгой малтай мөртөө 16000 тонн мах буюу 5 дахин бага махыг гаргасан байхгүй юу даа. Тэгээд энэ квот гэдэг юм яасан их бизнесийг, ялангуяа махны экспортыг гацаагийн жишээ энэ. Тэгээд энэ гацалтыг Болорчулуун сайд гарч ирээд энэ

махны квотыг байхгүй болгосноор оны эхний 3 сарын, би бол төлөвлөлт 2 сар хагас болчхож байна тийм үү 3 сар ингээд дуусахад ойролцоогоор 32000 тонн мах гарна. Энэ чинь өнгөрсөн бүтэн жилийн экспорттой чинь тэнцэж байгаа.

Тэгэхээр квот гэдэг юмыг байхгүй болгох ямар их үр дүнтэй өөрөөр хэлбэл төрийн дарамт бизнес дээр байхгүй бол ямар их тийм үр дүнтэй гэдэг вэ гэдгийг л энэ харуулж байгаа юм. Тийм учраас энэ квотыг байхгүй болгосон энэ Болорчулуун сайддаа, Хөдөө аж ахуйн яамныханд бас талархал илэрхийлье.

Энэ маань цаашаа ингээд үргэлжлээд явах юм бол амжилтад хүрнэ гэж харж байгаа. Тэгэхдээ асуудал бий. Ямар асуудал байна вэ гэхээр та нарын тэр нөгөө Хятад руу экспортод гаргадаг компанийн дарга нарын үзэмжээр өөрсдийгөө юу ч хийж чаддаггүй тэр компаниудын нэрийг Хятад руу явуулдаг, Хятадад нь тэр нөгөө экспортын шинжилгээ хийлгээд, бичиг баримтын үнэлгээ хийхээр тэнд нь тэнцдэг 1 ч компанигүй болчихоод байгаа байхгүй юу.

Урьд нь яадаг байсан бэ гэхээр хилийн Мэргэжлийн хяналтын яам, Хөдөө аж ахуйн яам өрсөлдөөд өөр өөр компанийн нэр явуулдаг байсан бол одоо Мэргэжлийн хяналт байхгүй болчихсон танайх явуулж байгаа юм. Танайх чадваргүй компани явуулаад байна. Тэрийг явуулснаас болоод өнөөдөр тэнд чинь тэнцдэг 1 ч компани байхгүй болж байгаа.

Дээрээс нь зөвшөөрөл авсан тэр компаниудын чинь зөвшөөрөл хугацаа нь дуусаж байгаа юм. Сунгах асуудал ерөөсөө байхгүй. Тэгэхээр махны экспорт дээр энэ яг нэг стандарт чинь аттестатчилалд тэнцдэг компаниа явуулаач. Энэ дээрээ анхаараач гэж. Энэ дээр танай дээр асуудал гарна шүү гэдгийг хэлье.

Гурав дахь асуудал бол мах, амьд мал экспортлохоо боль л доо. Энэ чинь махны экспортын үнийг унагааж байна шүү дээ. Дулааны аргаар боловсруулсан мах 70 юань байсан. 1 килограмм мах нь 35000 төгрөг байсан. Гэтэл энэ 20 хэдэн мянган ширхэг хонь гаргаснаас болоод тэр махны чинь дулааны аргаар боловсруулдаг махны үнэ уначхаад.../минут дуусав./

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Хөдөө цас зуд хүндрэлтэй аймаг, сум дээр явж байхад малчид өөрсдөө хэлж байна. Бид бол үндсэндээ сүүлийн 10 жил бол тайвширсан өнтэй өвөл болсон. Тийм учраас өвс тэжээлийн бэлтгэх бэлтгэл энэ жил бас муу байсан. Үүнтэй уялдаад тодорхой хэмжээний мал бас хорогдож байгаа гэдгийг бас хэлж байгаа юм. Ер нь бас иймэрхүү юм бай байх ёстой. Цаашидаа бид нар зудтай ч байсан, өнтэй ч байсан өвс, тэжээлээ бэлтгэдэг ийм байдалд байхгүй бол болохгүй нь шүү гэдгийг энэ жил харууллаа. Ялангуяа энэ жилийн өвөл бол цаснаасаа илүү маш их хүйтэн, манай орон даяар хүйтний үргэлжлэх хугацаа их урт болсон. Энэнээс болоод мал их ядарсан.

Тэгэхээр тэр ногоон тэжээлийг Пүрэвдорж гишүүний хэлдгээр үнэхээр сум болгон хувийн аж ахуйн нэгжүүд дээрээ тулгуурлаж сум болгон тарьдаг ийм фонд, нөөц бий болгох зайлшгүй шаардлагатай байгаа юм. Тэгэхгүй бол нөгөө 4000, 5000 байсан өвс, ногоон тэжээл чинь 4, 5 нугалраад 20 гаран мянга, 20-25000 болчихсон ийм байдал бол их хатуу ойлголтыг бол малчдад, сум, аймгийн удирдлагуудад өглөө гэдгийг бас хэлэх байна.

Мэдээж энэ үнэ дотор бол Хүнс, хөдөө аж ахуйн яам оролцдоггүй. Зах зээлийнхээ жамаар энэ явж байгаа. Харин аймаг, сумдыг ногоон тэжээл

хувийн хэвшил дээрээ тулгуурлаж тарих ийм боломжийг, судалгааг нь авч тэжээлийн ургамлын үрээр улаан буудай, овъёосны үүрээр хангах энэ тэр ажлыг Хүнс, хөдөө аж ахуйн яам бас зохион байгуулах ийм чиглэл, бодлоготой ажиллаж байна гэдгийг бас хэлэх байна.

Амьд малыг бол миний өмнөх сайдуудын үед шийдвэр гаргаж байсан, ажиллаж байсан гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Өнгөрсөн жил 5 сараас 11 сарын 15 хүртэл мал, мах гаргахгүйтэй холбоотой махны үнэ маш хямдарсан, малчдын орлого буурсан.

Тийм учраас энэ жил бол 22-23 онуудад бол амьд мал гаргаж байгаа энэ байдлыг амьд нь ч бай, тэр дулааны аргаар ч бай бүхэл хэлбэрээр гарах байдлыг яам бол дэмжсэн. Хориглоогүй.

Ер нь цаашидаа бол мэдээж амьдаар нь их гаргаад байх нь бол ач холбогдолтой зүйл биш гэдэг нь ойлгомжтой. Энэ дээр бас яам анхааран ажиллана гэж бас хэлэх байна. Квотыг хэлсэн. Квот бол хонь, ямаа, адуу, тэмээ бүгд мах экспортлох квотгүй болгосон нь бол махны экспортод бас эерэг нөлөө үзүүлсэн. Баярлалаа.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Ер нь энэ хөдөө аж ахуйн бодлого буруу тийшээ яваад байна. Бодлоготой болчихсон биз дээ? Бодлоготой болсон байна. Цаашдын бодлогоо бас тодорхой ярьж чадахгүй байна. Одоо энэ дээрээ ажил. 32 жил, 20 саятай байсан малын тоо өнөөдөр 70 сая. Бодлого өөрчлөгдөх ёстой. Бүх юм өөрчлөгдөх ёстой байхгүй юу.

Тэгээд манай энэ төр засаг яг ямар замаар яваад байгаа нь тодорхойгүй яваад байна. Өнөөдөр бид бүхэн бас энэ хөдөө аж ахуйн салбар дээр Монгол төр Засгийн газар махны үнийг тогтоодог, улаан буудайн үнийг тогтоодог болчихсон. Энэ олон жил явж байгаа.

Махны үнийг экспортыг хорих нөөцийн мах гэдэг энэ асуудлаар хорьж байгаа юм. Уг нь Болорчулуун сайд аа та уг нь анх сайд болоод нөөцийн махны асуудлыг бүр байхгүй болгоно гээд ярьж байсан.

Харамсалтай нь өнөөдөр нөөцийн махны бодлого яриад ороод ирлээ л дээ. Тэгээд энэ ярьснаа шууд ажил хэрэг болго. Тэгэхгүй зүгээр ингээд ярихаар өөр, үйлдэл нь өөр байгаад байна шүү дээ. Одоо манай улаан буудай газар тариалан дээр газар тариалангийнхыгаа олон жил үнийг нь тогтоож ингэж явж байна. Нөгөө хэдэн төрийн элеватор тэгээд хөнгөлөлттэй зээл 2-оор тэгээд үнийг нь тогтоочихно. Тэгээд өнөөдрийн гол асуудлын нэг нь болохоор энэ гурилын үйлдвэрүүд газар тариалангийнхан хооронд нийгмийг хамарсан том маргаан үүсгээд эхэлчихсэн.

Ер нь манай энэ хөдөө аж ахуйн яам үндэсний үйлдвэрлэгч гэдэг нэр томъёоллоо ер нь ойлгож байгаа юм уу? Эсвэл албаар ингэж буруу яваад байгаа юм уу? Тариаланч, малчид 2 болохоороо түүхий эд бэлтгэн нийлүүлэгч. Байшин бариад улаан буудай тээрэмдэхээрээ үндэсний үйлдвэрлэгч, ноолуурыг угаадаг байшинтай болохоороо угаалгын машинтайнууд нь болохоор үндэсний үйлдвэрлэгч гээд ийм ойлголтыг нийгэмд өгчихсэн.

Сая тэр ноолуурын асуудал дээр энэ асуудлаасаа болоод та нар өөрсдөө унаж байна лээ шүү дээ. 300000 ажлын байрыг бий болгодог мал аж ахуйн салбар чинь жижиг, дунд үйлдвэрлэл буюу Монголын хамгийн том үндэсний үйлдвэрлэл байхгүй юу даа. Тэгээд ноолуурыг нь хилээр гарах боломжийг нь хорьж байгаад хямдхан үнээр тэр угаадаг хүмүүс аваад самнаад тэгээд ашиг олно гэдэг ийм бодлого та нар хийсэн шүү дээ. Харин ч хэлж, ярьж байж, ойлголцож байж энэ асуудлаа цэгцэлсэн.

Ер нь газар тариалангийн тариаланч нар маань урини хийгээд тэр

үйлдвэрлэл нь эхэлдэг. Малчид мал төллөх тэр цагаас эхлээд үйлдвэрлэл нь эхэлдэг. Хамгийн суурь үйлдвэрлэлийг энэ хүмүүс хийж байгаа юм. Хэрвээ ноолуур байхгүй бол тэр ноолуурын үйлдвэр байхгүй. Хэрвээ улаан буудай байхгүй бол гурилын үйлдвэр байхгүй. Энэ холбооснуудаа сайн ойлго.

Тэгээд өдөр, шөнөгүй л үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлнэ гээд л хуралдахын, семинар дээр юм ярих юм. Гаргаж байгаа шийдвэр нь болохоороо буцаад үндэснийхээ хамгийн том үйлдвэрлэгч нарын эдийн засгаар нь боомилдогт. Эдийн засгийн хориг тавьдаг. Яагаад энэ зах зээлийнх нь жамаар явуулж болохгүй байгаа юм бэ? Болорчулуун сайд та тэгвэл төр бүх энэ асуудалд оролцохоо больё гээд зарлачих л даа. Тэгээд л энэ чинь том бодлого шүү дээ. Энэ л бодлого байхгүй юу. Одоо бүгдээрээ харж байна. Хөгжлийн банк баахан газар тариалангийн аж ахуй нэгжүүдэд зээл авсан л гэж байна. Нөгөөдхийг нь буруутгаад л. Зээл авсан нь буруу. Үйлдвэрээс зээл авсан нь буруу. Үгүй та нар дуугарахгүй. Энэ салбарыг чинь хэн өмөөрөх юм. Энэ хувийн бизнес энэ аж ахуйн нэгжүүдийг чинь хэн өмөөрөх юм бэ? Хэн эд нарыг чинь хамгаалж, эрх ашгийг нь зөв болгож ингэж авч явах юм бэ? Энэ дээрээ дуугар л даа.

Өнөөдөр Монголын ард түмнийг хямд чанартай хүнсээр хэн хангах ёстой юм? Заавал тэр бүх боломжуудыг хааж, хил гаалиа хааж байгаад дотооддоо бүх юмыг үйлдвэрлэнэ гэдэг нь наад бодлогоосоо бас эргэж хараад ингээд зөв зохицуулалтуудыг нь хийж өгөөч.

Хэрвээ бүгдийг хаах юм бол хамгийн үнэтэй бүтээгдэхүүнийг л бид хэрэглэх болно шүү дээ.

Г.Занданшатар: Үг хэлчхэв үү? Жамбын Батсуурь гишүүн. Жамбын Батсуурь гишүүн алга байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Бөхчулууны

Пүрэвдорж гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн дэг сахъя. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн дэг сахъя. Бөхчулууны Пүрэвдорж гишүүд санууллаа. Ингээд цалингийн, Пүрэвдорж гишүүн санууллаа, сүүлчийн удаа санууллаа. Хурал хэвийн явуулмаар байна. Пүрэвдорж гишүүн хурал хэвийн явуулмаар байна. Пүрэвдорж гишүүн хурал хэвийн явуулмаар байна.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг гэж дууссан. Одоо Улсын Их Хурал дахь намын бүлгүүдээс төлөөлж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.11-т заасны дагуу D-Parliament цахим хэлэлцүүлгийн платформ дээр байршуулсан Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн саналуудыг Засгийн газрын гишүүнээс асууна.

Улсын Их Хурал дахь Монгол Арын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакир Засгийн газрын гишүүнээс асуулт асууна. Цаг эхэллээ.

Т.Аубакир: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхий сайдын хийж байгаа мэдээлэлтэй холбогдуулаад хаврын тариалалтын бэлтгэл ажил өвөлжилт хүнд байсантай холбоотой, хаваржилтын бэлтгэл ажилтай холбоотой иргэдээс маш олон асуулт ирсэн. Иргэдээс ирсэн асуултыг нэг бүрчлэн асуухгүйгээр үндсэндээ багцлаад асуугаад, хариулаад явъя гэж бодож байна.

Иргэн Доржбатаас энэ хавар нийт малын хэдэн хувь нь хорогдох талаар хийсэн тооцоо судалгаа бий юу? Яагаад гэвэл баруун аймгууд болон говийн аймгуудаар өвөлжилт хүндрэлтэй байсан. Хэдэн тооны мал хоргодож байгаа юм? Төр засгаас үзүүлж байгаа туслалцаа, өвс тэжээлийн үнийг хямдруулаад өгч байгаа явдал бий. Шадар сайд болон Хүнс, хөдөө аж ахуйн сайд бол

өвөлжилт хүндрэлтэй байгаа аймгуудаар явж ажилласан.

Тийм учраас өвс, тэжээлийн тодорхой хувийг хөнгөлөөд өгөх мэдээж хэрэг бүгдийг нь хангаж ажиллах бол бас амаргүй гэдгийг сая тойргоор явж байхад иргэд маань бас хэлж байна лээ. Тийм учраас хөнгөлөлтүүдийг үзүүлээд явсан.

Эхний асуулт бол нийт ер нь малын хорогдол гарсан дүн, тоо бий юу гэдэг асуултыг иргэн Доржбат гэж хүн асуусан юм байна. Ажлын хэсэг хариулах уу, сайд хариулах уу? Тоо юм бий юу, гарсан тоо?

Г.Занданшатар: Шууд хариулаад явна шүү асуултад.Цаг яваад байна шүү.

Х.Болорчулуун: Аубакир гишүүний асуултад хариулъя. Энэ жил 71.1 сая тоо толгой мал өвөлжсөн. Одоогийн байдлаар нийт өвөлжсөн малын 0.07 хувь буюу 1 хувь арай хүрэхгүй 564000 толгой мал хорогдоод байна. Цаашидаа хэдий хэмжээний мал хорогдох тооцоо судалгаа юу вэ гээд тэн дээр бол үнэхээр тооцоо судалгаа гэж прогноз гарахад хэцүү байдаг. Яагаад гэвэл манай бэлчээрийн мал аж ахуй зонхилсон энэ байдал маань бол цаг уурын байдлаас ихээхэн шалтгаалдаг. Хаврын ногоо гартал цас, зуд, шуурга ямархуу байх вэ. Энэнээс ихээхэн шалтгаална.

Гэхдээ харин санасныг бодвол өнгөрсөн жил ихэнх аймгаар ган гачиг болсон гэхэд бас тэр аймгуудад, ялангуяа баруун, баруун урд талын аймгууд бас хэтэрхий их цас ороогүй бас санасныг бодоход өвөлжилт бас гайгүй, малын хорогдол бас 1 хувь ч хүрэхгүй одоогийн байдлаар ийм байна гэдгийг хэлье.

Т.Аубакир: Баярлалаа. Иргэн Доржбатын асуусан хариултын. Иргэн Энхболдоос бас асуултууд ирүүлсэн бас асуултуудаа хацаж байгаа юм. Тэгээд ажлын хэсэг хариулах уу, Газар тариалангийн бодлогын хэлтсээс? Энэ

хаврын тариалалт ер нь хэдэн га-д хийхээр төлөвлөж байгаа вэ? Яагаад гэвэл энэ дэлхий дайнтай байгаатай холбоотой Орос, Украйны ийм байдал байгаатай холбоотой, Монгол Улс дотооддоо улаан буудайгаар хангах бодлогоо тасралтгүй авч явах ёстой. Энэ хаврын тариалалтын га хэдэн га-д тариалахаар байна? Энийгээ ирэх жилийн дотоодын гурилын үнийг өсгөхгүй хэмжээнд улаан буудайгаа хангах бололцоотой гэж үзэж байгаа юу гэж иргэн Энхболд мөн Сэлэнгэ, Дорнод аймгийн иргэдээс асуусан асуулт байгаа юм. Хэдэн га-д тариалах вэ, дотооддоо хангана гэж үзэж байгаа юу гэж?

Г.Занданишатар: Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ. Дугаараа өргө. 85.

Д.Есөн-Эрдэнэ: Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ байна. Энэ жил 393000 га үр тариа, үүнээс 369000 га-д улаан буудай тариалахаар ингээд бэлтгэл ажлыг хангаад ажиллаж байгаа.

Мөн 69000 га-д малын тэжээл, 66000 га-д тосны ургамал, 20 орчим мянган га-д төмс, 12.2 мянган га-д хүнсний ногоо тариалахаар ингээд бэлтгэл ажлаа ханган ажиллаж байгаа. Энэ жилийн нийтдээ 510000 тонн улаан буудай хурааж авахаар ингээд төлөвлөж байгаа.

Тэгэхээр энэ улаан буудай, төмснийхөө хэрэгцээг бол дотоодоосоо бүрэн хангахаар ингээд бэлтгэл ажлыг хангаад төлөвлөөд явж байна. Хүнсний ногооны тариалалт бас өнгөрсөн жилийнхээс бас зохих хэмжээнд нэмэгдэхээр байна.

Т.Аубакир: Баярлалаа. Гурав дахь асуулт маань энэ бусад аймгуудаас мөн миний бие болон манай аймгаас сонгогдсон гишүүд Баян-Өлгий аймгаар явж ажилласан. Энэ дээр гарч байсан асуултуудыг би бас ерөнхийлөн базаад би

асууя. Жишээлбэл Буянт сумын малын эмч Гаваадулам гуай, Улаан-Уул сумын Декат, Сагсай сумын Серикгүл, Дэлүүн сумын ахмад малын эмч Бадел, Бугат сумын малын эмч Жанад, Алданеш, Алтанцогт сумын малын эмч Богетбек зэрэг эмч нар малын эмч нар маань яг л нэг утга агуулгатай асуултаа асуусан юм.

Бид нар тойргоороо үндсэндээ сар гаруй явж ажилласан. Өвөлжилт энэ жил хүндрэлтэй байгаа. Сумууд дээр хэдий малын тасаг байгаа боловч малын эмч нарын үйлчилгээ маань хоршооны байдалд шилжсэн нь манай аймагт үндсэндээ явах ийм боломжгүй болж байгаа юм. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх. Энэ байгаа бодлого маань ер нь реформ хийхийн хэмжээнд оччихсон юм биш үү? Энэ малын эрүүл мэндийн асуудал ер нь явсаар байгаад саяын яриад байгаа мал махны экспорттой салиггүй холбоотой. Гадаад зах зээл дээр үндсэндээ манай малын эрүүл мэндтэй холбоотой зарим асуудлууд зогсдог. Энэ дээр малын энэ, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх малын эмч нарын маань ярьж байгаа асуудал бид нар санхүү мөнгө хангалтгүй болсон. Бид нар дуудлага аваад 5000 төгрөгөөр тариа хийх гээд явдаг.

Гэтэл 20-30 километр бид нар өөрсдийнхөө унаа бензинээр очиход ямар ч ингээд эдийн засгийн тооцооллын, үндэслэлгүй ийм байдал бий болчихлоо. Монголын төр засаг маань цаашидаа энэ бодлогоороо яваад байх юм уу? Энэ малчдын амь, амьжиргааны эх үүсвэр болсон энэ малын эрүүл мэндийн асуудал чинь хаягдаж байгаа юм биш үү? Үгүй бол сумын тэр малын тасгийн эрхлэгчид байдаг юм уу эд нар маань ерөөсөө арга барил, энэ технологийн хувьд мэдээ мэдээлэлгүй болчихсон ийм томилгоогоор очсон хүмүүс чинь байгаа юм уу? Энэ Засгийн газар энэ хөтөлбөрөө эргэж хараач ээ, вакцины зарим төлбөр удаашралтай орж байна, вакциныхаа төлбөрийг авч чадахгүй байна, хоршоолол маягаар яваа нь ерөөсөө мухардалд орлоо

гэснийг үндсэндээ 12 сумын 10 орчим сум дээр дандаа малын эмч нар. Ерөөсөө бид нарын уулзалт болгон дээр малын эмч нар байсан.

Тийм учраас Мал эмнэлгийн ерөнхий газар маань энэ төр засгийн баримталж байгаа энэ бодлогод ер нь дүн, үнэлгээ, шинжилгээ хийсэн юм байна уу? Цаашаа Монгол Улс маань малынхаа эрүүл мэндэд хувийн хэвшилүүддээ даатгаад явах юм уу? Энэ дээр Мал эмнэлгийн ерөнхий газраас цаашид энэ бодлогыг өөрчилж, үгүй бол энэ бодлого нь онц сайн байгаа юм гэсэн гаргасан энэ ажилдаа хийсэн үнэлгээ, дүгнэлт гэж юм бий юу гэж яг сумууд дээр, яг фронт дээр ажиллаж байгаа малын эмч нар маань асууж байна шүү дээ. Энэ дээр хариулт өгчих. Энэтэй холбоотой дараагийн асуултаа би бас тавья. Ер нь энэ бодлого энэ зөв үү, реформ хийх шаардлагатай гэж үзэж байна уу гэж .

Г.Занданшатар: 84, Тунгалаг Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын даргын албан үүрийг түр орлон гүйцэтгэгч.

Т.Тунгалаг: Аубакир гишүүний асуултад хариулъя. Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч Тунгалаг. Монголын хэмжээнд мал эмнэлгийн анхан шатны үйлчилгээний нэгжид 1006 аж ахуйн нэгжид 1387 малын эмч жилийн эцсийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа дүн гарсан. Нийтдээ энэ мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхэлж байгаа малын эмч нарын маань насжилт бол маш өндөр болсон. Нийт мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж байгаа малын эмч нарын маань 62 хувь нь 50-аас дээш насны малын эмч нар болсон.

Тийм учраас манай салбарын анхан шатны нэгжүүдэд мал эмнэлгийн ажил үйлчилгээ гүйцэтгэх боловсон хүчний дутагдалд орох ийм эрсдэлтэй болж байгаа. Тэгээд үүнтэй уялдуулаад Мал

эмнэлгийн Био технологийн сургуультай хамтарч малын эмч нарыг цаашидаа бэлтгэх, орон нутагт ажиллаж байгаа ялангуяа саяын энэ асуултууд дээр гарсан Мал эмнэлгийн тасагт ажиллах боловсон хүчнүүдийг цаашидаа бодлогоор бэлтгэх энэ талаар бол Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, удирдлагууд хамтран ярилцаж малын эмчийн мэргэжлээр суралцах оюутны тоог нэмэгдүүлэх, энд суралцах оюутнуудыг орон нутаг болон бусад төсөл, хөтөлбөрийн шугамаар сургалтын төлбөр дээр хөнгөлөлт үзүүлэх талаар ярилцаж байна.

Түүнээс гадна Улсын Их Хурлын Хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарсан 04 дүгээр тогтоол, Түр хорооны тогтоол, Хүнсний аюулгүй байдлын 36 дугаар тогтоол зэргүүд дээр бол Монголын мал эмнэлгийн салбарт ажиллаж байгаа боловсон хүчнийг чадавхжуулах, мал эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг бэхжүүлэх тал дээр дорвитой арга хэмжээ авах талаар үүрэг, чиглэл өгсөн.

Үүний дагуу мал эмнэлгийн салбарт төрийн ажил үйлчилгээг гэрээ, захиалгаар гүйцэтгэж байгаа энэ хувийн мал эмнэлгийн эмч нарыг мал эмнэлгээ бэхжүүлэх, ашигийн төлөө энэ байгууллага дээр зөвхөн урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсөөр амьдрахгүй. Бусад ашиг орлогоо олдог бусад мал эмнэлгийн төрлийн үйлчилгээг үзүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 2023 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангаас олгох хөнгөлөлттэй зээлд хамрагдах салбар нэгжийн тоонд Мал эмнэлгийн үйлчилгээ орсон.

Энэ хөнгөлөлттэй зээлд бол өнөөдрийн байдлаар албан бус мэдээгээр 40 орчим мал эмнэлгийн нэгжийн 3.4 тэрбум төгрөгийн төсөл авах ийм саналууд ирсэн гэсэн байдалтай байгаа. Тэгээд ерөнхийдөө бол мал эмнэлгийн үйлчилгээг зөвхөн гоц халдварт өвчний үйлчилгээ, халдварт өвчнөөс урьдчилан

сэргийлэх тарилгын үйлчилгээнээс гадна үйлчлэх хүрээг өргөтгөх, 1 малын эмчид ноогдох малын тоог багасгах байдлаар малын эмчийн ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлж, малын эмчийн тоог нэмэгдүүлэх ийм бодлогыг зайлшгүй барьж ажиллах шаардлагатай болж байгаа. Улсын дунджаар бол 1 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид улсын дунджаар 90.1 мянган мал ноогдож байна. 1 малын эмчид 79000 мал ноогдож байгаа нь олон улсын дундаж жишгээс 3-5 дахин өндөр үзүүлэлттэй ийм дүнтэй байгаа.

Тийм учраас цаашидаа анхан шатны нэгжид мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэхэд орон нутагт ажиллах малын эмч нарыг бодлогоор бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах тал дээр бол бодлогын том том ажлуудыг хийх зайлшгүй шаардлагатай байгаа.

Т.Аубакир: Баярлалаа. Боловсон хүчин маань, бэлтгэгдсэн боловсон хүчин чинь тэнчээ очоод орлого санхүү нь хангалттай биш, ажиллах орчинд таатай биш техник механикжуулалт төхөөрөмжийн асуудал шийдэж өгөхгүй бол тэр алслагдсан бүс, аймгуудад бол малын эмч ажиллахгүй л дээ. Боловсон хүчнээ бэлтгэх ажил явах ёстой мөн. Үүний хажуугаар наад зах нь хавар болж байна. Вакцинжуулалтын ажил эхэлнэ. Сайдаа танай Мал эмнэлгийн ерөнхий газар даргагүй л сууж байгаа жишээлбэл. Энэ ажлаа яаж удирдан зохион байгуулах юм? Энэ тэрээ бас анхаараад явахгүй бол малын халдварт өвчин гэдэг бол тоглоом биш л дээ. Энэ дээр 2022 онд үндсэндээ вакцинжуулалт бол маш сайн явсан. Энэ оных нь чухам яаж явах юм байгаа юм. Зөвхөн боловсон хүчнээ бэлтгэх асуудлыг одоо яриад суух юм бол хангалттай биш л дээ.

Ер нь улсын төсөв яригдах үед бол энэ мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг хоршоолол маягаар байж байгаа энэ малын эмч нарынхаа энэ техникжүүлэлт,

унаажуулалтын асуудал энэ тэр дээр анхаарахгүй бол болохгүй байх гэсэн зүйлийг сая тойргоор явсан ихэнх гишүүд ярьж байгаа учраас би энийг ярьж байгаа юм.

Дараагийн нэг асуудал бол би 2022 оны 10 сарын 22-ны өдөр Байнгын хорооны тогтоолоор мал, махны экспортын ажлын хэсгийг Байнгын хороон дээр би ахалж ажилласан. 6 гишүүний хамтаар. Одоо тухайн үед бол 2 улс руу экспорттой байсан бол 8, 9 улс руу экспорт явж байгаа. Мал махны экспорт бол маш сайн явж байгаа. 3 дахь хөрш буюу Узбекистаны хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд яг өнөөдрийн байдлаар Хөдөө аж ахуйн яамны урилгаар ирээд Монгол Улсад ажиллаад явж байгаа. Монгол Улсаас мал, мах авъя, дээрээс нь арьс ширний үйлдвэрт хөрөнгө оруулах асуудлыг яриад явж байгаа юм.

Энэ мал, махны экспортын ажил бол нэг үеэ бодвол сайн явж байгаа. Хятад Улсын хил 3 жилийн хугацаатай хаалттай байсан. Манайхаас импортоор мах хүлээж авах боломж байхгүй байсан. Хил нээгдээд бол махны экспорт мэдэгдэхүйц нэмэгдээд явж байгаа. Үүнтэй холбоотой Монгол Улсын Засгийн газар мөн бог мал буюу адууны махны квотгүй болгосон. Одоо энэ маань юу гэж хэлж байна гэхээр бизнес эрхлэгчид маань тэр гадаад улсад очоод өөрсдөө харилцах худалдан авагч талтайгаа л ажиллах асуудал үлдэж байгаа юм. Монголын төр засгаас мал, махыг гаргахгүй гэсэн ямар хориг саад байхгүй.

Үхрийн махан дээр тодорхой хэмжээний хориг байх ёстой. Яагаад гэвэл нийт сүрэг дотор эзэлж байгаа үхрийн энэ сүргийн бүтцийн тоо нь өөрөө тийм хангалттай биш байгаа учраас үхрийн махан дээр тодорхой хэмжээний квоттой явж байгаа. Энийг Засгийн газар энэ шийдвэрийг гаргасан. Энэ маань нэгдүгээрт малчдын гар дээр байж байгаа амь амьжиргааны эх үүсвэр болсон малыг валют болгох, дээрээс нь

бэлчээрийн даац хэтэрсэнтэй холбоотой малын зүй зохистой тоо хэмжээнд аваачих нэг бодлого.

Мөн сая тойргоор явсан гишүүд намайг асуулт асуухтай холбоотой саналуудаа хэлсэн. Бэлчээрийн даац хэтэрлээ. Монгол Улсын Хөдөө аж ахуйн яамнаас энэ бэлчээрийн даацыг малын тоо толгойг зохистой түвшинд аваачихад ямар ажил, санал санаачилга гаргаж ажиллаж байгаа юм? Энэ чинь Баянхонгор аймгаас эхлээд үндсэндээ цөлжилт илт нүдэн дээр байна шүү дээ. Малчид маань өөрсдөө хэлж байгаа юм. Малчдын хэлсэн саналаар өнгөрсөн жил Монголын Улсын Их Хурал маань малын тоо толгойн татвар гэдэг зүйлийг санаачлаад малчдын өөрсдийнх нь гаргасан саналын хүрээнд малыг тоо толгойн татвартай болгосон. Дээд талын хэмжээ нь 2000 төгрөг. Сум орон нутгийн Иргэдийн хурал нь малынхаа тоо, толгойн татварыг тухайн нөхцөл байдалдаа тохируулж тогтоох эрхийг нь хүртэл өгөөд явж байгаа юм. Энэ маань мөн малчдаас гарсан санал.

Бэлчээр нэгнийхээ өвөлжөөд очоод зусчихдаг, намаржаанд очоод хаварждаг. бэлчээр нь ерөөсөө болохоо байсан юм байна шүү дээ гэдгийн үндсэн дээр үндсэндээ Монгол Улсын төр шат дараалалтай арга хэмжээнүүдийг ажиллаад явж байгаа. Малын тоо, толгойн татвартай болголоо. Бог малыг гадагшаа экспортод гаргахад квотгүй болголоо.

Дээрээс нь мал, махны экспортын ажлын хэсгийн Байнгын хороон дээрээс өгсөн чиглэлийн дагуу 7 байгууллагын бичиг баримтыг 40 гаруй хоног явж бүрдүүлдэг байсан бичиг баримтыг нэг цонхны үйлчилгээтэй болгоё. Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Стандарт, хэмжил зүй, Хөдөө аж ахуйн яам зэрэг бүх бичиг баримтыг Хөдөө аж ахуйн яаман дээр нэг цонхны үйлчилгээгээр тухайн бизнесменүүдэд хүндрэлгүй болгоё гэдэг асуудлыг

шийдэхийн тулд Байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу Хөдөө аж ахуйн яамны дэд сайдаар удирдуулсан ажлын хэсэг ажиллаад явж байгаа.

Монголын төр ажлаа хийгээгүй биш тодорхой хэмжээнд хийгээд явж байгаа. Нэг үеэ бодвол Монголын малчдын гар дээр маш олон сая толгой мал бий болжээ. Энэ нь тодорхой хэмжээний хууль, эрх зүйн хүрээнд зохицуулалт хийх ажлуудаа хийгээд явж байгаа юм. Үүнтэй холбоотой гадагшийг шинэ зах зээл бий болгох түрүүн Пүрэвдорж гишүүн асууж байгаа юм. Хятадын талын импортоор авах зөвшөөрөл дээр Хөдөө аж ахуйн яам зарим аж ахуйн нэгжүүдийн бичиг баримтыг дараад аваад үлдчихдэг юм биш үү? Хятад талдаа тэр бичиг нь очихгүй байна гэж. Энэ ганц үлдсэн асуудал бол энэ. Сайдаа та энэ дээр бас анхаарал хандуулж ажиллах хэрэгтэй.

Гадаад харилцааны яамнаас нь асуухаар манайд Хөдөө аж ахуйн яам тэр бичиг баримтаа ирүүлээгүй гэж. Энэ маань Хөдөө аж ахуйн яамыг гадаад харилцаагаа сайжруулах шаардлагатай болчихжээ гэдгийг харуулж байгаа.

Мал, махны экспорт, дулааны аргаар хөлдөөсөн, гүн хөлдөөсөн, хөргөөсөн мах гараад явж байгаа. Үүний зэрэгцээ амьд мал гарч байгаа. Гарах ёстой юм. Монгол Улс экспортлох боломжтой зүйлийг малчдадаа эргээд үнэ хүргэхийн тулд амьд мал гаргахыг би бол хувьдаа дэмжиж байгаа. Энийг нэг бол тэр мах нядалдаг үйлдвэрүүдийн лоббигоор зарим хүмүүс хэл ам хийдэг. Амьд мал гараад байна, болохоо байлаа цаана чинь хөөе та минь ээ гээд л уриалдаг. Үгүй энэ чинь Монгол улс гадагшаа экспорт хийж амьдрах л ёстой шүү дээ. Эргээд тэр хэдэн төгрөг нь тэр малчид дээрээ л очиж байгаа л асуудал. Гэх зэргээр мал махны экспортын ажил сүүлийн үед явж байгаа.

Мөн үүнтэй солиггүй нэг холбоотой зүйл бол Хөдөө аж ахуйн яам маань энэ

эрүүл мэндийн мал эмнэлгийнхээ үйлчилгээг маш сайжруулмаар байна. Сая тойргоор явж байхад ерөөсөө сум болгон дээр очиж хэлж байгаа юм. Нөгөө хэдэн малын эмч нь ядарчихсан, хөл дүүжлэх унаа байхгүй, нөгөө вакцины хэдэн төгрөг хараад амьдрах ямар ч бололцоо, мал ихтэй аймаг дээр болдог байх. Мал цөөтэй аймгууд дээр тэр чинь малын эрүүл мэндийг хэн харж хамгаалах юм? Энэ тал дээр мөн сайдаа та бас реформын шинж чанартай эргээж энэ дээрээ мониторинг, дүгнэлт хийгээд эргээж харах асуудлууд байгаа юм.

Тэгээд иргэдээс ирсэн асуултууд маань яг энэ хүрээнд байсан учраас асуултаа асууж, хариултаа авлаа. Баярлалаа.

Г.Занданишатар: Дуусах уу, болчихсон уу? Одоо Ардчилсан намын бүлгийг төлөөлж Наянтайн Ганибал асуулт асууна.

Н.Ганибал: Буруу, зөв ярьж байгааг та өөрийнхөөрөө үгүй, үгүй та өөрийнхөөрөө хариулчих. Тэгэхээр таны бодлыг бас ард түмэн сонсог л доо. Иргэд сонсог. Зөвхөн надыг буруутгах нь гол асуудал биш байх. Яг энэ бэлчээрийн асуудал ингээд сая ингээд зөндөө л олон асуултууд явлаа. Бэлчээрийн асуудал дээр салбарын яам ер нь ямар бодолтой байгаа юм? Сая Барилга, хот байгуулалтын яамнаас Газрын тухай багц хууль орж ирэнгүүт манай хөдөө аж ахуйн салбарынхан маань, яамныхан маань биднээс асуугаагүй гэдэг асуудал яриад байна лээ. Үгүй тэр багц хууль дээр хөдөө аж ахуйн газрын асуудал, эдэлбэр газруудын асуудлууд болохоороо бэлчээрийн асуудал нэн ялангуяа журмаар зохицуулна гээд ороод ирсэн. Энэ дээр та байр сууриа хэлээч.

Х.Болорчулуун: Ганибал гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яамнаас бол Газрын хуулийг оруулж ирээд сая эргээд бас татчихлаа. Энэ дээр бол Газрын хууль

дээр зайлиггүй нэг хөдөө аж ахуйг дэмжих бас энэ бэлчээртэй холбоотой ажил байсан. Энэ юу вэ гэвэл одоо манай ферм, эрчимжсэн аж ахуйнууд хажуудаа газар хагалаад ногоон тэжээлээ, малын тэжээл тарих ийм боломжгүй хуулиараа. Атар газар хагалахыг зөвхөн Засгийн газрын тогтоол шийдвэр гаргана гээд заачихсан байгаа.

Тийм учраас энэ эрчимжсэн аж ахуй фермерийнхэн хажуудаа бол ногоон тэжээл тарих, малын тэжээл тарих ийм боломжийг бол хангаж өгсөн, санал оруулаад явж байгаа. Ингэснээрээ бол бас хагас бэлчээрийн байдлаар мал аж ахуйгаа одоогоор авч явах ийм боломж бүрдэх юм гэдгийг хэлье.

Мөн энэ малын хөлийн татвар дээд тал нь 2000 хүртэл авна гээд заачихсан байгаа. Энэ бол өчүүхэн л дээ. Бүр 1 хувь ч хүрэхгүй. Ялангуяа тэр бэлчээрийг хамгийн их талхилдаг адуу, ямаан дээр арай өөр татвар авбал ер нь зохимжтой гэдгийг малчид өөрсдөө хэлж байгаа юм.

Тийм учраас 2000 гэдэг чинь жилдээ 10 гаруй хувийн инфляц явагдаж байхад дороо л 2000-ынхаа таазанд бараг тулчих гээд байгаа юм. Тэгэхээр доод үнийг малын хөлийн татварын доод үнийг 1 нэгж буюу 1000 төгрөг, дээшээ бол чөлөөтэй сумын иргэдийн хурал тогтоохоор ийм саналыг яамдаас аваад явж байгаа. Тэгээд Сангийн яам энэ дээр бас татвар нэмэгдчихнэ гэсэн байдлаас илүү болгоомжлолтой бас хандаад байна.

Ер нь тэгээд малын хөлийн татвараар бас бэлчээрийн даацыг зохицуулна уу гэхээс биш хүчээр та нар ийм төрлийн мал өсгөж, үржүүл энийг боль гэж хүчээр малчдыг бол нөгөө социализмын үе шиг заах ямар ч арга байхгүй. Үнэхээр энэ янзаараа тэгээд 70 хувь нь бэлчээр доройтолд ороод байвал цаг агаар бурхан тэнгэр л энийг ер нь багаас зохицуулчихна шүү дээ.

Н.Ганибал: Харилцан яриад явчихсан тийм ээ.

Г.Занданишатар: Асуулт, хариулт мэтгэлцээний журмаар явна.

Н.Ганибал: Ер нь бүгд ойлгож байгаа. Бүгдээрээ мэдэж байгаа. Нүдэн дээр цөлжилт явж байна, нүдэн дээр өвс, ургамлын гарц муудаж байна. Бүгдээрээ мэдээд байгаа байхгүй юу. Хамгийн гол нь тодорхой бодлого л хэрэгтэй. Тодорхой. Энэ чинь Монгол Улсын нийт бэлчээрийн даац маань өөрөө бараг 2 дахин, зарим газраа бараг 10 дахин илүү даац нь хэтэрчхээд байна шүү дээ. Энэ зохицуулалтыг бид нар хийх ёстой юм уу? Энэ чинь шинжлэх ухаан байгаа шүү дээ. Энэ хэмжээний газар, нутаг дээр хэрвээ тал хээрийнх бол тэдэн хонин толгой, хэрвээ хангайд бол хэдэн хонин толгой гээд ингээд бүгдийг нь заагаад өгчихсөн.

Тэгэхээр энэ чинь тодорхой хязгаарлагдмал юм руу очих ёстой байхгүй юу. Тэр чинь өөрөө бодлого. Тэр нь өөрөө малын тоо байх юм уу? Тэр өвөлжөө, хаваржааны газрын хэмжээ байх юм уу? Ийм юм руу бид нар зайлшгүй орох шаардлага өдрөөс өдөрт бид нарт ингээд тулгараад байна.

Магадгүй Дорнод аймаг арай гайгүй гэж харагдаад байж магадгүй. Тэгэхдээ Сүхбаатар аймагт энэ жил бэлчээрийн даац, бэлчээрийн хүрэлцээгүйгээс болоод өвөлжилт маш их хүндэрлээ. Өвөл хүйтэн боллоо. Яг намар мал, мах бэлддэг тэр цаг дээр нь малчдыг орлоготой байлгаж чадсангүй. Энэ бас бодлого мөн үү, биш үү? Та бүхэн бүгдээрээ санаж байгаа бол Монголын ард түмэн бүгд санаж байгаа. Тэр zarig.mn, pegui.mn гээд 2 сайт гарч ирээд Монголын махны салбар дээр, Эмээлт дээр тулаан хийсэн.

Тэгээд тэр нь өөрөө бүх махны экспортыг зогсоосон гэнэ. Санаатай юу, санаагүй юу? Энэ бол санамсаргүй мөртөө санаатай бодлогын ажил байсан. Тэгэхээр махны экспорт түрүүн эргээд би

хэлье тэр махны нөөц, нөөцийн мах гэдэг чинь малчдын маханд үнэ тогтоогоод байгаа байхгүй юу сайд аа. Үнэ тогтоогоод байна шүү дээ. Таны гурилыг зарж байтал нэг нөхөр гарч ирэнгүүтээ Засгийн газар ийм үнээр л гурил зарна гээд нэг үнэ тавьчихаад хажууд нь нэг үйлдвэр гурил зараад байвал яах вэ. Мэдээж тухайн гурилын үнэд нөлөөлнө шүү дээ.

Энэ бодлогын асуудлууд нь ингээд бие биетэйгээ дандаа уялдаатай байгаад байгаа байхгүй юу. Бэлчээр, орлого, өвс хадлан тэжээлээ бэлдэх гээд бүх юм. Тэгээд энэ намар, энэ өвөл малчид маань хангалттай өвс хадлан тэжээлээ бэлдэж чадаагүй. Одоо тэр зовлонг бүгдээрээ үүрч байгаа. Бид нарын та бүхний өнөөдөр танилцуулсан тэр цаасан дээр байгаа аюулгүй байдлын өвс, хадлан тэжээл бүгд худлаа. Бүгдээрээ дуусчихсан. Бүгд 20000 төгрөгөөр тэр өвүүдээ авахыг нь аваад, зарахыг нь зараад хөнгөлөлттэй үнээр зарахыг нь зараад бүгд ашиглаад дуусчихсан. Тэгээд ийм л асуудлууд байгаа.

Тэгэхээр энэ дээр бид нар одоо ингээд юу гэж хэлэх юм бэ дээ ингээд аясаар нь явна гэдэг ойлголт өнөөдөр ингээд уг нь зогсох ёстой юм. Энэ дээр зайлшгүй бэлчээр дээр нэлээн бодлоготой, ард иргэддээ ойлголттой, ойлгуулсан тэгээд дараа нь шийдвэртэй ийм бодлого зайлшгүй хэрэгтэй байна гэдгийг хэлье.

Хоёр дахь асуудал бас иргэдээс асууж байгаа асуулт л даа. Хөдөө аж ахуйн яам маань Монголын бүх үхрийг ээмэгжүүлнэ гэсэн. Энэ ээмэгжүүлэлтээс гарах үр дүн юу юм бэ гэдгийг асууж байгаа юм.

Г.Занданишатар: Шууд явж байгаа.

Х.Болорчулуун: Малыг индексжүүлэн бүртгэлжүүлэх өөр хуультай малын энийг нөөцийн хуулиар заагаад өгчихсөн байгаа. 18 онд батлагдан гарсан. Бид бүгдээрээ баталсан шүү дээ. Үүгээр бол

индексжүүлэн бүртгэлжүүлнэ гэдэг чинь бол чихэнд нь зүүдэг болохоор ээмэг гэгчээд байгаа юм. Тэрнээс энэ гоёлын эмэг биш байхгүй юу. Бүх үхэр, мал үл давтагдах код дугаараар ингээж бүртгэлд орно. Улсын нэгдсэн санд орно. Энэ нь бол хаанахын ямар аймгийн, ямар сумын, хэний малчин бэ гэдэг нь тодорхой болно. Ямар вакцин, туулга хийсэн бэ гэдэг нь тодорхой болно.

Энийг бол сая бол эсэргүүцэх ч юм уу ойлгохгүй хүмүүс баахан социалаар сэвлээ л дээ. Манайх шиг мал, махаа ялангуяа таваарлаг, үхрээ бүртгэлжүүлээгүй, өөрөөр хэлбэл ээмэгжүүлээгүй ийм ус дэлхийд байхгүй. Бид энэ ажлыг хийнэ. Цаашидаа хийх болно. Хэн яаж хориглолт, эсэргүүцэж байсан ч гэсэн. Бид ингээж хийж байж ялангуяа үхрийн махаа экспортод гаргах боломж бүрдэнэ олон улсын жишгийн дагуу.

Гэхдээ энэ жилийн хувьд бид нар Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас зөвхөн мал эмнэлгийн дэглэм бүхий эрүүл бүсүүддээ баруун 3 аймаг, Дорнод аймаг, Хөвсгөл аймаг, Хэнтийн Дадал гээд ийм газруудаар бүртгэлжүүлэлтийн ажлыг хийнэ үхэр дээрээ. Энэ ч өөрөө OIE буюу мал, амьтны эрүүл мэндийн байгууллага заавал ингээж индексжин бүртгэлжүүлэх, кодолж өөрөөр хэлбэл ээмэгжүүлэхийг заавал мөрдөх журамдаа оруулаад заачихсан байдаг юм.

Тийм учраас энэ ажлыг хийнэ. Яах вэ ерөнхийдөө бол Монголын үхэр сүргийг ээмэгжүүлэхэд 10, 11 тэрбум, ажлын хөлстэйгөө 10 тэрбум л орох юм л гэдгийг хэлчихсэн чинь тэрийг сэвээд явчихсан байхгүй юу.

Цаашидаа бол бид нарын энийг зайлигүй хийх ёстой. Бусад малаа больё. Хуучин социализмын үед хонь хүртэл чихэндээ ээмэгтэй, бүртгэлтэй байсан шүү дээ. Бүгд мэдэж байгаа.

Тэгэхээр бол малыг эрүүл байлгах нэг үндэс нь бол энэ бүртгэлжүүлж хөтлөх, бүртгэл хөтөлж нэгдсэн сан бүрдүүлэх явдал юм. Наад зах нь энэ Хэнтий аймаг Хэрлэн, Баян-Улаан дээр гэхэд 10 аймгийн 500 гаруй мал энэ жил өвөлжлөө. Отор нь нүүдлээр ирж. Хэрэв ийм бүртгэлтэй, эмэгтэй байвал нөгөө өвчин гарсан сум газраас ирсэн үү, үгүй юу гэдэг нь хүртэл тодорхой болох байхгүй юу. Тэх, энэ бүртгэл байхгүй, хяналт байхгүйгээс болж малын өвчин бас гарч байгаа, тархаж байгаа, хяналтгүй байгаа нэг хэлбэр гэж хэлж болно.

Тэгэхээр цаашидаа бол энэ индексийг нь мөрдүүлэх, коджуулах, өөрөөр хэлбэл ээмэгжүүлэх ажлыг ялангуяа үхэр сүрэг дээр бид хийнэ гэдгийг хэлэх байна.

Н.Ганибал: Бүртгэлжүүлэлтийн асуудал бол мэдээж экспортын гол гарал үүслийг тодорхой болгох, мөрдөн мөшгөх гол асуудал мөн л дөө. Тэгэхдээ хамгийн гол нь асуугаад байгаа нь яг энэ цаг хугацаанд Засгийн газар нь үхрийн махны экспортыг хорьчихсон байгаа шүү дээ тодорхой хэмжээнд квот өгөөд. Тэгээд бүх малаа бид нар ямар экспортод гаргачхаж байгаа биш. Гол асуудал нь бүртгэлжүүлэлтийн нөгөө систем чинь ажиллаж байгаа юм уу? Сум болгон дээр мал эмнэлэг үржлийн тасаг, түүнтэй холбогддог бүртгэлийн мэргэжилтнүүд түүнийгээ кодолдог кодууд энэ болгон маань өнөөдөр яг ажиллаж байгаа юу гэдэг л асуудал нь яригдаад байгаа л даа.

Тэгээд тэрийг заавал нөгөө хамгийн сүүлийнх нь ажлыг нь хийгээд байгаа байхгүй юу. Шууд ээмэг аваачаад чихэнд нь хийж. Нөгөө систем нь ажиллаж байгаа, үгүй нь тодорхойгүй. Дээрээс нь өнөөдөр тэрийг хийснээрээ дараагийн юу гэдэг юм 10 жил дэх ажлын эхлэлийг л тавих гээд байна л гэж ойлгож байна л даа. Тэгэхээр энэ л асуудлынх нь мөн чанар нь хамгийн чухал нь ээмэг нь мөн юм уу л гэдэг л асуудлыг л яриад байгаа юм байна лээ.

Дараагийн асуулт малын хорогдол 500000 хүрчихлээ. Энэ жил ер нь тэгээд энэ тоо жоохон өсөх юм шиг байна. Мэдээж хавар урт. Малын индексжүүлсэн даатгалын систем маань өнөөдөр Монголын мал аж ахуйн салбарт яг ажиллаж байна уу? Өнөөдөр малын индексжүүлсэн даатгалд малаа даатгуулсан хүмүүс малчид маань малын хорогдолтой тэгээд даатгалын нөхөн олговор авна гэсэн хүлээлттэй байгаа. Энэ талаар яам ер нь судалгаа хийв үү? Өөр даатгалын систем Монголын мал аж ахуйн салбар, газар тариалангийн салбарт ажиллах нөхцөл, боломж байдаг юм болов уу гэдэг талаас асууя.

Х.Болорчулуун: Хариулчихъя. Ганибал гишүүн нэг юун дээр мэдээлэл дутуу байна л даа. Манай яамны Мал аж ахуйн газрын доор Цахим мэдээллийн хэлтэс гэж байгаа. Энд бол малын цахим бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бий болсон. Энэ бол бүх аймаг сумын малыг бүртгэх ийм мэдээллийн сан, бааз нь бий болчихсон байгаа юм. Тийм учраас энэ бүртгэлжүүлэх, кодлох, ээмэгжүүлэх ажлаа хийх гээд байгаа юм.

Хоёрдугаарт, энэ сум болгонд малын эм,ч зоо техник ажиллаж байгаа мал аж ахуйн мэргэжилтэн эд нарыгаа бид нар бас ялангуяа энэ мал эмнэлгийн дэглэм бүхий эрүүл бүсүүд энэ хэрэгжүүлэх гэж байгаа бүртгэл мэдээллийн сан бий болгож ажиллах гэж байгаа газрууд дээрээ бол бас компьютержуулах ажлыг бас давхар явуулна гэдгийг бас хэлье.

Тэгэхээр бид олон улсын хийж байгаа, чадаж байгаа юмыг Монголд хийх л ёстой байхгүй юу. Тэрнээс биш үндсэндээ үхрийн мах гадагшаа аль ч ус авахгүй, харин Хятад руу л хагас чанаад л гаргаж байгаа болохоос биш 2 орны нөхцөл байдалд тохироод. Өөр улсууд руу гарч чадахгүй. Орос руу, бусад улс руу. Яагаад гэвэл үхэр чинь өөрөө бүр онцгой 30, 40 төрлийн шимэгч агуулдаг. Ийм онцгой бас нэг халдвар тээгч гэсэн

амьтны бас ангилалд ордог юм. Махыг нь сайн чанаж л болгох хэрэглэхгүй бол.

Тийм болохоор үхрийн махыг үнэ цэнтэй байлгах, гадагшаа экспортод гаргахад зайлшгүй олон улсын жишигээр л эрүүл бүс байгуулж, малаа эрүүлжүүлж гаргахаас өөр арга зам байхгүй. Жишээ нь манайхаас хүн ам адилхан ойролцоо Уругвай улс гэхэд 13 сая үхэртэй. Энийгээ бүгдийг нь бүртгэл мэдээллийн сандаа бүртгээд, өөрөөр хэлбэл ээмэгжүүлээд ингээд дэлхийд эхний 5 дотор орох экспортлогч орон болчихсон. Мал экспортлогч орон.

Ялангуяа амьд үхэр ч экспортолно, үхрийн мах экспортолно. 75 хувийг нь улсаас эхэлж зардал гаргасан юм байна билээ. 25 хувийг нь хувийн компани тэр мал аж ахуй эрхлэгч нар гаргасан. Цаашидаа бол мэдээж тэр ээмэг, бүртгэлийнхээ мөнгийг бол хувийнхан гаргаад явна. Ингэж яг нэгдсэн санг улсаас дэмжиж бүрдүүлдэг юм. Үнийн жишигээр манай улс бас ажиллана. Бид бол 50 хувийг нь ээмэгжүүлээд бүртгэл мэдээллийнхээ 50 хувийг нь улсаас хангана, 50 хувийг нь малчдаас гаргахаар ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Н.Ганибал: Мал аж ахуйн асуудал яривал одоо зовлон их байна. Малын өвчин өнөөдөр бид нар шүлхий өвчин бараг Монголын малын бараг брэнд болтол нь манай мал эмнэлгийн салбар авч явж байна шүү дээ. Цаашидаа арьс товруутах гээд бараг нутгийн өвчин болтол нь хадгалж авч үлдэж байна шүү дээ. Тэгээд мал эмнэлгийн салбар дээр бид нар хуулийг нь өөрчилсөн, тогтолцоог нь өөрчилсөн. Явдаггүй дээ. Тэгээд вакцин тариад л байдаг, тариад байдаг. Энэ олон асуудлын ард гарах тийм шийдвэртэй бодлогын асуудлууд бид нарт хэрэгтэй байна.

Ер нь бид нарын хамгийн чухал асуудал бол малчид орлоготой л байлгах ёстой. Орлоготой малчин заавал төрөөс тэр вакцин хийлгээд байхгүй өөрөө

худалдаж аваад хийчихнэ. Орлоготой малчин заавал тэр төрийн өвсний фонд нөөц гээд 2 хоног юу гэдэг юм 1 айлд 2, 3 боодол өвс л өгч байгаа шүү дээ. 200, 300-аар нь худалдаад аваад өвөлжсөөн дээрээ тавьчих орлоготой л болох ёстой. Сая тэр ноолуурын асуудал, малчдын ноолуурын үнийг буулгах гэж байсан шүү дээ. Бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ.

Одоо энэ нөөцийн мах дандаа л махных нь үнийг нь тогтоож өгөөд, дээд хязгаараа тогтоочихдог. Улаанбаатар хотын тэр худалдан авах тэр чадварыг нэмэгдүүл л дээ тэр хүмүүсийн цалин орлогыг нь нэмэгдүүл. Заавал хэн нэгний хийсэн бүтээгдэхүүний үнийг тэр дэлхийн зах зээлийнх нь бодит үнээс нь доогуур үнээр худалдаж авах гэсэн зорилт тавиад ийм төрийн бодлого гэж юу байх вэ дээ. Үнэхээр л үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлэх гэж байгаа бол, жижиг, дунд үйлдвэрлэлээ хөгжүүлэх гэж байгаа бол энэ үйлдвэрлэл хөгжүүл, орлогоо нэмэгдүүл.

Газар тариалан дээр бид нар 30 жил явлаа. Одоо бодлогоо өөрчлөхгүй бол болохоо байчихсан гэдгийг чинь бүгд зарлаад байна шүү дээ. Улаан буудайны үнийг тогтоогоод яах юм бэ. Тэр чинь зарим жил шатахууны үнэ өөр л байна. Энэ жил тэр таримал тэжээлийн боодлын үнэ өрийн өртөг нь бараг 7000-аар гарч байгаа юм шиг байна лээ шүү дээ. Тэгээд зах зээлийнх нь жсамаар борлуулалтын юундаа орж ирэхээр 10 гараад явчихсан тээвэр ороод ирэнгүүт. Өвс хадлан тэжээлийн хамгийн чухал хэцүү юм нь бүх өртөг нь тээвэртээ шингээд байдаг. Тэгээд тэр 20000 руу яваад байдаг.

Тэгэхээр энэ бүх энэ асуудлуудыг нэгдсэн ийм зураглалд оруулаад хаана төрийн хяналт, хаана тэр төрийн дарамт, хаана тэр төрийн оролцоо байна бүгдийг нь л байхгүй болгочих. Тэгвэл аандаа хөгжчихнө, аяндаа явчихна. Одоо тэр зээл өгнө гээд, 1 их наядын зээл өгнө гээд хүнсний хувьсгалын хүрээнд гээд.

Боломжтой нэг нь өнөөдөртөө авчихна. Барьцаа хөрөнгөтэйнүүд нь өнөөдөр авчихна. Өнөөдөр зээл авангуут нь тэрийг авч чадахгүй. Эсвэл маргааш төлөвлөж байгаанууд нь тэр зээлд хамрагдаж чадахгүй. Тэгээд нөгөө шударга бус байдал бий болно. Өрсөлдөөн шударга бус болчихно. Бид нар төр өөрөө энэ шударга бус өрсөлдөөнийг өөрсдөө бий болгоод байгаа юм.

Харин тэр Шударга бус өрсөлдөөний газар гээд газар энэ үнэ тогтоох гээд дайраад яваад байх юм. Энэ бас зөв юм уу, буруу юм уу? Энэ ямар учиртай юм? Өмнө нь нэг дарга байхдаа махны үнэ тогтооно гээд лангуун дээр очоод хэдэн лангуу түрээслэгч нарыг торгоод байсан. Одоо нэг нөхөр гурил.../минут дуусав./

Г.Занданшатар: Энэ асуулт, хариулт мэтгэлцээний зарчмаар 20 минут үргэлжлэх ёстой. Тэгээд ярьсаар байгаад тэгээд дуусгачихлаа. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Намын бүлгүүдийг төлөөлж томилогдсон гишүүд D-Parliament цахим сүлжээгээ. Шуурхай шуурхай асуулт, хариултаа. Мэтгэлцээний зарчмаар явж байх ёстой юм шүү цаашид. Яг ийм байдлаар явах ёстой байхгүй. Одоо цаг дууссан. Ингээд энэ асуулт, хариулт дууслаа. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

15.53 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

